

**ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ ГАДААДЫН
ОРНУУДЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ТҮҮНД
ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Г.Гантөмөр

Хууль сахиулахын их сургуулийн эрдэмтэн нарийн
бичгийн дарга, доктор (Ph.D), дэд профессор

О.Амарсайхан

Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын
удирдлагын академийн Цагдаагийн удирдлага,
стратегийн профессоровын багийн, дэд профессор,
цагдаагийн дэд хурандаа

Монгол улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацааны нэг төрөл нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа юм.

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх хугацаа нь зөвхөн материаллаг эрх зүй болох эрүүгийн эрх зүйд төдийгүй эрүүгийн процессын эрх зүйд онолын болон практик ач холбогдол бүхий ойлголт, судлагдхуун, институт мөн.

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны үндэсний эрх зүйн зохицуулалтын асуудал манай улсын эрүүгийн эрх зүйд сурах бичиг, нэг сэдэвт бүтээлийн хүрээнд харьцангуй судлагдсан¹ боловч уг асуудлыг гадаадын орнуудын Эрүүгийн хуульд хуульчилагдсан байдлыг тусгайлан судалсан бүтээл одоогоор байхгүй байна.

Мөн УИХ-аар 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж буй энэ цаг үед хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг боловсронгуй болгох зорилгоор гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гадаадын зарим орнуудын Эрүүгийн хуульд хуульчилсан байдлыг харьцуулсан эрх зүйн үүднээс судлах хэрэгцээ, шаардлага илүүтэй тавигдаж байгаа билээ.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд өөр өөр эрх зүйн бүлийн төлөөлөл болгон 30 гаруй орны эрүүгийн хууль тогтоомжийг судалсан бөгөөд үр дүнг дараахь байдлаар тоймлон авч үзэж байна. Үүнд:

1.Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хууль тогтоомжид хуульчилсан байдал. Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг өөр өөрийн онцлогтойгоор холбогдох хууль тогтоомжид хуульчилсан ба хэрхэн хуульчилсан байдлаас нь хамааран хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульдаа хуульчилсан, Эрүүгийн процессын хуульдаа хуульчилсан гэж ангилж болохоор байна.

¹Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. Ерөнхий анги. УБ.1973 он, С.Нарангэрэл. Монгол улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ. 1999 он, С.Жанцан. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол. II боть. Ялын тухай сургаал. УБ.2014 он, Г.Гантөмөр, О.Амарсайхан. Монгол улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа. УБ.2004 он.

Ихэнх орнууд /Азербайджан, Армен, Украин, Беларусь, Молдов, Казакстан, Кыргызстан, Узбекистан, Гүрж, Тажикстан, Туркменистан, ОХУ, БНХАУ, Монгол, Тайланд, Австри, Болгар, Польш, ХБНГУ, Голланд, Швед, Швейцари, Турк, Аргентин/ гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульдаа зааж өгчээ.

Эдгээрээс ОХУ болон ТТУХН-ийн гишүүн дийлэнх улсууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн “Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх”, Аргентин улс “Эрүүгийн хариуцлага /ял/ хүлээлгэж болохгүй байдал”, Болгар, Голланд, Дани, Турк улсууд “Гэмт хэргийн үр дагавар арилах” гэсэн бүлэгт хуульчилсан бол Австри, Герман, Польш, Швейцари, Тайланд улс “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн бие даасан бүлэгт шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх хугацааны хамт хуульчилсаны зэрэгцээ, хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх гэмт хэргүүд, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журмыг нарийвчлан зааж өгсөн нь илүү оновчтой зохицуулалт болсон гэж үзэж байна.

Харин Франц, Бельги, Израйль, Япон, Солонгос зэрэг орнууд хэргийн хөөн хэлэлцэх /эрүүгийн хариуцлагад татах/ хугацааг Эрүүгийн хуульд зааж өгөөгүй, эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны өөр нэг төрөл болох шүүхийн шийтгэх тогтоолын хөөн хэлэлцэх хугацааг зааж өгсөн нь ихээхэн анхаарал татаж байна. Дээрх орнуудад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн журмаар мөрдөн шалгах /мөшгих/ хугацаа хэмээн тодорхойлж, түүнийг процессын агуулгаар нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тодорхойлжээ. Тухайлбал: Япон улсын ЭБШХ-ийн 2 дугаар хэсгийн “Прокурор яллах” гэсэн 2 дугаар бүлгийн 250 дугаар зүйлд “...Цаазаар авах ялтай хүн амины хэргээс бусад хэрэг үйлдсэнээс хойш дараахь хугацаа өнгөрсөн бол яллагдагчаар татаж болохгүй. Үүнд:

1. Цаазаар авах ялтай бусад гэмт хэрэг үйлдсэнээс хойш 30 жил,
2. Хугацаагүйгээр хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 25 жил,
3. 15 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил,
4. 15 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш 7 жил,
5. 10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил,
6. 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх гэмт хэрэг үйлдсэнээс хойш 3 жил,
7. баривчлах, торгох ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэнээс хойш 1 жил өнгөрсөн бол...”² гэж заасан байна.

Англи-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульд бус, процессын хуульд заадаг нь уг эрх зүйн бүлийн жишиг юм. Бидэнд биетээр байгаа Австралийн Холбооны улсын Эрүүгийн хууль, АНУ-ын Техас муж улсын Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг заасан хэм хэмжээ байхгүй.

²www.http://law.e-gov.go.jp/htmldata-S23/S23HO131.html

Харин АНУ-ын зарим муж улсын хууль тогтоомжид мисдиминор ангиллын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 2 жил байхаар заасан тухай энэ чиглэлээр гарсан зарим бүтээлд дурьджээ³.

Мусульманы шашинт орнуудын Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зааж өгөөгүй ба энэ нь Мусульманы шашны ариун, үнэт зүйлд халдсан ноцтой гэмт хэрэг, ялангуяа худуд, тазир ангиллын хэрэг нь хэзээ үйлдсэнээс үл хамаарч нүгэл, муу зан үйлд тооцогддогтой холбоотой. Харин зарим оронд /Сири, Йордани/ зөвхөн шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх хугацаа буюу ялыг эдлүүлэх хугацааг заасан байдаг.⁴

2. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлсон нэр томъёо. Судалгаанд хамрагдсан орнуудын Эрүүгийн хуульд судалж буй ойлголт, ухагдахууныг хуульчлахдаа өөр өөр нэр томъёо хэрэглэсэн байна. Хуучнаар ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан болон социалист системийн орнуудад хамаарч байсан ихэнх улсуудын Эрүүгийн хуульд “хэргийн хөөн хэлэлцэх хугацаа”, “эрүүгийн хариуцлагад татах хугацаа”, “эрүүгийн хариуцлага хүлээлгэх хугацаа”, Литва, Швед улсад “ял оногдуулж болохгүй хугацаа”, Польш, Дани улсад “эрүүгийн хэргийн ял хүлээх үр дагавар арилах хугацаа” гэсэн материаллаг эрх зүйн үүднээс нэр томъёо хэрэглэсэн бол Ром-Германы эрх зүйн бүлийн зарим орнууд, тухайлбал: Голланд, Австри, Аргентин, Швейцари, Турк, Тайланд улсуудад процессын эрх зүйн утгаар “эрүүгийн журмаар мөрдөн шалгах хугацаа”, “эрүүгийн журмаар мөрдөн мөшгих хугацаа”, Япон улсад “яллагдагчаар татаж болохгүй хугацаа” гэсэн нэр томъёогоор хууль тогтоомждоо тодорхойлсон байдаг.

3. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо баримталсан шалгуур, үндэслэл.

Судалгаанд хамрагдсан орнууд хэргийн хөөн хэлэлцэх тогтоохдоо

а. Гэмт хэргийн ангилал

б. Гэмт хэргийн төрөл /хэргийн өнгө/

в. Гэм буруугийн хэлбэр

г. Гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан ялын төрөл

д. Гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан тодорхой ялын хэмжээ гэсэн 5 шалгуурыг харгалзан тогтоосон нь харагдаж байна.

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн гэмт хэргийн ангиллыг харгалзан тогтоосон орнууд. ОХУ болон ТТУХН-ийн гишүүн ихэнх орнуудын Эрүүгийн хуульд⁵ хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн 4 ангиллыг шалгуур болгон хуульчилсан юм. Үүний учир нь 1995 онд батлагдсан ТТУХН-ийн гишүүн орнуудын “Эрүүгийн загвар хууль”-ийн 77 дугаар зүйлд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дээрх шалгуураар хуульчилсан зөвлөмжийг баримтлан гишүүн орнууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ижил төстэй байдлаар хуульчилсан байдагт оршино. Тухайлбал: ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 78 дугаар зүйлд “...Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дор дурьдсан хугацаа өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

а. Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 2 жил

³В.Н.Додонов. Сравнительное уголовное право. Учебник. изд. Юрлитинформ. М. 2009 стр 392

⁴Г.Ф.Елаян. Основы мусульманского уголовного права. Учебное пособие. Махачкала. 2002 г. стр 72-73

⁵Литва, Эстони, Гүрж улсыг эс тооцвол. Зохиогч

- б. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш 6 жил
- в. Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил
- г. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн бол...” гэж заажээ⁶. Харин Молдов улсын Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлд
 - а. Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 2 жил
 - б. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил,
 - в. Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил
 - г. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил
 - д. Туйлын /онцгой/ хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 25 жил өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэж заажээ.⁷

Мөн ТТУХН-ийн гишүүн бус ч хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо гэмт хэргийн ангиллыг шалгуур болгосон бусад орнууд бий. Жишээ нь: Эстони улсын Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлд “...Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дор дурьдсан хугацаа өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй...” гээд хөөн хэлэлцэх хугацааг:

- а. Гуравдугаар зэрэглэлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 2 жил өнгөрсөн,
- б. Хоёрдугаар зэрэглэлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 5 жил өнгөрсөн.
- в. Нэгдүгээр зэрэглэлийн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн бол гэж заасан байдаг.⁸

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуулийн тусгай ангид оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээнээс хамаарч хуульчилсан орнууд: Ийм орнуудад Австри, Аргентин, Болгар, Герман, Дани, Швейцари, Турк, Тайланд, Хятад, Япон зэрэг улс хамаарна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн V хэсгийн “Эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн 1 дүгээр бүлгийн 78 дугаар зүйлд:

1. Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 30 жил өнгөрсөн,
2. Арваас дээш жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн,
3. Таваас доошгүй арван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн,
4. Нэгээс доошгүй таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн,
5. Нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу бусад төрлийн ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 3 жил өнгөрсөн бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байхаар тогтоожээ.⁹

Тайландын Вант Улсын Эрүүгийн хуулийн “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн 9 дүгээр бүлгийн 95 дугаар зүйлд зааснаар

1. Цаазаар авах, бүх насаар нь хорих болон хорин жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн,

⁶Уголовный кодекс Российской Федерации / по состоянию на 01.09.1916 года/. М. Изд.Прспект.2014 г.

⁷Молдов улсын Эрүүгийн хуулийн 16-р зүйлд зааснаар гэмт хэргийг нийгмийн хор аюулын шинжээр 5 зэрэглэлд ангилдаг. Уголовный кодекс Республики Молдова. г.Кишинев. 2003 г. стр 6

⁸Уголовный кодекс Эстонской Республики. Изд Юридический Центр Пресс. СПб. 2001г. стр 34

⁹Уголовный кодекс ФРГ. Изд МГУ.М.1996г. стр 60.

2. Долоогоос дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн,

3. Нэгээс жилээс дээш долоон жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн,

4. Нэг сараас дээш нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн,

5. Нэг сар хүртэл хугацаагаар хорих эсхүл өөр төрлийн ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 1 жил өнгөрсөн бол эрүүгийн журмаар мөрдөн шалгахгүй, шүүхэд татагдахгүй¹⁰.

Мөн манай урьд хөрш БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг тухайн хэрэгт тусгай ангид оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээнээс хамааран:

а/ 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн,

б/ 5-10 жилийн хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн,

в/ 10 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн,

г/ Хугацаагүй хорих ял, цаазаар авах шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн байхаар тогтоосон юм.¹¹

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг заахдаа холимог шалгуурыг хэрэглэсэн орнууд: Ийм орнууд нь хэргийн хөөн хэлцэх хугацааг дээр дурьдсан гэмт хэргийн ангилал, гэмт хэргийн төрөл /хэргийн өнгө/, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээ зэрэг 2-3 шалгууруудыг үндэслэн тогтоосон байх ба Литва, Гүрж, Польш, Голланд зэрэг орнуудыг нэрлэж болно. Тухайлбал: Голланд улсын Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлд эрүүгийн журмаар мөрдөн шалгах хугацааг заасан ба дор дурьдсан хугацаа өнгөрсөн бол мөрдөн шалгаж болохгүй.

а/ Эрүүгийн зөрчил үйлдсэн бол 2 жил өнгөрсөн,

б/ Торгох ял болон 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 6 жил өнгөрсөн,

в/ 3-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 12 жил өнгөрсөн,

г/ 10 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн,

д/ Бүх насаар нь хорих ял шийтгэхээр заасан хэрэг үйлдсэнээс хойш 18 жил өнгөрсөн бол гэж зааснаас үзэхэд гэмт хэргийн ангилал¹², гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээг шалгуур болгосон нь харагдаж байна.

Мөн Литва улсын Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйлд:

а/ Эрүүгийн зөрчил үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн,

б/ Болгоомжгүй гэмт хэрэг, эсхүл хөнгөн болон хүндэвтэр гэмт хэргийг санаатай үйлдсэнээс хойш 4 жил өнгөрсөн,

в/ Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 8 жил өнгөрсөн,

¹⁰Уголовный кодекс Тайланда. Изд Юридический Центр Пресс.СПб.2005 г. стр 68-69

¹¹Уголовный кодекс КНР. Изд Юридический Центр Пресс.СПб.2001 г. стр 52-53

¹²Голланд удсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэгийг эрүүгийн зөрчил, гэмт хэрэг гэж хоёр ангилдаг. Уголовный кодекс Голландии. Изд Юридический Центр Пресс.СПб.2001г. стр 190-191

г/ Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 12 жил өнгөрсөн,

д/ Хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил өнгөрсөн бол ял оногдуулж болохгүй...” гэж хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахдаа гэмт хэргийн ангилал, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийн төрөл гэсэн 3 шалгуурыг удирдлага болгожээ¹³.

4. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны төрөл, хэмжээг тогтоосон байдал.

Гадаадын улс орнууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахдаа төрөл, түүний доод, дээд хэмжээг харилцан адилгүй хуульчилсаныг харж болно.

ОХУ болон ТГУХН-ийн гишүүн зарим орнууд, Хятад, Монгол, Дани улс гэмт хэргийн ангиллаас хамааран хөөн хэлэлцэх 4 төрлийн хугацааг заасан бол Австри, Аргентин, Болгар, Герман, Голланд, Польш, Литва, Молдов, Тайланд 5, Итали, Турк - 6, Эстони, Швейцарь хамгийн цөөн буюу 3, Испани, Сан-Марино, Япон хамгийн олон буюу 7 хугацааг зааж өгчээ.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хэмжээг /доод ба дээд хэмжээг/ заасан байдлыг авч үзвэл Латви 6 сараас 15 жил, Туркэд 6 сараас 25 жил, Австри, Испани, Тайланд 1 жилээс 20 жил, Эстони 5 жилээс 10 жил, Аргентин, Армен, Беларусь, Дани, Казакстан, Кыргызстан, Литва, ОХУ, Украин, Тажикстан, Туркменистан 2 жилээс 15 жил, Голланд 2 жилээс 18 жил, Швейцари, Хятад 2 жилээс 20 жил, Молдов, Норвеги, Гүрж, Швед 2 жилээс 25 жил, Польш 1 жилээс 30 жил, Герман 3 жилээс 30 жил, Болгар 2 жилээс 35 жил гэх мэтээр тогтоосон байх ба дунджаар авч үзвэл доод хэмжээ нь хэмжээ 2 жил, дээд хэмжээ нь 15-20 жил байна.

5. Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх нөхцөл /хэргүүд/.

Судалгаанд хамрагдсан орнууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахдаа хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй тохиолдол, гэмт хэргүүдийг харилцан адилгүй зааж өгчээ.

1968 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр НҮБ-аас баталсан “Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай” конвенци, 1974 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Хүн төрөлхтний эсрэг болон цэргийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тухай Европын конвенци, 1998 оны “Олон улсын Эрүүгийн шүүхийн /Ромын/ дүрэм”-ийг соёрхон баталсан, нэгдэн орсон улс орнууд энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй тухай заалтыг үндэсний хууль тогтоомжид хуульчилжээ. Ийм зохицуулалт Беларусь улсын Эрүүгийн хуульд бие даасан зүйл буюу 85 дугаар зүйлд, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Молдов улсын Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Кыргызстан улсын Эрүүгийн хуулийн 67 дугаар зүйлийн 5 дахь хэсэг¹⁴, Болгар улсын Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт бий.

Зарим орны Эрүүгийн хуульд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхүй байх ердийн эрүүгийн хэргийг заасан нь манай улсын эрүүгийн эрх зүйд судалж үзэх туршлага байж болох талтай. Тухайлбал: Япон улсын ЭБШХ-ийн 250 дугаар зүйлд цаазаар авах ялтай хүн амины хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй¹⁵, Австри улсын Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлд бүх насаар нь хорих ял шийтгэхээр заасан хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй¹⁶ байхаар заажээ.

¹³Уголовный кодекс Литовской Республики. Изд Юридический Центр Пресс.СПб.2002 г. стр 19

¹⁴Уголовный кодекс Кыргызской Республики. Бишкек. 2003 г.

¹⁵ www.http://law.e-gov.go.jp/htmldata-S23/S23HO131.html

¹⁶Уголовный кодекс Австрии. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2004 г. стр 108

Түүнчлэн цаазаар авах болон бүх насаар нь хорих ялтай хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх, зарим оронд прокурор шийдвэрлэх талаар заасан орнууд /Азербайджан, Армен, Гүрж, ОХУ, Казакстан, Кыргызстан, Латви, Монгол, Молдов, Узбекистан, Хятад/ байна. Тухайлбал: Латви улсын Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...энэ зүйлийн 1.5-д заасан цаазаар авах, бүх насаар нь хорих ял шийтгэхээр заасан хэрэг үйлдсэнээс хойш 30 жил өнгөрсөн бол хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй гэж үзвэл цаазаар авах ялыг хорих ялаар солино...”¹⁷ гэж заасан нь манай улсын Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ойролцоо юм.

Мөн Гүрж улсын Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт хугацаагүй хорих ял шийтгэхээр заасан хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв хөөн хэлэлцэх хугацааг шүүх хэрэглэхгүй гэж үзвэл хугацаагүй хорих ялыг хугацаатай хорих ялаар солино гэж заасан байна¹⁸.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар цаазаар авах болон бүх насаар нь хорих ялтай гэмт хэрэг үйлдсэнээс хойш 20 жил өнгөрсөн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг Бүх Хятадын Ерөнхий Прокурор шийдвэрлэдэг.¹⁹

6. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам. Эрүүгийн эрх зүйд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг онолын хүрээнд төдийгүй хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлдог. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам гэдэг ойлголтод хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэх, хөөн хэлэлцэх хугацааг зогсоох, үргэлжлүүлэн тоолох, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолох, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусах зэрэг ойлголтууд хамаарах бөгөөд улс орнууд тэдгээрийг өөр өөрийн гэсэн онцлогтойгоор эрүүгийн хууль тогтоомждоо хуульчилсан байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ямар хугацааны дотор /эхлэх, дуусах/ тоолох онцлог.

Австри, Болгар, Герман, Латви, Дани, Норвег, Испани, Польш, Турк, Швед, Швейцари, Эстони зэрэг улсад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эрүүгийн журмаар мөрдөн шалгах өдөр хүртэл, Голланд улсад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэний дараа маргааш өдрөөс эрүүгийн журмаар мөрдөн шалгах өдөр хүртэл тоолдог бол Тайландын Вант Улсад хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хэргийг /хэрэгтнийг/ шүүхэд шилжүүлэх хүртэл, Японд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс прокурор хэргийг яллах хүртэл, Кыргызстан, Турк, Литва улсад гэмт хэрэг үйлдсэн өдрөөс шүүхийн шийтгэх тогтоол гаргах хүртэл тоолдог онцлогтой.

Харин ОХУ болон ТТУХН-ийн гишүүн зарим орнуудын хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт этгээдэд ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл тоолно. Ийм зохицуулалт ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт байдаг нь манай улсын Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ижил байна.

¹⁷Уголовный кодекс Республики Латвии. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2002 г. стр 19

¹⁸Уголовный кодекс Грузии. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2002 г. стр 134

¹⁹Уголовный кодекс КНР. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2004 г. стр 53

Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зогсох, сэргээн тоолох, тасрах, шинээр тоолох онцлог.

Болгар улсын Эрүүгийн хуулийн 81 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...эрх бүхий байгууллагаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийг мөрдөн шалгах зорилгоор тодорхой ажиллагаа явуулсанаар, Швейцари улсын Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйл, Турк улсын Эрүүгийн хуулийн 104 дүгээр зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоологдож эхэлсэн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа сэжигтэн, яллагдагчийг мөрдөн шалгах зорилгоор процессын ямар нэг ажиллагаа /хуулийн байгууллагаас зарлан дуудах хуудас явуулах, баривчлах, түр саатуулах, үзлэг, нэгжлэг хийх, байцаах, эрүүгийн хэрэг үүсгэх г.м/ явуулсанаар, Гүрж улсын Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг яллагдагчаар татсанаар, Испани улсын Эрүүгийн хуулийн 132 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэснээр, Голланд улсын Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг мөрдөн шалгаж эхэлсэн тухай эрх бүхий байгууллагаас түүнд мэдэгдсэнээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох ба энэ ажиллагаанууд дуусахад уг хугацааг үргэлжлүүлэн тоолно.

Харин ОХУ /Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/, Казахстан /Эрүүгийн хуулийн 69 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг/, Кыргызстан /Эрүүгийн хуулийн 67 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/, Хятад /Эрүүгийн хуулийн 88 дугаар зүйл/, Молдов /Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 5 дахь хэсэг/ зэрэг улсад хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхэлснээс хойш гэмт этгээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс орговол хөөн хэлэлцэх хугацаа зогсох бөгөөд уг этгээд өөрөө сайн дураар хуулийн байгууллагад хэргээ илчлэн ирэх, эсхүл түүнийг хуулийн байгууллагаас эрэн сурвалжилж баривчлах, саатуулах үеэс уг хугацааг үргэлжлүүлэн /сэргээн/ тоолохоор заасан нь манай улсын Эрүүгийн хуулийн зохицуулалттай үндсэндээ ижил байна.

Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолохтой холбоотой зохицуулалт гадаадын зарим орнуудын Эрүүгийн хуульд байгааг үндэсний Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг боловсронгуй болгоход анхаарах нь зүйтэй гэж судалчийн хувьд үзэж байна.

Зарим орнуудын хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, сэргээн тоолоход гэмт этгээдийн эхний болон дараагийн үйлдсэн гэмт хэргийн ангилал, төрөл, ялын хэмжээ ач холбогдол үзүүлдгийг судалгаа харууллаа.

Украин, Латви, Литва, Эстони, Молдов, Хятад зэрэг орны Эрүүгийн хуульд өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад /тоологдож байхад/ шинээр гэмт хэрэг үйлдвэл сүүлийн үйлдсэн хэргийн ангилал, төрөл, гэм буруугийн хэлбэр, оногдуулах ялын хэмжээ хамаарахгүйгээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах ба сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс уг хугацааг сэргээн тоолох журам үйчилдэг. Тухайлбал: БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлд “...хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор шинээр гэмт хэрэг үйлдвэл өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасарч, сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолно...” заасан байдаг.

Харин Кыргыз улсын Эрүүгийн хуулийн 67 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “...хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор шинээр санаатай гэмт хэрэг үйлдвэл өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасарч, сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолно...”, Молдов улсын Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор хоёр жил хүртэл хугацаагаар хорих оногдуулахаар заасан гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн

хэлэлцэх тухай тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг сүүлийн хэрэг үйлдсэн өдрөөс шинээр тоолох заалт байгаа нь манай өмнөх Эрүүгийн хууль буюу 1985 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зохицуулалттай ижил байна.

Мөн Армен улсын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх тухай тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг шинээр гэмт хэрэг үйлдсэн өдрөөс сэргээн тоолохоор заасан нь хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолоход сүүлийн үйлдсэн хэргийн ангилал, ялын төрөл нөлөөлж байгаагийн жишээ мөн.

Үүний эсрэг гэмээр зохицуулалт Казакстан улсын Эрүүгийн хуулийн 69 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт бий. Уг хэсэгт “...Хэрэв урьд нь хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор дахин шинээр гэмт хэрэг үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг сүүлийн үйлдсэн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс шинээр тоолно. Харин бусад гэмт хэрэг үйлдсэний дараа дахин шинээр гэмт хэрэг үйлдвэл хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрахгүй, хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зэрэгцэн тоологдоно...” гэж заасан нь тус улсын хууль тогтоогч хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тасрах, шинээр тоолоход эхний үйлдсэн гэмт хэргийн ангиллыг харгалзсаныг гэрчилж байна.

Зарим орнуудын /ОХУ, Азербайджан, Гүрж, Туркменистан/ хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа шинээр гэмт хэрэгт үйлдэхэд тасрах, сүүлийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс уг хугацааг сэргээн тоолох ойлголт байдаггүй, харин эхний гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоологдож байхад шинээр гэмт хэрэг үйлдвэл хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зэрэгцэн тус тусдаа тоологдох журам үйлчилнэ. Тухайлбал: Азербайджан улсын Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор гэмт хэрэг шинээр үйлдвэл хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тус тусдаа зэрэгцэн тоологдоно. ...”²⁰ гэж заажээ.

Дүгнэлт

1. Судалж буй асуудал болох гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гадаадын улс орнууд өөрийн эрх зүйн уламжлал, эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн түвшин, эрх зүйн бүлийн болон өөрийн орны онцлог зэргийг харгалзан харилцан адилгүй үндэсний эрүүгийн хууль тогтоомждоо хуульчилсан байна.

2. Гадаадын орнуудын эрүүгийн хууль тогтоомжид хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчилсан байдлыг харьцуулсан эрх зүйн хүрээнд судалж, авч үзэж буй судлагдахууны талаарх орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний хөгжил, эрх зүйн зохицуулалт, олон улсын жишиг, чиг хандлагыг тодорхойлвол хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн гэмт хэргийн ангиллаар бус гэмт хэргийн төрөл, гэм буруугийн хэлбэр, оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээ зэргийг харгалзан илүү олон төрөлтэйгээр, түүний доод, дээд хэмжээг харьцангуй доошлуулах замаар, хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг гэмт хэрэгтэнд илүү энэрэнгүй байдлаар ялгамжтайгаар хуульчлах чиг хандлага ажиглагдаж байна.

3. Гадаад орнуудын эрүүгийн хууль тогтоомжид хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсан эрх зүйн зохицуулалт, олон улсын жишиг, чиг хандлагыг тодорхойлж судлахгүйгээр үндэсний эрүүгийн хууль

²⁰Уголовный кодекс Республики Азербайджан. Изд. Юридический Центр Пресс.СПб. 2004 г. Стр 92

тогтоомжийг боловсронгуй болгох боломжгүй бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль болон УИХ-аар хэлэлцүүлж буй Эрүүгийн хуулийн шинэчлсэн найруулгад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах, санаа авахуйц, цаашдын судалгаанд анхаарахуйц онолын үзэл баримтлал, шинэлэг санаа, шийдэл цөөнгүй байгааг анхаарах хэрэгтэй юм.

Санал

1. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоох гол үндэслэл нь хуульд заасан хугацааны дотор гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах явдал бөгөөд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн үеэс анхан шатны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл тоолох нь зүйтэй гэж үздэг улс орнууд олон байгааг харгалзан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “яллагдагчаар татаж болохгүй” гэсэн нэр томъёог “эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй” гэж өөрчлөх, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэсэн заалтыг өөрчлөхгүй байх

2. Олон улсын жишиг, хандлагад нийцүүлэн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа шинээр гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тасрахгүй байх, хоёр гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тус тусдаа зэрэгцэн тоологдохоор хуульчлах зэрэг болно.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ш.Чулуун

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн АТБТ-ийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үйл ажиллагаанд цагдаагийн алба хаагч албадлагын аргаа хэмжээ хэрэглэхдээ гэмт этгээд, зөрчил гаргагчид хэрхэн ямар байдлаар хэрэглэх, ямар хууль эрхийн актыг мөрдөн ажиллах, нөгөө талаас НҮБ-ийн Ерөнхий Ассамблейгээс батлан гаргасан хүний эрх болон албадлага хэрэглэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг үйл ажиллагаанд хэрхэн ямар байдлаар баримтлан ажиллах, ач холбогдол, үр дүнгийн талаар өөрийн саналыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Эрх зүй, зохицуулалт, тусгай хэрэгсэл, хүч, албадлага

Цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг бол гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах явдал юм.

Энэхүү чиг үүргийг Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн²¹ гэж Цагдаагийн албаны тухай хуулинд тусгайлан зааж өгсөн байна.

Цагдаагийн алба хаагч нь албан үүргээ биелүүлэх явцдаа төрөл бүрийн нөхцөл байдалд өөрийн болон бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэнд хохирох аюултай тулгарч байдаг. Ийм үед цагдаагийн алба хаагчид хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд албадлагын арга хэмжээ хэрэглэх тусгайлсан эрх олгогдсон байдаг байна.

Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэгчийн идэвхтэй болон идэвхгүй байдлаар илэрхийлэх үйлдлийг хяналтандаа авах, саад хийх, таслан зогсоох зорилгоор хуулиар зөвшөөрсөн галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч болон бусад арга хэрэгсэл ашиглан санаатай хийж буй үйлдлийг албадлагын арга хэмжээ гэж нэрлэнэ.

Албадлагын арга хэмжээг дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

- Дээд/эцсийн/шатны арга хэмжээ буюу *галт зэвсэг хэрэглэх*
- Дунд шатны арга хэмжээ буюу *тусгай хэрэгсэл /аминд халгүй зэвсэг/ хэрэглэх*
- Доод шатны арга хэмжээ буюу *биеийн хүч /тусгай мэх/ хэрэглэх*

Дээрхи ангилалаас дүгнэж үзэхэд цагдаагийн алба хаагч нь гэмт этгээд, зөрчил гаргагчийн хууль бус үйлдлийг таслан зогсоохдоо боломжтой бүх тохиолдолд тухайн этгээдэд аль болох хамгийн бага хохирол учруулсан албадлагын арга хэмжээ хэрэглэхийг урьтал болгохыг анхааруулсан байна. Тухайлбал: Цагдаагийн алба хаагч албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ дараахь нийтлэг шаардлагыг баримтална²² гэжээ.

- Зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх
- Нэн тэргүүнд хэрэглэхгүй байх
- Тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх

Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагч нь гэмт этгээд, зөрчил гаргагчийн хууль бус үйлдлийг таслан зогсоохдоо аль болох бага хүчийг хэрэглэх нь нэг талаас тухайн этгээдийн амь нас, эрүүл мэндэд бага хохирол учруулах, нөгөө талаас алба хаагчийн албаны ёс зүй, мэргэжлийн ур чадвар, дадлыг илтгэн харуулах явдал юм.

Албадлагын арга хэмжээ хэрэглэх явдал нь хүний төрөлхөөс заяагдсан нэр төртэй байх, амьд явах, аюул заналхийллээс ангид, эрх чөлөөтэй байх эрхийг хөндөж байдаг.

Тиймээс хүн бүр хуулиар адил тэгш үндсэн дээр хамгаалуулах эрхтэйг санаж хүний эрх, эрх чөлөөг үргэлж хамгаалах, хүндэтгэх, хөхүүлэн дэмжих зарчмыг баримтлах нь зүй ёсны асуудал билээ.

Түүнчлэн Нэгдсэн Үндэсний Байгууллагаас батлан гаргасан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” болон бусад баримт бичиг, дотоодын “Үндсэн хууль” болон бусад холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүдэд тунхагласан хүний эрхийн талаар тодорхой мэдлэгтэй байх нь чухал алхам болох юм.

²¹ Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1 дэх хэсэг

²² Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 48-р зүйлийн 48.1 дэх хэсэг

Өнөөдөр цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулинд заасан үндэсэл журмын дагуу хүч хэрэглэхдээ галт зэвсэг хэрэглэхээс аль болох зайлсхийж тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэхийг чухалчлан авч үзэж байна.

Хөгжингүй болон өндөр хөгжилтэй орны цагдаагийн байгууллага албаны үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тусгай хэрэгслийг аминд халгүй зэвсэг гэж нэрлэдэг байна. Үүнийг тодруулбал:

Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хүн, амьтанд нөлөөлөх, хүний бие болон зэвсэг, техник хэрэгслийг чадамжгүй болгох зорилгоор бүтээгдсэн хэрэгслийг аминд халгүй зэвсэг гэнэ²³ гэж тодорхойлсон байна.

Олон улсын болон дотоодын хууль тогтоомжоор цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хэн нэгний буюу хэсэг бүлэг хүмүүсийн хууль бус үйлдэл, эсэргүүцлийг хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн тусгай хэрэгсэл хэрэглэн зогсоох боломжийг зохицуулсан байдаг.

Тусгай хэрэгсэл нь хүний амь насанд аюулгүй ангилалд багтах боловч хэрэглэх журам, зааврыг зөрчиж буюу хэтрүүлэн хэрэглэвэл хүний амь нас, эрүүл мэнд хохирно гэдгийг ямагт санах хэрэгтэй. Тиймээс тусгай хэрэгслийг тусгайлан боловсруулж баталсан журам, нарийн заавар, удирдамжийн дагуу хэрэглэх ёстой.²⁴

Галт зэвсэг, тусгай хэрэгслийг хууль тогтоомжид заасан журам, заавар болон үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу хэрэглэх бөгөөд үйлдвэрлэгчийн зааврыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын хавсралт болгож хэрэглэнэ²⁵.

Тусгай хэрэгсэл хэрэглэх нь нийгэмд сөрөг үр дагавар бий болгодогч аль ч нийгэмд хуулиар заасан нөхцөлд хэв журам, иргэдийн аюулгүй байдал, амь нас, эд хөрөнгө хамгаалах зорилгоор зөвшөөрдөг байна.

Түүнчлэн тусгай хэрэгсэл удирдах албан тушаалтны байнгын хяналтанд байж гагцхүү зайлшгүй шаардлагатай үед ашиглагдах ёстой. Тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө болон хэрэглэсний дараа нарийн бүртгэл хөтөлж хууль бусаар буюу хяналтгүйгээр, өөр зорилгоор ашиглах явдлаас зайлсхийх хэрэгтэй.

Тиймээс цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулинд: Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр албан хэрэгцээнд хүлээн авч бүртгэсэн тусгай хэрэгслийг хэрэглэнэ гэж заасан байна²⁶.

Цагдаагийн алба хаагч нь албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ дотоодын дараах эрх зүй актуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон баримталж ажиллана. Үүнд:

- Цагдаагийн албаны тухай хууль²⁷
- Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаал²⁸

²³“Аминд халгүй зэвсэг-2010” АНУ-ын сургагч багш нарын сургалт

²⁴НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд 1 дүгээр зүйл, 1990 он

²⁵Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 47-р зүйлийн 47.3, 47.4 дэх хэсэг

²⁶Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 17-р зүйлийн 17.5 дахь хэсэг

²⁷Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 47-58-р зүйл

²⁸Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар” 2017.09.06.

Мөн Монгол улс нь Нэгдсэн Үндэсний Байгууллагад гишүүн улсаар нэгдэн орсон тул түүнээс гарсан олон улсын гэрээ, конвенц буюу эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөхөөр тусгасан байдаг.

Энэхүү ажлын хүрээнд цагдаагийн байгууллага албадлагын арга хэмжээ хэрэглэхтэй холбоотой дараах эрх зүйн баримт бичиг, конвенцыг албаны үйл ажиллагаандаа баримтлан ажилавал зохино. Үүнд:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал²⁹
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт³⁰
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжилон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц³¹
- Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд³²
- Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль³³

Дээр дурдсан дотоодын болон олон улсын хууль тогтоомж, эрх зүйн актыг албаны үйл ажиллагаандаа нэг мөр баримталж ажилласнаар цагдаагийн байгууллага, алба хаагч нь албадлагын арга хэмжээ хэрэглэх болон хүний эрхийг хангахтай холбоотой аливаа сөрөг асуудал, хүндрэл бэрхшээл гарахад түүнийг хэрхэн ямар журмаар шийдвэрлэх, мөн алба хаагчийн хувийн аюулгүй байдал, эрх зүйн баталгааг нь хангахад чухал, үр дүнтэй арга хэмжээ болох юм.

2013 онд баталсан Цагдаагийн албаны тухай хуулийг 2017 онд шинэчлэн найруулж “Цагдаагийн албаны тухай” хуульд албадлагын арга хэмжээ хэрэглэх гэсэн нэршилтэйгээр дахин баталсан бөгөөд тус хуульд нийцүүлэн цагдаагийн байгууллага нь үндсэн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус хуулинд албадлагын арга хэмжээ хэрэглэх тусгайлсан бүлэг, зүйл, заалтууд шинээр тусгагдсан онцлог бөгөөд цагдаагийн алба хаагчийн эрх зүйн баталгааг хангахад чухал ач холбогдол бүхий нөхцлийг бий болгосон байна. Үүнийг задалж харуулбал:

Цагдаагийн албаны тухай шинэчилсэн хуулийг цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаандаа баримтлан ажилласантай холбогдуулан 2014 оны Хууль зүйн сайдын А/126 тоот тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар” нь хүчингүй болсон бөгөөд улмаар Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан А-224/А-102 тоот хамтарсан тушаал³⁴-ыг мөрдөн ажиллаж байна.

Тус хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан зааварт цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах албаны биеийн хүч, тусгай хэрэгсэл,

²⁹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/А/III/ тогтоолоор 1946.12.10-ны өдөр батлагдсан.

³⁰ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966.12.16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976.03.23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 57-р чуулганы 2002.12.18-ны өдрийн А/RES/57/199 дүгээр тогтоолоор баталж 2006.06.22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³² Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил гаргагчидтай харьцах асуудлаарх НҮБ-ын наймдугаар Их Хурлаар баталсан. Гавана, Куба, 1990 оны 8 дугаар сарын 27-оос 9 дүгээр сарын 7-нд

³³ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12-р сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор баталсан.

³⁴ ХЗДС, УЕП-ын 2017 оны 09-р сарын 06-ны өдөр хамтарсан баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

галт зэвсгийг алба хаагч нь хэрхэн яаж ямар арга, аргачлалаар хэрэглэхийг тусгайлан заасан ба цагдаагийн албаны тухай хуулийн албадлагын арга хэмжээ хэрэглэх 5-р бүлгийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлж өгсөн юм.

Албадлагын арга хэмжээг дараах үндэслэл бий болсон үед хэрэглэнэ.

Үүнд:

Олон улсын эрх зүйн зохицуулалт нь³⁵:

- Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд бодит хохирол учрах аюул
- Өөр арга, хэрэгсэл хэрэглэх нь үр дүнгүй буюу зайлшгүй нөхцөлд
- Хүч буюу тусгай хэрэгсэл хэрэглэх нь хуулийн биелэлтийг хангахад чиглэсэн байх

Дотоодын эрх зүйн зохицуулалт нь³⁶:

- Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох
- Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох
- Байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх
- Хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах
- Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон
- Цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэн буюу бүлэглэн довтолсон
- Хүнийг барьцаанд авсан
- Ялтан,цагдан хоригдогч оргосон, хүнд, онц хүнд гэмт хэргт сэжиглэгдсэн этгээд зугатсан
- Галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн
- Хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн, эсхүл бүлэглэн довтолсон
- Хорих, цагдан хорих, баривчлах байранд нийтийн эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон

Хүч хэрэглэхэд баримтлах зарчим:

- Тайван замаар буюу хүч хэрэглэхгүйгээр асуудлыг шийдвэрлэх

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь жагсаал, цуглааны үед ажиллахдаа жагсагчдын эсрэг аль болох хүч хэрэглэхгүй байх, асуудлыг эв зүйгээр зохицуулах зорилготой байгаагаа үйл ажиллагаагаараа илэрхийлж байх хэрэгтэй.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь бололцоотой бүх тохиолдолд галт зэвсэг, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухайгаа урьдчилан сануулах ба тухайн нөхцөл байдалд хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэнэ.³⁷

³⁵4, 9 дүгээр зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

³⁶Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 57-р зүйлийн 57.1 дэх хэсэг

³⁷Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 48-р зүйлийн 48.1 дэх хэсэг

Энэ нь жагсаал, цуглааныг зохион байгуулагч, эсхүл тэдний төлөөлөгчтэй гэрээ хэлэлцээр хийх, сануулга бичиг тараах, чанга яригчаар анхааруулах гэх мэт хэлбэртэй байна.

- Албан үүргээ биелүүлэх хүрээнд

Энэ тохиолдолд цагдаагийн алба хаагч нь зөвхөн албан үүргээ хэрэгжүүлж байгаа тухай ойлголт яригдана. Өөрөөр хэлбэл алба хаагч нь ажлын цагаар болон албан ажлын хэрэгцээ шаардлагаар томилогдон хууль, хэв журам сахиулах үүрэг гүйцэтгэх үедээ тусгай хэрэгсэл хэрэглэх гэсэн үг юм.

Харин ажлын бус цагаар албаны тусгай хэрэгслийг хувийн зорилгоор ашиглаж болохгүй.

- Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хүч хэрэглэх

Хуулиар зөвшөөрөгдсөн хүч, хэрэгсэл гэдэг нь гагцхүү хуулиар баталж хүлээн зөвшөөрсөн тусгай хэрэгслийг үндэслэл бүхий нөхцөлд хэрэглэнэ.

Өөрөөр хэлбэл алба хаагч нь дотоодын хууль тогтоомж, тушаал, заавруудыг сайтар судалсан байх ба хуулиар зөвшөөрөгдөөгүй галт зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглаж болохгүй юм.³⁸

Тухайлбал: Хуулинд тодорхой заасан нулимс асгаруулагчаас өөр төрлийн химийн бодис бусад олон хүнд нөлөөлөх бодис хэрэглэхийг хориглоно.

- Бусад арга, хэлбэрээр эсэргүйцлийг таслан зогсоох боломжгүй тохиолдолд буюу тухайн нөхцөлд зайлшгүй шаардлагатай

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал нь энгийн арга хэрэгсэлээр зогсоох боломжгүй болсон буюу тайван замаар тараах боломжгүй, үр дүнгүй болох нь тодорхой болсон үед тухайн нөхцөл байдал, эсэргүйцэлд тохирсон тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

Түүнчлэн цагдаагийн байгууллага хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой хохирол учирхаар байвал тусгай хэрэгслийг хэрэглэж болно.

- Тусгай хэрэгслийг ялгамжтай хэрэглэх

Тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэр гаргаж байгаа эрх бүхий албан тушаалтан нь шийдвэр гаргахдаа жагсаал, цуглаанд оролцогчдын зорилго, нас, хүйс, ямар хүмүүс байгаа зэргээс хамаарч тусгай хэрэгслийг ялгамжтай байдлаар хэрэглэнэ.

Энэ нь мөн тухай этгээдийн гаргаж байгаа үйлдэлд тохирсон түүнд чиглэсэн байхыг хэлнэ.

Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар болон галт зэвсэг хэрэглэж довтолсон, эсэргүүцсэн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон, бүлэглэн довтолсон хүмүүсийг дотор нь ялгах боломжгүйгээс бусад тохиолдолд өндөр настай, илэрхий насанд хүрээгүй, жирэмсэн, тахир дутуу болох нь мэдэгдэж байгаа хүмүүст тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглох ба шаардлагатай үед мэх хэрэглэж болно.³⁹

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхээс өмнө

- Анхааруулга.⁴⁰

Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох, жагсаал, цуглааныг албадан

³⁸2 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

³⁹Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 49-р зүйлийн 49.2 дахь хэсэг

⁴⁰10 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

тараах шийдвэрийг биелүүлэх, байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.

Урьдчилан анхааруулахдаа тодорхой хугацаа зааж, чанга яригчаар зарлах зэрэг боломжтой аргыг хэрэглэнэ.

Урьдчилан анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй бол тусгай хэрэгсэл хэрэглэнэ. Гэхдээ тухайн ажиллагаа, бүлгийг удирдаж байгаа албан тушаалтны шийдвэрээр урьдчилан анхааруулахгүй хэрэглэж болно.⁴¹

- Эсэргүйцлээ зогсоох хугацаа өгөх

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь анхааруулга өгсөний дараа тэдэнд сайн дураараа тарж явах бололцоо олгоно. Энэ нь уг жагсаалыг сонирхогч иргэд, хөндлөнгийн хүмүүс тусгай хэрэгсэлийн нөлөөнд өртөхөөс сэргийлнэ.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхдээ анхааруулга өгөхөөс гадна тэдгээр жагсаалд оролцогчид, сонирхогчдыг чөлөөтэй тарж явах бололцоог олгож гарах, явах гарцыг нээсэн байна.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх үед:

- Хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх.⁴²

Тусгай хэрэгсэл хэрэглэж байгаа зорилго нь тухайн эсэргүйцлийг няцаах, хяналтандаа авах, таслан зогсооход чиглэгдсэн байдаг тул аль болох бага хор уршиг учруулах. Эсэргүүцэл зогссон үед дахин хэрэглэхгүй байх

- Хүний амь нас, нэр хүндэд хүндэтгэлтэй хандаж илүү их хохирол учруулахгүй байх.⁴³

Хэдийгээр тухайн эсэргүүцэгч этгээд чулуу, мод, шил, төмөр шидсэн бусдын амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөнд халдсан ч гэсэн түүнийг барисан тохиолдолд иргэдийн урд гаргасан үйлдэлд өширхөх маягаар зодох, дэглэх үйлдэл хийж болохгүй.

Түүнчлэн эмх замбараагүй байдалд оролцоогүй энгийн буюу хөндлөнгийн хүмүүсийн аюулгүй байдлыг хангаж ажиллах хэрэгтэй. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй үед хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй гэсэн зарчмыг баримтлах.

- Онцгой байдал болон бусад шаардлагатай байгууллагуудтай ажиллах арга хэмжээ авах

Энэ нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед гарч болох эрсдэлүүдийг тооцож Засаг дарга Онцгой байдал, Тагнуул, Эмнэлэг, Шүүхийн шийдвэр биелүүлэх, Прокурор, Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар төлөвлөгөөтэй, урьдчилан дадлага сургууль хийсэн байхыг хэлнэ.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа:

- Эмнэлгийн туслалцааг гэмтэж бэртсэн хүн бүрт яаралтай үзүүлж шаардлагатай арга хэмжээ авах.⁴⁴ /өмнө үйлдсэн үйлдлээс үл хамааран/

⁴¹ХЗДС, УЕП-ын 2017 оны 09-р сарын 06-ны өдөр хамтарсан баталсан “Цагдаагийн алба хаагч биенийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4-р хэсгийн 4.3 дахь заалт

⁴²5 /б/ дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁴³5 /б/ дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

Тухайн этгээдийн жагсаал, цуглаан дээр гаргасан авир байдлыг үл харгалзах ба хохирсон хэнд ч болов туслах /цагдаа, үймээн гаргагч, жагсагч, жирийн иргэн, сонирхогч г.м/.

Тусламж шаардлагатай хүнд газар дээр нь анхны тусламж үзүүлж, эмнэлэгийн байгууллагад хүргэх арга хэмжээг цаг алдалгүй авах, хордсон хүн амьтан гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээ авах, иргэдэд зөвлөгөө өгөх.⁴⁵

- Дээд буюу удирдах албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх

Тусгай хэрэгсэл хэрэглэсэн талаар өгөгдсөн үүргийг хэрхэн биелүүлсэн талаар шуурхай удирдлагын штабт илтгэнэ.

- Бэртэж гэмтсэн хүнийн ар гэрийхэн болон ойр дотны хүмүүст нэн даруй мэдэгдэх.⁴⁶

Жагсаал, цуглаанд оролцогчид болон иргэд нь хэдийгээр хууль бус үйлдэл хийж хэрцгий авирласан байлаа тусгай хэрэгсэлийн нөлөөлөлд өртөж гэмтэж бэртсэн бол цагдаагийн байгууллагаас уг этгээдийн хэн болохыг тогтооож, ар гэрийнхнийх нь хаяг, утасны дугаарыг тодруулан түүний ар гэр, хамаатан садан, найз нөхдийн аль нэгэнд яаралтай мэдэгдэх арга хэмжээ авна. Уг хүний талаар ямар шийдвэр гарч хаана байгааг нь мөн дуулгана.

- Илтгэх хуудас бэлдэж удирдлагад танилцуулах.⁴⁷

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн үндэслэл, нөхцөл байдал, арга ажиллагаа, үр дүнгийн тухай эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ. Өөрөөр хэлбэл цагдаагийн төв байгууллагын даргад шуурхай танилцуулж энэ тухай илтгэх хуудас бичих.⁴⁸

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх алба хаагчид тавигдах шаардлага

Анхны тусламж үзүүлэх, бие хамгаалах хэрэгслийг ашиглах алба хаагч нь тусгай хэрэгсэл ашиглах, олон нийттэй харилцах, зөрчилдөөн шийдвэрлэх, сэтгэлийн хөдөлгөөнөө дарж сурах чадвараа сайжруулах сургалтанд хамрагдсан байх, бамбай хамгаалалтын хантааз, хамгаалалтын малгай, шууд үхэлд хүргэдэггүй зэвсэг хэрэглэж, эзэмшиж сурах.

Өөрийн мэдэлд байх тусгай хэрэгслийг аюулгүй болгоомжтой авч явах. Тусгай хэрэгсэл хэрэглэх арга техникт суралцах.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд цагдаагийн газар, хэлтэс, нэгжүүд жилд 2-оос доошгүй удаа нийтийг хамарсан арга хэмжээний үед ажиллах дадлага сургууль хийнэ гэсэн заалт байдаг.

Хариуцлага:

- Тусгай хэрэгсэл хэрэглэсэн талаар илтгэх хуудас бэлдэж дээд албан тушаалтанд хянуулах үүднээс танилцуулах.⁴⁹

Цагдаагийн алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн үндэслэл, хүний биед учирсан гэмтэл, үзүүлсэн тусламж, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдсэн тухай

⁴⁴5 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁴⁵ХЗДС, УЕП-ын 2017 оны 09-р сарын 06-ны өдөр хамтарсан баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4-р хэсгийн 4.2.6 дахь заалт

⁴⁶5 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁴⁷22 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

⁴⁸Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 58-р зүйлийн 58.6 дахь хэсэг

⁴⁹22 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он

шууд захирах даргадаа нэн даруй танилцуулж, бичгээр тайлбар үйлдэх бөгөөд шууд захирах дарга нь прокурорт мэдэгдэнэ.⁵⁰

- Дээд албан тушаалтан өөрийн удирдлагад ажиллаж буй албан хаагчийг тусгай хэрэгсэл хууль бусаар хэрэглэсэн тухай мэдсэн хэрнээ арга хэмжээ аваагүй бол хариуцлага хүлээх ёстой.⁵¹

Албадлагын арга хэмжээг бусдыг гутаан доромжлох, залхаан цээрлүүлэх, шийтгэх зорилгоор хэрэглэхийг хориглоно.⁵²

- Дээд албан тушаалтны хууль бус үүргийг биелүүлэхээс татгалзсан албан хаагч хариуцлагаас чөлөөлөгдөх ёстой.⁵³

Цагдаагийн байгууллага, алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй гэж тус тус нарийвчлан тодорхой зааж өгсөн байна.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ албадлага хэрэглэх дотоодын болон олон улсын хууль, эрх зүйн баримт бичиг, мөн хүний эрхийн талаар тусгасан хууль тогтоомж ялангуяа Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын олон улсын гэрээ, конвенцийн холбогдох заалтыг албаны үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

Ингэснээр цагдаагийн байгууллага нь олон улсын хүчний байгууллагад хүлээн зөвшөөрсөн жишиг стандартыг баримтлан албадлагын арга хэмжээг хэрэглэх, нөгөө талаас хүний эрхийг хангаж ажиллах эерэг нөхцлийг бүрдүүлэх юм.

Мөн цагдаагийн байгууллага нь албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлан түүнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах нь учирч болох сөрөг дагавараас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ болох юм.

Санал

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд баримталж байгаа хууль тогтоомж, эрх зүйн акт болон НҮБ-ийн хүний эрхийн талаархи конвенц, эрх зүйн баримт бичгийн талаар нэгдсэн сургалтыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран алба хаагчдад зохион байгуулж хууль эрх зүйн мэдлэгийг нь дээшлүүлэх
- НҮБ-ийн байгууллагаас гаргасан холбогдох олон улсын гэрээ, конвенцийг албаны үйл ажиллагаанд баримтлан мөрдлөг болгон ажиллах нь хүний эрхийг хангах үндсэн нөхцлийг бүрдүүлж түүний баталгааг хангах
- Цагдаагийн албаны үйл ажиллагаанд хэрэглэдэг албадлага /галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч/ хэрэглэх сургалтыг үе шаттайгаар алба хаагчдад зохион байгуулан ур чадвар, дадал эзэмшүүлэх
- Бусад улс орны цагдаагийн байгууллага нь албадлага хэрэглэхдээ хэрхэн ямар байдлаар хэрэглэдэг, ингэхдээ ямар арга хэмжээ, зарчим

⁵⁰Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 58-р зүйлийн 58.6 дахь хэсэг

⁵¹24 дүгээр зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд 1990 он

⁵²Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 48-р зүйлийн 48.2 дахь заалт

⁵³25 дугаар зүйл, НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он, 1 дүгээр зүйл, Хууль сахиулах байгууллагын албан хаагчдийн ёс зүйн дүрэм

баримталдаг талаархи туршлагыг нь судлах, түүнд тулгуурлан дотоодын үйл ажиллагаандаа өөрчлөлт, шинэчлэлт хийх

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАГВАР

Г.Бямбадорж

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн

ЦЭЗТ-ийн ахлах багш, цагдаагийн хошууч

Товч агуулга

Цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалт хийх эрх зүйн зохицуулалт, байгууллагын загвар бүтэцийг тогтооход харгалзах нөхцөл, бүтэц загварыг тогтооход нөлөөлөх хүчин зүйл, байгууллагын загвар, түүний төрөл онцлогийн талаар товч авч үзэж өөрийн дүгнэлт саналаа дэвшүүлэв.

Түлхүүр үг: Загвар, бүтэц, байгууллага, чиг үүрэг, зохион байгуулалт

Цагдаагийн байгууллага нь орчин үеийн шаардлага хангасан тогтолцоо, бүтэцтэй болох нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал хангах, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, үндсэн зорилт, чиг үүргээ амжилттай биелүүлэх нөхцлийг бүрдүүлэх, үйл ажиллагаа тогтворжих чухал ач холбогдолтой. Мөн үүнтэй уялдуулан орчин үеийн үйл ажиллагааны арга барил буюу ард иргэдийн оролцоонд тулгуурлах чиг хандлагыг нэмэгдүүлэх нь чухал юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад зөвхөн тогтолцооны шинэчлэл төдийгүй, сэтгэлгээ, зан байдалд өөрчлөлт оруулах нь зайлшгүй юм. Өөрөөр хэлбэл иргэд нийгэм, улс төрийн бүлгүүдийн дуу хоолой, санаа бодол, сэтгэл зовниж буй асуудлыг нь сонсох хэрэгтэй болно.

Цагдаагийн байгууллагын ажлын ачаалал, ажилтны гүйцэтгэх үүрэг, эрх мэдлийн зөв хуваарилалт, албад хоорондын уялдаа холбоо, зааг ялгаа, хүлээх хариуцлага ямагт тодорхой, шинжлэх ухааны үндэслэлтэй баймааж нь зохион байгуулалтын бүтэц оновчтой болно.⁵⁴

Цагдаагийн байгууллагын бүтцийг Шинэчлэн найруулсан Цагдаагийн Албаны тухай хуулийн 6-р зүйлд “Цагдаагийн байгууллага нь цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас бүрдэнэ” хэмээн заасан.

Цагдаагийн байгууллага нь хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын эрхэм зорилго зорилтыг хэрэгжүүлэхэд тохирсон бүтэц зохион байгуулалттай байх шаардлагатай байдаг.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны бүтэц болон эрх мэдлийн харилцаа хамаарлыг тодорхойлдог процессыг зохион байгуулалт хийх гэнэ.

Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтыг хийхдээ дараах зүйлсэд анхаарал хандуулна. Үүнд:

⁵⁴ Цагдаа судлал онол арга зүйн сэтгүүл. 2016 оны №1 дугаар, 12 дахь тал

1). Ямар ажил хийх ёстойг тодорхойлох тухайлбал: Мөрдөн байцаалт явуулах, эргүүл харуул хийх, гэмт хэргийн газар, нотлох баримт ул мөрийн хамгаалах, хангалт хийх г.м;

2). Ажил үүргийн хэрхэн бүлэглэхийг тодорхойлох тухайлбал: Эргүүл хамгаалалт, мөрдөн байцаалт болон гэрч хохирогчийг хамгаалах г.м;

3). Албан тушаалын дэс дараалал тогтоох тухайлбал: Дарга, дэд дарга, ахлах мөрдөгч, мөрдөгч, ахлах байцаагч, хэсгийн байцаагч, эргүүлийн цагдаа г.м;

4). Ажил үүргийн хариуцлага болон эрх мэдлийг тэнцвэржүүлэх тухайлбал: Мөрдөн байцаалт явуулах ажлын хэсгийн даргад тухайн үүргийг гүйцэтгэхэд зохих ёсны эрх мэдэл олгох ёстой. Эс бөгөөс түүнд ямар нэгэн хариуцлага тооцож болохгүй.

Цагдаагийн байгууллагын бүтцийг тогтоохдоо дараах хүснэгтэд дурьдсан 14 зүйлд анхаарал хандуулж тухайн нутаг дэвсгэрт тохирсон үйл ажиллагаа явуулах бүтэц загварыг тогтооно гэж судлаачид үзсэн байна.

Хүснэгт №1. Цагдаагийн байгууллагын загварт нөлөөлөх хүчин зүйл

Байгууллагын загварт нөлөөлдөг хүчин зүйлс	
Цагдаагийн агентлагуудын бүтэц зохион байгуулалт улс даяар өөр өөр байдаг. Хэдийгээр судлаачид байгууллагын бүтэц зохион байгуулалтын загварт нөлөөлдөг бүх хүчин зүйлсийг тогтоож чадаагүй ч, гурван том судалгаа хийсний үр дүнд 14 хүчин зүйлс нөлөөлдөг болохыг илрүүлжээ. Үүнд:	6. Байгууллагын наслалт буюу түүх
1. Байгууллагын хэмжээ болон орчин	7. Улс төрийн соёл болон орчин
2. Хотын засаг захиргаа	8. Хүн амын хэмжээ болон нягтрал
3. Бүс нутаг	9. Хүн ам төлөвлөлт
4. Технологийн хэрэглээ болон ашиглалт	10. Ядуурал болон орлогын түвшин
5. Гэмт хэргийн түвшин болон хэв журмын нөхцөл байдал	11. Хотжилт
	12. Менежментийн хязгаар
	13. Цаг хугацаа
	14. Бүтэц зохион байгуулалт
Эх сурвалж: Эдвард Магуль, Крейг Д. Учида, “Америк цагдаа нарын харьцуулсан судалгааг үнэлж, тайлбарлах нь” Гэмт хэрэг болон шүүн таслах үйл ажиллагааны үнэлгээ болон шинжилгээ (Албан бус орчуулга)	

Судлаач Тансик, Элиот нар аливаа байгууллагын албан ёсны бүтэц зохион байгуулалтын асуудлыг авч үзэхдээ дор дурьдсан хоёр зүйлд анхаарал хандуулах ёстой хэмээн үзэж дараах загвар бүтэцтэй байж болон хэмээн үзжээ. Үүнд:

1. Тухайн байгууллагын боловсон хүчний албан ёсны харилцаа хамаарал болон ажил үүрэг
2. Байгууллагын зохион байгуулалт болон албан үүргийн хүрээнд үйл ажиллагааг тодорхойлж буй албан ёсны дүрэм журам, бодлогын баримт бичиг гэж үзсэн.

Тэрээр цагдаагийн байгууллагын бүтэц загварыг олон төрөл хэлбэрийг тайлбарласан байна. Үүнд:

Босоо бүтэц: Эрх мэдэл буюу байгууллагын хэмжээнд хэн ямар эрх мэдэлтэй болох дээр тулгуурласан байдаг. Босоо бүтцийн дагуу эрх мэдэл эдэлж буй хүмүүс бусдад ажил томилж, түүний гүйцэтгэлийг хянах эрхтэй байдаг.

Хэвтээ бүтэц: Энэ бүтэц нь ажиллагаан дээр тулгуурладаг. Гэвч, зарим тохиолдолд, хэвтээ бүтэц нь тодорхой нэг төсөл хөтөлбөр аль эсхүл газар зүйн байршил дээр тулгуурлаж байдаг. Өөрөөр хэлбэр үйл ажиллагаа, байршлаас хамаарч бүтэц загварыг тогтоож иргэдэд үзүүлэх үйлчилгээгээ илүү ойр хүргэдэг байна.

Шугамын бүтэц: Байгууллагын загварын хамгийн эртний, хамгийн энгийн бөгөөд хамгийн тодорхой төрөл юм. Энэ бүтцээр эрх мэдлийг дээрээс доош маш тодорхой байдлаар нэг шугамын дагуу зохицуулсан байдаг.

Үүгээр удирдах болон захирагдах албан тушаалтнуудын харилцаа хамаарлыг зохицуулдаг бөгөөд тухайн шатлалыг тушаалын дэс дараалал гэдэг.

Гол ач холбогдол нь тушаалын дэс дарааллын дагуу хариуцлага хүлээлгэхэд оршдог.

“Шугамын” гэдэг нь Цагдаагийн байгууллагын хэмжээнд түүний ёстой ажлыг хийдэг хэсгийг буюу элементийг хэлдэг. Өөрөөр хэлбэл: Цагдаагийн байгууллагын үндсэн нэгжийн алба хаагчид эргүүл, харуул, хамгаалалтын цагдаа, замын цагдаа, мөрдөгч нарыг шугамын алба хаагчид гэж үзнэ.

Цагдаагийн байгууллагын хүрээнд авч үзвэл шугамын бүтцийг “үндсэн үйл ажиллагаа”, “үндсэн үйлчилгээ” аль эсхүл үүнтэй адил бусад нэрээр томъёолж болно энэ нь Монголын Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах газартай дүйцэнэ.

Энэхүү бүтэцтэй цагдаагийн байгууллагуудад дэмжлэгийн тасаг хэсэг байдаггүй. Үүний оронд иргэдэд шууд үйлчлэх бүтэцтэй цагдаагийн нэгжүүдийн хүний нөөцийг зузаатгаж үйл ажиллагаагаа илүү үр дүнтэй явуулдаг. Шугамын бүтцийг голдуу жижиг хот тосгодод ашигладаг бөгөөд Америкийн мужийн цагдаагийн хэмжээнд энэ бүтэц элбэг байдаг.

Шугамын болон захиргааны бүтэц: Цагдаагийн хэлтсийн үйлчилгээ үзүүлэх эрэлт хэрэгцээ нэмэгдэх өөрөөр хэлбэл гэмт хэргийн гаралт ихсэх, эрүү хэв журмын нөхөл байдал хүндрэх тусам үндсэн чиг үүрэг гүйцэтгэж байгаа нэгжийг дэмжлэгийн тасаг хэсгүүд байгуулж шугамын болон захиргааны бүтэцийг бий болгодог.

Шугамын бүтэцтэй байгууллагуудад захиргааны хэсэг байгуулж өгөх нь хэд хэдэн талаар давуу талтай. Үүнд:

1. Алба хаагчид мэргэжлийн чиглэлийн дагуу илүү үр дүнтэй ажиллана;
2. Алба хаагчдын хийх дургүй аль эсхүл хийж гүйцэтгэж чадахгүй ажлыг захиргааны ажилчид гүйцэтгэнэ. Тухайлбал, сургалт семинар зохион байгуулах, төсөл хөтөлбөр боловсруулах;
3. Хэлтсийн хэмжээнд үйл ажиллагааг нэгдсэн байдлаар явуулах нөхцөл бүрдэнэ;
4. Байгууллагын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх. г.м

Зарим тохиолдолд захиргааны ажлыг туслах болон захиргааны гэсэн хоёр төрөлд хуваагдана. Ийм зохион байгуулалт хийсэн тохиолдолд туслах буюу дэмжлэгийн нэгжүүд нь үндсэн чиг үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад туслалцаа үзүүлэн ажилладаг.

Нөгөө талаас захиргааны ажилчид нь нийт цагдаагийн хэлтсийн хэмжээнд үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажил, үйл ажиллагааг зохицуулан ажилладаг байна.

Ерөнхийдөө байгууллагын ажил үүргийг үйл ажиллагааны чиглэлээс шалтгаалан өөр өөрөөр ангилдаг. Маш ховорхон тохиолдолд байгууллагын

бүтэц зохион байгуулалтын асуудлыг хууль эрх зүйн тогтоолоор шийдвэрлэсэн байдаг.

Үйл ажиллагааны бүтэц: Шугамын бүтцэд өөрчлөлт оруулан ашиглахыг үйл ажиллагааны бүтэц гэж хэлдэг юм. Судлаач Ходж болон Жонсон нар үйл ажиллагааны бүтцийг тодорхойлохдоо алба хаагчид шугамын болон захиргааны бүтцийг өөрчлөн байгуулсан бүтцийг хэлнэ хэмээн тодорхойлжээ.

Энэ бүтцээр тодорхой нэг ажлын нэгжүүдийг заавал бусад нэгжүүдийн удирдах албан тушаалтнуудын өмнө хариуцлага хүлээж ажилдаг. Алба нэгжүүд хоорондоо мэдээлэл солилцох, хүн хүч, нөөц хэрэгслээ хуваалцаж чиг үүргээ хэрэгжүүлдэг. Зөвхөн чиг үүрэг үйл ажиллагаанд тулгуурлаж бүтэцээ бий болгох боломж олгодог бүтэц юмаа.

Үйл ажиллагааны бүтцийн нэг том сул тал нь байгууллагын нарийн бөгөөд төвөгтэй байдлыг улам ярвигтай болгодог. Тухайлбал: Мэдээллийн тасгийн ажилчид маш олон хүний удирдлаган доор ажилладаг, нэгжийн алба хаагчидмаш оло төрлийн чиг үүрэг хэрэгжүүлэх гэх мэт.

Матрицын бүтэц: Байгууллагын бүтэц зохион байгуулалтын загварын маш сонирхолтой нэг төрөл бол матрицын (буюу торын) бүтэц юм.

Матриц загварын гол мөн чанар нь алба хаагчдыг өөрсдийнх нь мэргэжлийн чиглэл тухайлбал: Эргүүл хамгаалалт, мөрдөн байцаалт болон дэмжлэгийн үйлчилгээ болон бусад ажил үүргийн дагуу тодорхой төслүүд дээр томилж ажилуулах үйл ажиллагаан дээр тулгуурласан загвар юм.

Матриц загварын бүтцийг голдуу орон нутгийн хэмжээнд хэд хэдэн удаа маш ноцтой гэмт хэрэг гарсан тохиолдолд түүнтэй тэмцэх, илрүүлэхэд зохион байгуулж ашигладаг. Энэ нь эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх ажлын хэсэг байгуулах явдлаар илэрнэ.

Матриц загварыг ихэнх үед богино хугацааны хэмжээнд тодорхой нэг хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулж хэрэглэдэг. Үүрэг даалгаврыг гүйцэтгэсний дараагаар ажлын хэсгийн гишүүд эргээд өөр өөрсдийн ажлын нэгж уруу буцдаг. Өөрөөр хэлбэл тодорхой хэрэг дээр ажиллах ажлын хэсэг байгууллахыг матриц бүтэц гэж тодорхойлдог. Энэхүү бүтцийг тодорхой нэг асуудлыг шийдвэрлэхэд зохион байгуулж ашиглавал илүү үр дүнтэй.

Цагдаагийн байгууллагын дээр дурьдсан бүтэц загвараас гадна хэд хэдэн төрлийн орон нутгийн цагдаагийн байгууллагын загварыг амжилттай хэрэгжүүлсэн боловч одоогийн байдлаар маш олон асуудлууд тулгарсан байна. Тухайлбал: Цагдаагийн байгууллагын уламжлалт бүтцийн хувьд, тэдгээр нь бусдыг захирч, удирдахад чиглэгдсэн байдаг бөгөөд захиргааны шатлалын зарчмыг баримталдаг. Гол нь эдгээр зарчмууд нь алба хаагчдын инноваци болон бүтээлч сэтгэлгээг бууруулж, хувь хүнийг тусгаарлаж, түүний үнэ цэнийн тухай ойлголтыг үгүйсгэж бүх зүйлийг нэгэн жигд байлгах, удирдлагын удирдан манлайлах дагуулах ур чадварыг сулруулдаг гэж судлаачид үзсэн нь оновчтой байна.⁵⁵

Ер нь орон нутагт цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд байгууллагын бүтэц илүү богино буюу хэвтээ байх шаардлагатай.

⁵⁵ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration , 2011. 124-139 дэхь тал

Түүнчлэн орон нутгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл үйлчилгээ нь төвлөрсөн бус байдаг тул харьцангуй хүнд суртал багатай байх боломжтой.

АНУ-ын судлаач Корднерын үзсэнээр орон нутгийн цагдаагийн байгууллагын хувьд бичиг цаас болон дүрэм журмаас илүүтэйгээр шууд нөхцөл байдалд нь тааруулж ажиллах арга барилыг ашиглах нь зүйтэй. “Бичиг цаас болон дүрэм журмыг цагдаагийн удирдлагын албан тушаалтнуудыг удирдах зориулалттай” гэсэн нь нэгжийн үйл ажиллагаанд төдийлөн шууд хамааралгүй гэжээ.

Түүнээс гадна нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа “хаалттай” бөгөөд “дотогш чиглэсэн” байхын оронд илүү нээлттэй буюу олон нийтрүү чиглэсэн байх нь илүү үр дүнтэй байж болох юм.

Нөгөө талаар цагдаагийн байгууллагын загварыг тогтоохийн тулд заавал алба хаагчид тодорхой хэмжээнд мэргэшсэн байх шаардлагатай ба энэ нь эргээд ажил үүргийг удирдан зохион байгуулахад байгууллагын бүтцийг бий болгоход нөлөөлдөг.

Мэдээлэлд суурилсан цагдаагийн байгууллагын загвар: 2000-аад оны эхээр өрнөсөн Compstat хөдөлгөөн нь нийт Америк улсын хэмжээнд гэмт хэргийг маш ихээр бууруулсан. Гэвч тухайн хөдөлгөөн нь байгууллагын бүтэц болон загварт ямар нэгэн тодорхой нөлөө үзүүлэхгүй бөгөөд байгууллагын үйл ажиллагааны бүтэцэд нөлөөлнө.

Энэхүү загвар бүхий цагдаагийн үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагыг илүү идэвхтэй бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэлтэй зохион байгууллахыг шаарддаг.

Ингэхийн тулд байгууллагын хэмжээнд мэдээлэл түгээх үйл явцад анхаарал хандуулж ажиллах шаардлагатай. Мэдээлэлд суурилсан цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд мэдээллийг цаг алдахгүй хүлээн авах, дамжуулах, боловсруулах шаардлагатай ба түүнийг хэрэгжүүлэхэд бусад хэлтэс болон агентлагуудтай хамтран ажиллах мэдээллийн нэг бааз суурьтай болох замаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг байх шаардлагатай.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг нийгэм эдийн засгийн орчин, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, гэмт хэргийн гаралт, орон нутгийн онцлог зэргийг харгалзан цагдаагийн байгууллагын дээр дурьдсан олон төрлийн бүтэц зохион байгуулалт загварыг бий болгож цагдаагийн газар хэлтэс, тасаг, хэсгийг бүтэц зохион байгуулалтыг онцлогт нь тохируулж ялгавартайгаар тогтоох шаардлагатай гэж үзэж байна.

Санал

1.Нутаг дэвсгэрийн онцлог шинж, гэмт хэргийн гаралт, хүн амын тоо, хот төлөвлөлт, нийгэм эдийн засгийн орчин, хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон бүтэцтэй байна гэж Цагдаагийн албаны тухай хуульд тусгах;

2. Цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалт загварыг тогтоох суурь судалгаа шинжилгээний ажил явуулах;

3.Аймаг, дүүргийн цагдаагийн бүтэц зохион байгуулалтын тогтсон нэг хэлбэр загвараас татгалзаж нутаг дэвсгэр бүр хэвтээ, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай, захиргааны, матриц гэх мэт өөрт тохирсон бүтэц загвартай болгох;

4.Цагдаагийн дэд хэсгийн бүтцийг үйл ажиллагааны болон матриц бүтэцэд шилүүжүүлэх;

Ингэснээр хороодын засаг дарга өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа иргэдийн ая тухыг алдагдуулж, хэв журам зөрчиж байгаа бүхий л асуудлыг цагдаагийн байгууллагатайгаа хамтран шийдвэрлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хууль сахиулах ажиллагаанд иргэд, цагдаагийн байгууллага иргэд дунд орж хамтран ажиллах бололцоогоор хангагдана.

ЦАГДААГИЙН ЭРГҮҮЛИЙН ҮҮСЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Ч.Ганбат

ХСИС-ийн АШБС-ийн магистрант,
цагдаагийн хошууч

Товч агуулга

Энэхүү өгүүлэлд цагдаагийн эргүүлийн үйл ажиллагааны түүхэн хөгжил, тэр дундаа эртний хаад ноёд хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр янз бүрийн арга хэрэглэж, түүнийгээ тухай үед мөрдөж байсан хууль тогтоомжид хэрхэн тусгаж байсан болон өнөөгийн хүртэл эргүүлийн үйл ажиллагаа хэрхэн хөгжиж ирсэн талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: Эргүүл, харуул, хууль, үйл ажиллагаа

Монголчууд өнө эртний төрт ёс, соёл, эрх зүйн баялаг, бахархам түүхтэй ард түмэн. Олон зууны түүхийн нугачаанд бичмэл болон бусад төр, эрх зүйн баримтууд устаж үгүй болсон ч зарим эх сурвалжууд⁵⁶ бидний үед ирсэн байна.

Монголчуудын хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэж байсан уламжлалыг нэн эртний түүхээс хайж судалвал зохино. Төв Азийн анхны төрт улс болох Хүннү гүрэнд эрх зүйн сурвалжийн хоёр төрөл тухайлбал төрөөс тогтоосон хууль цааз болон заншлын хэм хэмжээнээс бүрэлдсэн хэв хууль харилцаа холбоотойгоор хослон үйлчилж байжээ.⁵⁷

Үүнээс үзвэл Хүннү гүрэнд төрөөс тогтоосон хууль үйлчилж хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэж байсан нь тодорхой болж байна. Мөн “Ши-Цзи”-д “тэдний /Хүннүгийн/ баримталдаг хуулиар...арав хоногоос илүү хугацаагаар хорихгүй, улс даяар хоригдол хүн хэдхэнээс хэтрэхгүй” гэсэн нь хорих ял биш бөгөөд зөвхөн хэрэг, зөрчлийг шалгах, хэв журмыг сахиулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсооход түр саатуулах хугацаа хэмээн үзэж болохоор байна.

Хүннүчүүд торгоны замыг хяналтандаа байлгахдаа эргүүлийн морин баг цэрэг байнга ажиллуулдаг байсан ба уг цэргүүд харуулын үүрэг давхар гүйцэтгэдэг байсан байна. Хүннүгээс хойших төрт улсуудын үед ч хэв журам

⁵⁶ Монголын нууц товчоо /Хятад ханзаар бичигдсэн эх сурвалж БНХАУ-ын нууц номын санд бий/, Персийн түүхч Жувеини “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх”, Рашид-Ад Дин “Чингис хааны түүх”, Плано Карпини. “Монголын түүх” /Азид хийсэн аян замын тэмдэглэл/, Марко Поло “Азид хийсэн аян замын тэмдэглэл”, Рубрук. “Зүүн азиар аяласан тэмлэглэл” гэх мэт болон бусад зохиол, тэмдэглэл, олдворууд.

⁵⁷ . И.Дашням “Монгол улсын төр, эрх зүйн түүх” 56-р тал

сахиулах эргүүл, харуулын үйл ажиллагаа тасралтгүй явагдсаар ирсэн байдаг. Тухайлбал Жужан улсын хаан Чуну гадаад улсуудад явах элч, элчингүүд, төрийн сайд, төрийн багш, төрийн түшмэдийг тохоон томилж харгалзан явах харуулыг томилж, улсын доторх төрийн эсрэг үймээн гарсан тохиолдолд морьт эргүүлийг ажиллуулж байжээ.

Эзэн богд Чингис хаан 1185-1206 онд 32 удаа дотоодын дайн явуулж 81 аймгийг нэгтгэн төвхнүүлсэн байна. Эдгээр тэмцлийн үр дүнд Чингис хаанаар өргөмжлөгдөж бүх монгол туургатны хаан болсноор Шихихутагт үүрэг болгож улсынхаа дотоодод дэг журамыг тогтоож хэв журам сахиулах хэрэг зөрчлийг шийдвэрлэх эрх олгожээ.⁵⁸

Монгол улсын түүхэнд эзэн богд Чингис /1206-1227/ хаанаас эхлэн хамгийн сүүлчийн хаан Алтан ургийн Лигдэн /1604-1634/ хаан хүртэл 427 жил хаант төр тогтоохдоо хэв журам сахиулах хэрэг зөрчилтэй тэмцэх ажлыг төрийн “тусгай байгууллага, яам, цэргийн” хүчээр болон харьяат улс түүний зуут мянгат түмтийн аймаг засаг ноёдын хүчээр зохион байгуулж дэв зэрэгтэй түшмэдүүдэд томилж байжээ.

Чингис хаан хамаг Монгол улсаа сэргээн байгуулснаас эхлэн их Монгол улсын хаанд өргөмжлөгдөх хүртэлх түүхэн үе буюу 1190-1205 он цэргийн байгуулалтынх нь 2 дугаар үе шат байв.

Энэ шатанд Чингис хаан уламжлалт турхаг цэргийн байгуулалтдаа түшиглэн байнгын бүрэлдэхүүн бүхий “Хишигтэн цэрэг” байгуулан улсын бүх цэргийг аравтын тогтолцоонд шилжүүлж байлдааны цагийн хатуу чанд хууль цааз тогтоон, зөвхөн Хишигтэн төдийгүй шууд бус захиргааны цэргээ ч мөн өөрийн шууд удирдлагаар оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, цэргийн нэгдмэл захиргааны ёсыг бүрэн агуулгаар тогтоох нөхцлийг бүрэлдүүлсэн нь монгол цэргийн байгуулалтын түүхнээ эрс шинэтгэлийн үе болсон юм.⁵⁹

Энэ үед өдрийн эргүүлд “торхон” шөнийн манаанд “хэвтүүл” гэх цэрэг бүхий хишигтэнг ажиллуулж байжээ.

Чингис хааны үед байнгын цэрэгтэй байж, дайн байлдааны үед тэдгээрийг манлай цэрэг, гээг цэрэг, гол цэрэг, сүүл цэрэг гэж хуваарилан цэргийн аравт, зуут, мянгат, түмтийн жанжны удирдлагаар хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэх ажлыг зохицуулж иржээ.

Өгөөдэй, отгон дүү Тулуй, II хаан Өгөөдэйн ахмад хүү Гүюг, Чингисийн ач Тулуйн хүү Мөнх, Хубилай нарын үед Чингисийн үеийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгон уламжилж иржээ.

Хубилай хаан ширээнд сууж 1271 онд Юань гүрэн байгуулав. Юань улс нь төв байгууллага, цэргийн хүрээлэн, хууль цаазын байцаах хороо гэсэн байгууллагатай байж хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэхэд гол үүрэгтэй бүтэц бүхий хулгай дээрэмчдийг барих хэлтсүүдтэй байжээ.

Юань улсын үед баруун болон зүүн этгээдийг манаж цагдах, анхан манаж цагдах яамдууд байгуулж, элдэв дэв зэрэгтэй ажилтантай байжээ.

⁵⁸. Ж.Содмандах “Нийгмийн хэв журам хамгаалах албаны түүхэн замнал” УБ 9 дэх тал

⁵⁹. Монгол улсын Батлан хамгаалах яамны эрдэм шинжилгээний хүрээлэн “Монгол цэргийн түүхийн товчоон” тэргүүн дэвтэр 107 дах тал

Манжийн ноёрхлын үед Монгол нутагт анхны суурин цагдаагийн байгууллага үүссэн түүхтэй. Манжийн ноёрхлын үед хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэж байсан эргүүл, харуулын талаарх түүхийн баримт, мэдээ харьцангуй баялаг юм.

Баруун Монголын хаан Галданбошигт нэгдсэн Монгол улс байгуулж, Манжийн эсрэг тэмцэх бодлогыг явуулахад халхын Түшээт хаан, Богд Жавзандамба нар зөвшөөрөөгүйгээс тэмцэл, тулаан өрнөж Манж чин улс Монголыг дайран түрэмгийлж эрхэндээ оруулснаар 1691 оноос 1911 он хүртэл 220 гаруй жил Манж чин улсын дарлалд байв. Манжийн түрэмгийлэгчид халх Монголыг өөрийн дарлалд оруулж, ард түмнээс олон төрлийн алба гувчууруудыг авах болсон.

Эдгээр алба гувчуурыг хүчээр албадан төлүүлэх нь хэв журам сахиулж, хэрэг зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаа болж байв. Энэ үед Монголын хаадын баримталж ирсэн “Их засаг” хууль хоригдож, Халх гурван хошууны дүрэм, 1709 онд халхын Түшээт хаан, ноёдын зохиосон “Халх журам” хуулийг даган мөрдөхийг зөвшөөрч, дараа нь 1795 оны Монголын цаазын бичиг, Манжийн 1817 оны хууль зүйн бичгийг голлон хэрэглэж байжээ.

Ар Монголд Улиастайн цагдаа, Их Хүрээний цагдаа, Орон нутгийн цагдаа хэмээх үндсэн 3 том цагдаагийн алба байснаас гадна Богд хан уул, Хан Хэнтий уулын ойн цагдаа, Авын цагдаа, Харчин өртөөний цагдаа зэрэг томоохон цагдаагийн алба байжээ.⁶⁰

Түүхч Л.Гомбо 1960 онд туурвисан “Манжийн үеийн алба гувчуур (1750-1911)” хэмээх зохиолд “Олон хошуудын хилийг харгалзсан харуулуудыг цагдаа буюу тайгам гэж нэрлэж байсан бөгөөд хилийн цагдаа харуул нь ихэвчлэн Монгол нутгийн өмнөд талаар байрлаж байв.”⁶¹

Ц.Насанбалжир.1963 онд туурвисан “Ар Монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба (1691-1911)” хэмээх зохиолд “Олон хошуудын цагдааг нутгийн цагдаа, савын цагдаа, хилийн цагдаа, тайгам хэмээн нэрлэдэг”⁶² хэмээжээ.

Ар Монгол дахь орон нутгийн цагдаагийн гүйцэтгэх үүрэг, байршлийн онцлог байдал зэргээс үндэслэн хоёр ангилж болох юм. Үүнд:

- Дотуур харуул буюу хилийн харуул лугаа зах нийлсэн цагдаа.
- Олон хошуудын хилийг харгалзсан цагдаа хэмээн хоёр ангилна.

XIX зууны II хагасаас Их Хүрээ нүүдлийн шинжээ орхиж суурьшмал байдалд шилжин хотжилт төлөвших болсон бөгөөд тэрхүү үйл явцтай уялдан хөдөө орон нутгаас зорин ирэх хүмүүсийн тоо нэмэгдэж хашаа байшин, сүм дуган, дацан олноор баригдаж худалдаа арилжаа өргөжин тэлж худалдаачид, лам нар харчууд гэсэн ялгаа гарчээ. Ялангуяа хөдөө орон нутгаас ядуу хоосон хүмүүс хүрээг зорин ирэх нь нэмэгдэж хулгай дээрэм, хэрэг будлиан гарах нь ихсэх болсон тул Их Хүрээний нутаг дэвсгэр дээр цагдаагийн албыг бий болгох зайлшгүй шаардлага тулгарсан байна.

⁶⁰ Б.Буянчулуун. Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн. Худам монгол бичгээс крилл бичигт буулгасан: Хэрээд Ж.Урангуа, Боржигон Дориг З.Энхтайван. УБ., 2010 69-р тал

⁶¹ Л.Гомбо. Манжийн үеийн алба гувчуур (1750-1911) УБ., 1960

⁶² Ц.Насанбалжир. Ар Монголоос Чин улсад залгуул байсан алба (1691-1911). УБ., 1963 129- тал

Үүний тулд “1857 онд тусгай дүрэм гарч Их Хүрээний орчин тойрон газрыг сэргийлэх явдлыг чангатгах арга хэмжээ авсан”⁶³ боловч тэрхүү арга хэмжээ нь амжилтгүй болсон бөгөөд Бүрэлт засагчийн 5 дугаар он (1866 он) 09 дүгээр сарын 21-нд Богдын шавь нарын хэргийг эрхлэн шийтгэх Эрдэнэшанзудба Цэдэндорж, Сангийн хамаг хэргийг байцаан шийтгэх сайд тайж Эриндор, Да лам Лувсан нараас хүрэн дэх Сэцэн хан аймгийн чуулган даргад илгээсэн бичигт “...Тушаасныг дагаж хүрээний ойр тойрон 15-н газар⁶⁴-ыг хэмжээлэн 15-н анги хуваахад...” хэмээн өгүүлснээс үзэхэд Арван тавны цагдаа нар нь Их Хүрээний ойр орчмын газрыг амар амгалан тайван байдлыг хангах үүрэг бүхий маш чухал алба байсан төдийгүй эргүүл хийх, харуул гарах явцад ёс бус үйлдэл гаргасан амгалан тайван байдал эвдсэн этгээдийг баривчилж харьяат газартаа тушаах эрх бүхий алба байсан байна.

1911-1916 он буюу цагдан сэргийлэх хороо байгуулагдах хүртэл Богд хаант Монгол улсын цагдаа хэв журмын зөрчилтэй тэмцэх талаар үлэмж ажлыг гүйцэтгэсэн байна.

1916 онд батлагдсан Нийслэл Хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм хэмжээнд зөвхөн Нийслэл Хүрээ, Хүрээний доторх албан газар, байгууллага, зах зээл, гудамж, хороод гадаад, дотоодын иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд бүрэн чиглэгдэж, Нийслэлийн цагдаагийн үүргийг тодорхой болгон заасан юм.

Түр засгийн газар Ардын засгийн газраа байгуулж, цэрэг, дотоод, шүүх, гадаад, сангийн зэрэг таван яамыг юуны өмнө байгуулж ажилд оруулахын хамт хувьсгал ялсны найм дахь хоног дээр хувьсгалт шинэ ёс журмыг хэрэгжүүлэх, улс орон, нийслэл хүрээний амгалан тайван байдлыг сахиулах зорилготой төрийн механизм болсон ардын цагдан сэргийлэх байгууллагыг байгуулахаар шийдсэн байна.

Ийнхүү Богдын төрийн цагдаагийн байгууллага нь шинж чанар үйл ажиллагаагаар шинэчлэгдэж, ардын төрдөө үйлчлэх болсон боловч морьт ба явган цагдаагийн системийг үргэлжлүүлж,⁶⁵ анхны жилдээ цэрэг мэт сангаас хоол идэж, хувцас хэрэглэн хуарагнаж байснаа засгийн газрын 1922 оны 3 дугаар сарын 29-ний 13 дугаар хурлаар Ардын цагдаа нь цэрэгтэй адилгүй, гэр орноороо байж, алба залгуулах нь өөрийн хүнд хүчир үүргээ биелүүлэх боломж нь сайжрах учраас тэд нарт хүнс, хувцас олгохгүй, харин 9 лангийн цалин олгох нь зүйтэй гэж шийдвэрлэсэн бол 1924.02.15-ны Засгийн газрын хурлаас морьт цагдааг 27 лангийн цалинтай болгож нийгмийн байдлыг сайжруулан ажиллах боломжийг нь дээшлүүлж, жинхэнэ төрийн алба хаагч болгон шинэ шинэ үүргүүд хариуцуулж зохион байгуулалт, бүтэц⁶⁶ нь өргөжин бэхжиж байв.

Цагдаагийн хувцасны талаар олон саналууд гарч⁶⁷ өөрчлөгдөж байсан боловч хот орчим болон хөдөө нутагт гарсан гэмт хэргийг илрүүлэхээр ажилладаг морьт цагдаа нь цагаан шар хантаазтай, хотын доторх амгалан тайван

⁶³. Р.Гүнсэн, Б.Сэнгэдорж. Цагдан сэргийлэхийн түүхэн өгүүлэл. УБ., 1979 6-р тал

⁶⁴. Газар гэдэг нь ургын хэмжүүр бөгөөд Нэг газар нь орчин үеийн хэмжээсээр 576 м болно.

⁶⁵. Мөн тэнд 72 дах тал

⁶⁶. 1922 онд нийслэл хүрээний ЦС хороо 102, Амгаланбаатар хотын ЦС хэлтэс 32 бүгд 134 орон тоотой байсан бол 1923 онд хороо, хэлтэс хоёрыг нэгтгэж нэгэн удирдлагатай болгоход 1924 онд орон тоо нь 148 хүнтэй ажиллаж байв.

⁶⁷. 1922 онд дарга Г.Гүрсэд, Амгаланбаатар хотын ЦС хэлтсийн түшмэл Цэрэнпунцаг нар саналаа бичгээр гаргаж байсан ажээ.

байдал, хэв журам, ариун цэврийг сахиулах, хэрэг зөрчлийг илрүүлэх, чухал газрыг манаж хамгаалдаг явган цагдаа нь улаан шар хантаазтай, хантааз дээрээ “морьт цагдаа” “явган цагдаа” гэж монгол бичгээр бичсэн хувцастай болж 1925 оныг хүртэл хэрэгжиж байжээ.

Цагдан сэргийлэх байгууллага зөвхөн нийслэл хүрээнд байсан ба орон нутагт байсангүй. Харин Монголын ХЗЭ-ийн төв хорооны саналын дагуу 1924 оны 7 дугаар сард засгийн газрын хуралдаанаас хүн ам бөөгнөрсөн, гадаадын мөнгө хүлээгчид төвлөрч байсан Улиастай хотод бага дарга нэг, цагдаа дөрвийг ажиллуулахаар шийдвэрлэн ажиллаж байсан нь орон нутаг дахь анхны салбар юм.⁶⁸

1926-1932 он хүртэл нийслэл хотын хүн ам, албан газар байгууллага нэмэгдэж, түүний дотор хэв журам зөрчигч, гэмт хэрэг үйлдэгч нар өсөж, эрүүгийн нөхцөл байдал хүндэрч байжээ. Хотод хулгай, дээрмийн хэрэг өдөр шөнөгүй гарах болсон учраас нийгмийн хэв журам сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх талаар цагдан сэргийлэхийн үйл ажиллагааг улам сайжруулах шаардлага гарч, олон арга хэмжээнүүдийг авч байв.

УБ хотын захиргаа 1928 онд цагдан сэргийлэх, олон хороодын дарга нар, шашин хурлын хэрэг эрхлэх түшмэл нар хамтран хуралдаж хотын доторх муу самууныг таслан ариутгаж, ард түмний амгалан тайван байлгахын учир хотын 10-н хашаа бүрээс шөнө тутам манаа гаргаж цагдан сэргийлүүлэх, хүрээ гандангийн байрыг нэгэн адил манаж сэргийлүүлэхийн тулд шашин хурлын хэрэг эрхлэх газраас гандан ба хүрээний дотор байгаа лам нараас ээлжлэн гаргахаар шийдвэрлэж байжээ.

1963 онд Цагдан сэргийлэх байгууллагын шинэ дүрмээр гудамж, талбай, олон нийтийн монгол зургаан, туслагч жанжны газарт алба хааж буй цагдаа цэргүүд нь мэдээний албаны нь дэлгэрэнгүй зааж өгчээ.⁶⁹ Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын сэргийлэн хамгаалах хэлтэс гэж байгуулсныг 1960 онд өөрчлөн зохион байгуулжээ. Улсын хэмжээгээр хариуцах аппаратыг Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын гүйцэтгэх албан хэлтсийн нэг тасаг, групп хариуцах болгож уг хэлтсийн оронд нийслэлийн цагдан сэргийлэх газрын Сэргийлэн хамгаалах хэлтэс гэж байгуулан хурандаа Цэдэвийн Шагдарыг томилсон байна. Энэ хэлтэс эхлээд хэв журмын тасагтай бусад ажлыг хариуцсан ажилтнуудтай байсан удсангүй харуулын тасаг нэмэгдэн байгууллагдаж өргөжсөн төдийгүй сэргийлэн хамгаалах гранинзон болон өргөжсөн түүхтэй билээ.⁷⁰ Тус хэлтэс 1960-1965 онд хот хөдөөний хэмжээгээр хэв журам сахиулах ажлыг хариуцаж, нийслэлийн 13 хороо аймгийн цагдан сэргийлэх ангийн сэргийлэн хамгаалах байцаагч хотын хороо бүр нэг сэргийлэгчтэйгээр хэв журам сахиулж байв.

“Цагдан сэргийлэх байгууллагын 1963 оны дүрмээр тодорхойлсон нийгмийн хэв журам сахиулах үүргийг дүрэмд заасны дагуу“ гудамж, талбай, цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэг, галт тэрэг, төмөр зам, нисэх онгоцны буудал, үзвэр үйлчилгээний газар, түүнчлэн нам, улс олон нийтээс зохиож байгаа

⁶⁸. Думбурай.А Монгол төрийн цагдаагийн уламжлал түүхэн хөгжилт /нэгдүгээр дэвтэр/ 1999 .,УБ хот. 73 дах тал

⁶⁹. А. Думбарай Монгол төрийн цагдаагийн уламжлалт, түүхэн хөгжилт II боть 38 дах тал

⁷⁰. Хэв журмын тасгийн дарга дэд хурандаа Дондогийн Доржсүрэн байцаагч нь дэслэгч Жигмэдийн Гомбодорж, Харуул хамгаалалтын ахлах байцаагчаар дэд хурандаа Сосорын Жигмэддорж, тасгийн даргаар дэд хурандаа Гэлэгпунцаг нар томилогдон ажиллажээ.

цуглаан, жагсаал, нийтийн зугаалга, биеийн тамирын тэмцээний үед нийтийн хэв журам сахиулах, гал түймэр, усны үер, газар хөдлөлт зэрэг байгалийн гэнэтийн аюул, гоц халдварт өвчин гарсан тухай холбогдох газар байгууллага, иргэдэд мэдэгдэж хохирогч нарт яаралтай тусламж үзүүлж, эд хогшлыг нь хамгаалах, хот суурин газарт ариун цэврийн зохистой байдлыг хангах зэрэг олон зорилтыг улс орон даяар хэрэгжүүлэхээс гадна гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн хэв журам сахиулах талаарх нам засгийн болон орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаадын шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, хорих суллагдсан болон хүмүүжлийн доголдолтой хүмүүсийг АИХТ-ийн 1974 оны 216 дугаар зарлиг ба түүнийг биелүүлэх зааврын дагуу дахин засаж хүмүүжүүлэх, зөвшөөрлийн системийн хэм хэмжээг мөрдүүлэх, эргүүл харуулын албадыг зохион байгуулан удирдах явдалууд байжээ.⁷¹

1970 оноос эргүүлийн машин, явган эргүүл постуудад радио холбоо нэвтэрч эхлэв. Машинтай, холбоотой хөдөлгөөнт эргүүлүүд их хэмжээний газарт үүрэг гүйцэтгэж, хэрэг зөрчлийн газарт богино хугацаанд хүрэлцэн очиж хамгаалах үйл ажиллагаа явуулж байжээ.

Иргэд олон нийтийн байгууллагаас гаргасан саналыг харгалзан нийгмийн хэв журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай АИХТ-ийн 1974 оны 111 дүгээр зарлиг, ууж согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай АИХТ-ийн 1974 оны 120 дугаар зарлиг гарч түүнийг хэрэгжүүлж эхэлсэн нь олон нийтийн хэв журмыг нэг мөр хамгаалахад ач холбогдолтой болсон байна.

Энэ үед эргүүл постын албаны ажлыг Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын сэргийлэн хамгаалах хэлтэс түүний урьдчилан сэргийлэх тасаг, Улаанбаатар хотод Цагдан сэргийлэх газрын сэргийлэн хамгаалах гарнизон түүний урьдчилан сэргийлэх хэлтэс, орон нутгийн анги хэлтсүүдэд сэргийлэн хамгаалах ба урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах ба жинхэнэ байцаагч нар хариуцан зохион байгуулж байв.

1980-1990 онд нийгмийн хэв журам сахиулах ажлын хүрээ улам өсөж байв. Энэ үед Цагдан сэргийлэх байгууллагын сэргийлэн хамгаалах алба нь ЦСЭГ-ын сэргийлэн хамгаалах хэлтэс, дотроо урьдчилан сэргийлэх тасагтай, хэв журам сахиулах, зөвшөөрлийн систем, тусгай байгууллагуудыг хариуцсан ахлах жинхэнэ байцаагч нартай ажиллаж байв.

Улаанбаатар хотын Цагдан сэргийлэх газар нь сэргийлэн хамгаалах гарнизон, дотроо Урьдчилан сэргийлэх хэлтэс, Хэв журам сахиулах тасаг, харуулын тасаг, Эргүүл харуулын хэд хэдэн роттой ажиллаж, Цагдан сэргийлэх байгууллагын харьяа аймаг, хотын районы цагдан сэргийлэх хэлтсүүд сэргийлэн хамгаалах тасаг, ахлах жинхэнэ байцаагч, хэсгийн байцаагч, хамгаалах тасаг, ахлах жинхэнэ байцаагч, хэсгийн байцаагч, хорооны сэргийлэгчтэй ажиллаж, энэ албыг УЦСЭГ-ын 1-р орлогч дарга хариуцан ажиллаж байжээ.

Монгол Улсад нийгэм, эдийн засгийн суурь өөрчлөгдөхөд нийгмийн давхарга бүр шинэчлэгдэж өөрчлөгдсөний дагуу Нийгмийг аюулаас хамгаалах яам гэж байсныг 1990 оны 4 дүгээр сард татан буулгав. Үүнтэй холбоотой Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн дагуу цагдаагийн байгууллагын эрх зүйн орчин ч шинэчлэгдэж эхлэв. Нэгэнт нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж байгаатай

⁷¹ А. Думбарай Монгол төрийн цагдаагийн уламжлалт, түүхэн хөгжилт II боть 42 дах тал

холбоотой нийгмийн байдал, эрүүгийн нөхцөл байдлыг үнэлэх үнэлэмж ч өөрчлөгдсөн байна.

1990-ээд оны эрүүгийн нөхцөл байдал нь цагдаагийн байгууллагад өөрчлөлт шинэчлэлтийг эхлүүлж улмаар эргүүл, харуулын албыг ч мөн өөрчлөн зохион байгуулах шаардлагатай болсон байна.

Цагдаагийн ерөнхий газар нь эрүүгийн цагдаа, хэв журам, мөрдөн байцаах, замын цагдаа, гал түймэртэй тэмцэх, аж ахуй санхүү гэсэн зургаан албатай, дотоодын цэргийн штаб, криминалистикийн шинжилгээний төв, иргэний бүртгэл мэдээллийн төв, дээд сургууль, холбооны анги, цагдан хорих төв гэсэн зургаан байгууллагатай, Цагдаагийн ерөнхий газар нь өөртөө тамгын хэлтэс сургалт боловсон хүчний тасаг хяналт шалгалтын тасаг аж ахуй санхүүгийн албатай харьяа Холбооны хэлтэс эдийн засгийн хэлтэс, III тусгай тасагтай бөгөөд орон нутагтаа Улаанбаатар хотын Цагдаагийн газар Дархан-Уул, Орхон, Төв, Дорнод, Дорноговь гэсэн таван аймагт цагдаагийн газар бусад аймгийн цагдаагийн хэлтэстэй зохион байгуулагдсан байна. Хотын цагдаагийн газар нь харьяа Сүхбаатар Баянзүрх Хан-Уул Чингэлтэй Сонгинохайрхан, Баянгол Налайх Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс Багахангай Гацуурт Био үйлдвэр Жаргалант Дамбадаржаагийн цагдаагийн тасгууд болон хороо дундын цагдаагийн хэсгүүдтэйгээр байгуулагдсан бол хөдөө орон нутагт Зүүнхараа, Хөтөлийн цагдан сэргийлэх тасгуудтай, зарим сум дундын хэсэгтэй байгуулагджээ.

Энэ зохион байгуулалтаар Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын сэргийлэн хамгаалах хэлтэс ба Улаанбаатар хотын сэргийлэн хамгаалах гарнизоныг нэгтгэн хэв журмын асуудлыг төв, хөдөөтэй нь Цагдаагийн ерөнхий газар хэв журмын хэлтэс болгон зохион байгуулсан нь ажлын давхардлыг арилгах зорилтыг агуулсан байна. Хэв журмын алба нь эргүүлийн 801, харуулын 808, Банк хамгаалах суман, Дохиолол хамгаалалтын алба, Насанд хүрээгүй хүмүүсийн хэргээс урьдчилан сэргийлэх тасаг зэргийг удирдаж байхаар зохион байгуулжээ.

Засгийн газрын 2007 оны 346 тоот “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” тогтоолоор нийслэлийн иргэдийг аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх, түргэн шуурхай дуудлагад очих зорилгоор Улаанбаатар хот дахь цагдаагийн эргүүлийн байршилтыг шинэчлэн тогтоож, 24 цагийн горимд шилжүүлэх ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэв.

Уг тогтоолын дагуу ЦЕГ-ын даргын 2008 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 27 тоот тушаалаар Нийслэлийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн амын нягтралыг харгалзан дүүргүүдийн нутаг дэвсгэрт баригдалгүй 4 бүс 50 чиглэлд хувааж “Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газар”-ыг 480 алба хаагчийн орон тоотойгоор 4 хэлтэс, 8 тасгийн зохион байгуулалттайгаар байгуулан даргаар, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэномыг томилж 2008 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Нийслэл хотод эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа машинт болон явган эргүүлийн уялдаа холбоог сайжруулах, эргүүлийн чиглэлийн давхардлыг арилгах, нэгдсэн нэг удирдлагаар хангах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 114 дүгээр тушаалаар дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, Эргүүл хамгаалалтын газрын явган эргүүлийн тасгийн алба хаагчдыг Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газрын мэдэлд

шилжүүлэн, 4 хэлтэс, 16 тасагтайгаар, машинт эргүүлийн 70, явган эргүүлийн 94, нийт 164 чиглэлд 803 алба хаагчийн орон тоотой ажилласан байна.

Цагдаагийн байгууллагын шинэтгэлийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 700 тоот тушаалаар Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газрыг татан буулгаж, үйл ажиллагааг нь дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд шилжүүлсэн байна.

Одоогийн байдлаар Улаанбаатар хотын эрүү, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан 24 цагаар 70 бүс, чиглэлд 70 машинт эргүүл, 100 чиглэлд 200 гаруй явган эргүүл үүрэг гүйцэтгэж, 152 гаруй хэсгийн байцаагч ажиллаж байна.

Орон нутгийн цагдаагийн газар хэлтсүүдэд ч хөдөлгөөнт эргүүл автомашинтай ба явганаар зохион байгуулагдан үүрэг гүйцэтгэж байна.

1.“Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2011оны153 дугаар тогтоолоор цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг нормативыг баталсан.

Тус тогтоолд “15.000 хүн ам тутамд хоёроос доошгүй хэв журмын эргүүл, эргүүлийн нэг чиглэлд хоёр алба хаагч үүрэг гүйцэтгэхээр”, цагдаагийн байгууллагын автомашины хангалт, гүйлтийн жишиг нормативыг “хөдөлгөөнт эргүүлд нийслэлд 15.000 хүн ам тутамд нэгээс доошгүй автомашин” ажиллуулахаар тогтоосон жишиг нормативаас харахад Нийслэлд явган эргүүлийн 95 чиглэлд 190, авто эргүүлийн 75 чиглэлд 600, нийт 170 чиглэлд 790 алба хаагч /офицер 300, цагдаа 490/ шаардлагатай байна. Одоогийн батлагдсан орон тоон дээр авто эргүүлд 19 чиглэл, 76 эргүүлийн офицер, 76 эргүүлийн цагдаа, явган эргүүлд 45 чиглэлд 86 цагдаа, нийт эргүүлийн 64 чиглэлд 76 офицер, 190 цагдаагийн орон тоог шинээр бий болгох тооцоолол гарч байна.

Америкийн нэгдсэн улсын вашингтон хотын цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаа

Америкийн нэгдсэн улс нь нийт 50 муж улстай ба муж болгон өөрийн гэсэн цагдаагийн байгууллагын бэлэг тэмдэг, хууль дүрэмтэй билээ. Энэхүү муж хотуудаас Вашингтон хотын цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаа болон хэрхэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлдэг талаар танилцуулья.

Вашингтон хотын цагдаагийн газар буюу Нийслэлийн цагдаагийн газар/Metropolitan police department/ нь АНУ-н томоохон цагдаагийн газруудын нэг юм. Хууль сахиулах чиглэлээр буюу гудамжинд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 4000 гаруй офицер, цагдаа нар, 500 гаруй арын албаны алба хаагчид ажилладаг байна.⁷² Нутгийн хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага нь бусад албадуудтайгаа үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр хамтарч ажилладаг байна. Нийслэлийн цагдаагийн газар нь дараах эргүүлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байна. Үүнд:

1. Авто эргүүл
2. Морьт эргүүл
3. Дугуйт эргүүл
4. Явган эргүүл

Вашингтон хотын авто эргүүл нь тодорхой хэсэг газруудыг хариуцан авч нэг машин дээр хоёулаа үүрэг гүйцэтгэдэг ба дуудлага мэдээлэл байхгүй үед

⁷² <https://www.tripsavvy.com/police-departments-in-washington-dc-1039549>

тодорхой цэгт машинаа байрлуулж явган эргүүлийн үүрэг гүйцэтгэж тухайн хариуцсан хэсэгт ямар хүн оршин суудаг, ямар байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг талаар байнга судалж, иргэдтэй уулзаж байх үүрэгтэй байна. Нэг ёсондоо манай цагдаагийн байгууллагатай харьцуулан авч үзвэл объект, субъектын судалгааг хийж байгаатай адил байгаа юм.

Морьт эргүүл нь хотын төв хэсгээр үүрэг гүйцэтгэдэг ба ихэвчлэн жуулчдад туслах, алга болсон хүүхдийг эрэн сурвалжлах, иргэдэд цагдаагийн байгууллага талаар мэдээлэл өгөх чиг үүрэгтэй байдаг байна. Мөн тусламж хүссэн хүмүүст тодорхой хэмжээний хүрээнд туслалцаа үзүүлдэг байна.

Вашингтон хотын цагдаагийн газрын нэг гол эргүүл бол дугуйт эргүүл юм. Дугуйт эргүүлийн алба хаагчдын давуу тал нь тусламж ирсэн цагдаагийн алба хаагч дээр хурдан шуурхай очих, гэмт хэрэг, зөрчил үйлдэгчийг хөөх үед ямар нэгэн байдлаар саадгүй, цаг хугацааны хувьд богино байдаг байна. Мөн цагдаагийн газрын өмнөөс иргэдтэй хамгийн ойр ажиллаж байгаа алба хаагчид юм. Тэд үүрэг гүйцэтгэх хугацаандаа сэжиг бүхий иргэдийг шалгах, алга болсон хүүхдийг эрэн сурвалжлах, хотын талаар мэдээлэл өгөх, иргэдэд цагдаагийн үйлчилгээг илүү ойртуулж өгч байдаг байна.⁷³

Тус цагдаагийн газар нь гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг зуны улиралд нутгийн оршин суугчидтай хамтран All hands on deck буюу Бүх гар хамтдаа нэртэй хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Энэ нь нэг ёсондоо цагдаагийн байгууллагын явган эргүүлийн алба хаагчид нь оршин суугчдын хамт эргүүлийн үүрэг гүйцэтгэж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлдэг байна. Хөтөлбөрийн хүрээнд хотын нийт нутаг дэвсгэрт 48 цагийн турш тасралтгүй эргүүлийн үүрэг гүйцэтгэдэг байна.

Мөн Америк нэгдсэн улсын цагдаагийн байгууллагын нэг ажиглалтын хэлбэр бол хяналтын камерын систем юм. 1990 оноос хойш ажиглалтын камерыг хөгжүүлсэн ба одоогийн байдлаар дийлэнх гэмт хэрэг, зөрчлийг хяналтын камераар илрүүлж байна.

Япон улсын цагдаагийн эргүүлийн үйл ажиллагаа

Японы цагдаагийн газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба буюу Community safety Bureau нь Японы улсын нийт нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүлийн үйл ажиллагааг зохион байгуулдаг байна. Японы эргүүлийн үйл ажиллагаа нь эрт дээр үеэс ихтэй ба анх эргүүлийн офицеруудыг Шогу гэж нэрлэдэг байсан байна.⁷⁴

Японы цагдаагийн газрын гэмт хэрэг тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Кобан нэртэй цагдаагийн дэд хэсэг, байруудыг байгуулсан байдаг байна. Кобан нь Японы цагдаагийн газрын чухал амин хэсэг бөгөөд Япон улс даяар нийт 12,000 гаруй Кобан байдаг байна. Энэ нь Японы нийт цагдаагийн хүн хүчний хоёр орчим хувийг эзэлдэг байна. Кобан нь дунджаар 5-7 хүний бүрэлдэхүүнтэй цагдаагийн хэсэг бөгөөд алба хаагчид нь явганаар, дугуйт болон автомашинтай эргүүлийн үүргийг ойр орчмын хариуцсан нутаг дэвсгэртээ гүйцэтгэдэг байна. Кобаны алба хаагчдын үүрэг нь хариуцсан нутаг дэвсгэрт амьдардаг оршин суугчид, үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудын талаар болон гэмт хэрэг зөрчлийн талаар

⁷³ https://mpdc.dc.gov/page/bicycle-patrol-officer-tayna-williams?fbclid=IwAR018kd7VYzN9aheMs1x6Dp1kLOOCiYrRjrVfH0epjeAGviOlf-r-w8X5_k

⁷⁴ <https://doyouknowjapan.com/police/>

мэдээллийг цуглуулах, сэжиг бүхий явж байгаа иргэнийг шалгах, автозамын хөдөлгөөнийг зохицуулах, өсвөр насын хүүхдүүдийг сурган зааварчилах, гэмтэж бэртсэн хүмүүсийг аврах хамгаалах, алга болсон хүүхдийг эрэн сурвалжлах зэрэг байдаг байна. Кобаны алба хаагчид нь ажлын цагаар үүрэг гүйцэтгэдэг ба иргэдэд хамгийн ойр хүрч ажилладаг байгууллага болж чаддаг байна.⁷⁵

Иргэд байгууллагаас ирсэн дуудлага мэдээллийн дагуу ажилладаг алба хаагчийг Олон нийтийн цагдаагийн офицер гэдэг ба тэд 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг байна.⁷⁶ Тэд нарын үүрэг чиглэл нь ерөнхийдөө Кобаны цагдаагийн хэсгийн алба хаагчидтай адил боловч нэг үүрэг чиглэл нь гэмт хэрэгтэй тэмцэх, хэрэгтэнг илрүүлэх баривчлах байдаг байна. Олон нийтийн цагдаагийн офицер нь нэг машин дээр хоёроороо үүрэг гүйцэтгэдэг ба дуудлага мэдээлэл байхгүй үед тодорхой цэгүүдэд зогсож гэмт хэргээс урьдчилан сэргийлдэг байна.

Мөн Японы цагдаагийн газрын нэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь эргүүл ба цагдаагийн офицерууд нь явган, дугуйт, автомашинтай эргүүл хийдэг байна. Энэ нь гэхдээ Олон нийтийн цагдаагийн ажилтнаас өөр чиг үүрэгтэй ба дуудлага мэдээлэл хүлээн авахгүй, зөвхөн эргүүлийн үүргийг гүйцэтгэдэг байна. Үүрэг гүйцэтгэх хугацаандаа сэжиг бүхий явж байгаа этгээдийг шалгах, иргэдэд гэмт хэргийн талаар мэдээлэл өгөх, тэдэнд анхааруулах, өсвөр насны хүүхдүүдэд зөвлөгөө өгөх, алга болсон хүүхдийг хамгаалах ар гэрт нь хүлээлгэн өгөх зэрэг арга хэмжээг авч ажиллуулдаг байна.

Японы цагдаагийн газрын гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нэг томоохон ажил бол хяналтын камерын систем буюу CCTV/Closed circuit TV/ юм. 2000 оноос хойш Япон улс камерын системийг хөгжүүлж ирсэн ба өдгөө хотын гудамжны өнцөг булан бүрт цагдаагийн камер байрлах болжээ. Камер хяналтаар илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийг тэр даруй олон нийтийн цагдаагийн офицер, эргүүлийн офицер, Кобан уруу мэдэгдэж арга хэмжээ авдаг байна. Энэ нь гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд томоохон дэмжлэг туслалцаа болж байгаа юм.

Дүгнэлт

Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзвэл эрт дээр үеэс эхлэн өнөөг хүртэл бүхий л цаг үед улс орныг удирдан захирч ирсэн хаад ноёд болон өнөө цагийн төр засаг хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн цаг үедээ тохирсон өөр өөрсдийн өвөрмөц аргуудыг хэрэглэж ирсэн нь дээрхи өгүүлэлд дурдсан түүхийн улбаанаас харж болохоор байна.

Гагцхүү тухайн үеийн нийгмийн хөгжлөөс шалтгаалан эргүүлийн үйл ажиллагаа нь харилцан адилгүй байдлаар хөгжиж, тэр хэмжээгээр хэв журам сахиулах үйл ажиллагаагаа нийгмийн тогтолцоотойгоо уялдуулан явуулж ирсэн байна.

Монголын цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлийг багасгах нэг арга нь урьдчилан сэргийлэх ажил гэдэгтэй санал нэгдэх хэрэгтэй байгаа юм. Урьдчилан сэргийлэх нэг томоохон ажил нь иргэдэд хууль эрх зүйн талаар мэдээлэл өгөх боловч гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдээд байгаа эмзэг цэг, гудамж, гэр хорооллын айлууд дунд байнгын эргүүлийн үйл ажиллагааг

хэрэгжүүлэх юм. Японы цагдаагийн газар нь ойролцоогоор 259,500 эргүүлийн цагдаагийн ажилтантай ба энэ нь Японы хүн амтай харьцуулахад 5 хүн тутамд нэг цагдаагийн ажилтан ноогдож байгаа юм. Мөн Японы Цагдаагийн байгууллагад нийт 47,500 ширхэг цагдаагийн эргүүлийн машинтай байдаг нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд томоохон түлхэц болж байгаа юм.

Харин Монголын цагдаагийн байгууллага нь 10,000 гаруй цагдаагийн бие бүрэлдэхүүнтэй байгаа нь нийт хүн амтай харьцуулахад харьцангуй бага байгаа юм. Мөн техник технологи, машин механизмын хувьд ч Америкийн нэгдсэн улс, Япон улсын цагдаагийн байгууллагатай харьцуулашгүй бага түвшинд байгааг бид бүхэн мэдэж байгаа билээ.

Манай улс нь цаашид гэмт хэрэг, зөрчлийг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг улам боловсронгуй болгож, техник технологийн орчин үеийн дэвшилийг нэвтрүүлж, алба хаагчдийн тоог нэмэгдүүлэх нэн шаардлагатай байгаа нь энэхүү илтгэлээс харагдаж байгаа юм.

Санал

1. Цагдаагийн хэв журмын алба, тэр дундаа эргүүлийн үйл ажиллагааны арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжлийн чиглэлээр магистрын судалгааны ажил хийлгүүлэх;
2. Үе үеийн хэв журам сахиулж ирсэн эргүүлийн үйл ажиллагааны сонгодог туршлагуудын талаар эрдэмтэн судлаачдын дунд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах;
3. Хэв журмын албаны түүхэн хөгжлийн чиглэлээр эрдэмтэн судлаачдаас бүрдсэн түүхийн ном, сурах бичиг гаргах.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛЖ ИРСЭН ЗАРИМ ТУРШЛАГЫГ НЭВТРҮҮЛЭХ АСУУДАЛ

Б.Мэндбаяр

ХСИС-ийн АШБС-ийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга

Энэхүү өгүүлэлд ардын хувьсгал ялсан цагаас эхлэн манай улсад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулж байсан, түүнийг хэрхэн төр засгаас дэмжиж ирсэн талаар товч өгүүлсэн болно.

Түлхүүр үг: Цагдан сэргийлэх байгууллага, Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригад, Нийгмийн хэв журам

Үндсэн хэсэг

Манай улс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрт дээр үеэс төрөл бүрийн арга, хэлбэрээр хийж ирсэн бөгөөд ардын хувьсгал ялсан нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинэ хэлбэрээр явуулах эхлэл болжээ.

Ардын Засгийн газрын 1921 оны 7 дугаар сард болсон 6 дугаар

хуралдаанаар дэг журам сахиулах, жинхэнэ ард түмний эрх ашгийг хамгаалагч “Сэргийлэх цэрэг”-ийг байгуулсан.

Энэ нь цагдаагийн байгууллагын төдийгүй аливаа хэрэг явдлаас урьдчилан сэргийлэх бодлогын эхлэл болсон юм.

1923 онд Засгийн газрын хуралдаанаар олон түмэнд зориулсан анхны “Ухуулга бичиг”-ийг гаргаж, “Нийслэл хүрээний газар аливаа хүн архи уух, мөрийцөн наадах, хэрүүл шуугиан өдүүлэх, шөнийн цагаар чимээ гаргах, гал усны аюул болох, хулгайлах, булаах зэрэг бүхий л гашуун самууныг цагдан байцаалгах”-ыг олон түмэнд сануулж, “....цаазалсаныг зөрчвөөс цээрлэн шийтгэх” журмыг зөвшин батлан явуулсан байна

Уг журамд “Ямнаас зохих газруудад хүргүүлэн тушаасныг өөр өөрийн харъяат газруудаас олон дор зарлах тул....аливаа ухамсарлан мэдэж, хичээнгүйлэн дагаж явбаас зохимой” гэсэн заалт нь хэрэг явдлаас урьдчилан сэргийлэх, түүгээр ч барахгүй төр, захиргаанаас эхлээд нийт байгууллага, иргэдийн эрхэм үүрэг нь гэж тодотгож өгсөн чухал баримт болсон юм.⁷⁷

Тэр үеэс эхлэн хууль ёсыг сахин биелүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон түмнийг татан оруулах талаар тухайн үеийн нам, төрийн байгууллагуудаас олон чухал арга хэмжээ авч байсан. Улс орны эрүү, хэв журмын нөхцөл байдалтай холбогдуулан цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа дүгнэлт хийж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулахад анхаарч ирсэн.

Хууль хамгаалах байгууллагуудын нэг чухал зорилт бол гэмт хэрэг нэг бүрийг илрүүлж, гэм буруутай этгээдэд зохих хариуцлагыг шударгаар оногдуулахын хамт гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгааныг илрүүлж, цаг тухайд нь арилгуулах замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүх аргаар зохиоход оршино.⁷⁸

Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль зүйн уламжлал, шинэчлэл нэвт шингэсэн, үр өгөөжтэй байх шаардлагатай.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь эдийн засаг, соёл, ёс суртахуун, тухайн нийгмийн түүхэн тодорхой нөхцөл, хүмүүсийн аж амьдралын түвшин, хуулийн хэрэгжилт, улс төрийн удирдлагын чадвар зэрэг олон талын хамааралтай байдаг.⁷⁹

1941 онд МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 41 дүгээр тогтоолоор ардын цагдан сэргийлэхийн ажилд туслах сайн дурын бригадыг байгуулахаар шийдвэрлэж, дагаж мөрдөх журмыг баталсан нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд ард олныг өргөнөөр оролцуулах шийдвэртэй алхам болжээ.

Энэ үеэс эхлэн иргэд, хөдөлмөрчдөөс цагдаагийн байгууллагад идэвхитэй туслах хөдөлгөөн амжилттай өрнөж ирсэний учир, улс орны үндэсний аюулгүй байдал, эрүүгийн нөхцөл байдал тогтворжиж иргэдийн эрх чөлөөг хамгаалах асуудал нэлээд баталгаажиж ирсэн байна.

Төр засгаас дэс дараатай олон арга хэмжээ авсны үр дүнд, Цагдаагийн

⁷⁷ Л. Билгээ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй” УБ. 2005. 11-12 дахь хуудас

⁷⁸ Ж. Авхиа. Гэмт явдал, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал. УБ. 1997. 159 дэх тал

⁷⁹ Н. Гаравсүрэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба Цагдаагийн байгууллага. УБ. 2002. 3 дахь тал

байгууллага жилээс жилд бэхжин, 1947 онд улсын хэмжээнд гэмт хэргийн дөнгөж 50 хувийг илрүүлж байсан бол 1951 онд 74%, 1954 онд 83%, 1958 онд 92 хувийг нь илрүүлдэг болсон байна. Энэ нь улс орны хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх ажил жилээс жилд эрчимжиж байсны илрэл юм.⁸⁰

Энэ үеийн онцлог нь, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил зөвхөн цагдаагийн үүргийн хүрээнд явагдаж байсан байна. Үүнийг өөрчлөх зорилгоор 1960 онд, МАХН-ын Төв Хорооны 170 дугаар тогтоол гарч, хөдөлмөрчдийн дунд хууль сурталчилах олон хэлбэрийн ажил зохиох, гэмт хэрэг, зөрчил гаргаж болзошгүй хүмүүстэй нэг бүрчлэн уулзаж, хүмүүжлийн ажил хийх, эргүүл шалгалтыг хүчтэй болгож, гэмт хэрэг гарч болох байдлуудыг урьдчилан илрүүлж арилгах ажлыг нам, улс, олон нийтийн байгууллага, хөдөлмөрчин олон түмний туслалцаатайгаар зохион байгуулж эхэлсэн байна.

Уг тогтоолд “Ухуулга суртчилгааны ажлыг олон хэлбэрээр зохиох, гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй хүмүүсийг биечлэн ангилах, эргүүл шалгалтын ажлыг хүчтэй болгож, хэргийг илрүүлэн арилгах нь нам, улс, олон нийтийн туслалцаанд түшиглэх ёстой” гэж заасан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хийхэд олон нийтийн туслалцаа авах нөхцлийг нэлээн бүрдүүлж өгсөн байна.⁸¹

Энэ бүхэн нь, улс орны эрүүгийн нөхцөл байдлыг эрүүлжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялангуяа ЦСБТОН /цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийт/-ийн бригад, нөхөрлөлийн ажлыг сайжруулах, гэмт хэргийн эсрэг нийтийн тэмцэл өрнүүлэх боломжийг нээхэд чухал арга хэмжээ болсон юм.

Нам, төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил нь зөвхөн ЦСБТОН бригадын гишүүн бус, бүх ард түмний үйл хэрэг байх ёстой гэж үзэж Ардын нөхөрлөлүүд, Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн төвүүдийг нутаг дэвсгэрээр нь байгуулан ажиллуулсан байна.

ЦСБТОН бригад нь хэв журам, мөрдөн байцаах ажилд туслах, авто техникийн, галын сайн дурын, өсвөрийн сэргийлэгчдийн, залуучуудын, өмч хамгаалах бригад, зөвлөл, бүлэг гэсэн төрөлжсөн хэлбэрүүдэд шилжиж, 40 шахам мянган гишүүдтэй хөдөлмөрчдийн үүсгэл санаачлагын байгууллага болтлоо хөгжин дэвжижээ.

Иймээс тэдний үйл ажиллагааг улам идэвхижүүлэх зорилгоор 1968 онд цагдан сэргийлэх байгууллагад туслах хүчний анхдугаар, 1974 онд Улсын 2 дугаар зөвлөлгөөнүүдийг зохион байгуулан, гэмт хэрэгтэй тэмцэхэд амжилт гаргасан олон зуун гишүүдийг төрийн одон медалаар шагнасны гадна, аймаг, нийслэлд энэ ажлыг мөн зохион байгуулж, үйл ажиллагааг нь идэвхижүүлж байжээ.

Мөн, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд олон түмний оролцоог сайжруулах зорилгоор аймаг, сум, дүүрэг бүрт “Нийгмийн хэв журам хамгаалах төв”-үүдийг байгуулан сум, дүүрэг, хорооны дарга нарыг төвийн даргаар сонгон ажиллуулж байсан нь, гэмт хэрэгтэй тэмцэхэд олон түмнийг татан оролцуулсан шалгарсан аргын нэг байлаа.

Ингэж гэмт хэрэг, зөрчлийн эсрэг нийтийн тэмцлийг өрнүүлэхэд тухайн үеийн нам, төрийн тууштай бодлого, зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж,

⁸⁰ Г. Даштүдэв. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй”. УБ. 2007. 23 дахь тал

⁸¹ Л. Билгээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. УБ. 2005. 11-12 дахь тал

тодорхой арга хэмжээ авч байснаас гэмт хэрэг, зөрчлийг бууруулж ирснийг түүх мартаагүй билээ.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг хүчтэй болгохын тулд хуулийн байгууллагын ажлын уялдааг сайжруулах асуудал цоо шинээр тавигдсан учир 1961 оны 1 дүгээр сарын 14-нд Улсын прокурор, Улсын дээд шүүх, НАХЯ-ны 12, 38, 9 тоот хамтарсан тушаал гаргаж, Намын төв хорооны 1960 оны “Гэмт хэрэгтэй тэмцэхэд намын байгууллагын зорилтын тухай” 170 дугаар тогтоол, мөн онд болсон хуулийн байгууллагын удирдах ажилтны зөвлөлгөөний шийдвэрийг хүч хавсран биелүүлэх тухай нарийвчлан заасан нь зарчмын чухал ач холбогдолтой арга хэмжээ болжээ.⁸²

Ялангуяа 1970-1980-аад оны үед гэмт хэргийн гаралт буурч, жил дунджаар 6000 орчим гэмт хэрэг бүртгэгдэж, хүний амь насыг санаатай бүрэлгэх, хүчин, дээрэм болон бүлэг зохион байгуулалттай гэмт хэргүүд харьцангуй бага гарч, ард олон амгалан тайван амьдарч байсан байна.

МАХН-ын Төв Хорооны 1965 оны 305 дугаар тогтоолоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийг аймаг, хотын намын хороодын дэргэд байгуулан, Намын Төв Хорооны нэг нарийн бичгийн дарга, улсын хэмжээнд хариуцаж байсан байна.⁸³

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэвшмэл байдлаас гаргаж, бүх нийтээр анхаарал тавьдаг болгоход цагдаагийн байгууллага гол санаачлагач байвал зохистой юм.⁸⁴

1992 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд нийгмийн дэг журам хангах түр зөвлөлийг, 1995 онд Засгийн газрын дэргэд тус тус байгуулж, 1996 оноос Засгийн газрын тухай хуулиар Хууль зүйн сайдад уг үүргийг хариуцуулж ирсэн нь тухайн үедээ улс оронд дэг журам тогтоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ихээхэн ач холбогдолтой явдал байсан юм.

УИХ-аас 1997 оны 12 дугаар сарын 5-нд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг батлан гаргасан нь энэ чиглэлээр хийх үйл ажиллагаанд ихээхэн түлхэц болсон юм. Уг хуулийн дагуу зохицуулах зөвлөлүүд нь гурван үе шаттайгаар үүрэг гүйцэтгэх болсон бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч 1998 онд 06, 2001 онд 25 дугаар зарлигаар Зохицуулах зөвлөлийн бүрэлдхүүн, ажиллах дүрмийг баталж ажиллуулж эхэлсэн бөгөөд зохицуулах бүх шатны зөвлөлүүд тодорхой үүрэг гүйцэтгэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улам идэвхижүүлж, ялангуяа цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албаны бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгоход ихээхэн анхаарсан байна.

Дээрх арга хэмжээний хүрээнд, цагдаагийн байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, төв орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтны орон тоог баталж, зарим аймаг, хотод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийг байгуулж, эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн байна.

Захиргааны урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь, албадах замаар гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс сэргийлэх, эрх зүйн эсрэг нөхцөл байдал бүрдүүлэхгүй байхад чиглэгддэг захиргааны албадлагын бие даасан анхдагч

⁸² Г. Даштүдэв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. УБ. 2007. 23 дахь тал

⁸³ Ц. Бужинлхам, С.Наранбулаг. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил ба прокурорын байгууллага. УБ. 1884. 65 дахь тал

⁸⁴ Н. Гаравсүрэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба Цагдаагийн байгууллага. УБ. 2002. 3 дахь тал

төрөл юм.⁸⁵

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн туслалцааг авч ажиллах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Хэв журам хамгаалах газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийг өөрчлөн “Олон нийттэй харилцах хэлтэс” болгон өөрчилж, ажлын чиг үүргийг тодорхойлж өгсөн.

Цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэдэд ойртуулах, тэднийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд оролцуулан хамтран ажиллах чиглэлээр Монголын нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-тэй хамтран “Цагдаа-иргэд олон нийтийн хамтын ажиллагаа” төслийг 2000-2005 онд хэрэгжүүлсэн билээ.

Энэ төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх ажлын материаллаг баазыг сайжруулан техник, хэрэгслээр хангах, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, ухуулга, сурталчилгааны ажил явуулах, иргэд, төрийн захиргааны албан хаагч, цагдаагийн байгууллагын алба хаагчдын дунд эрх зүйн сургалт явуулах зэрэг ажлыг үе шаттай хийсэн нь ихээхэн үр дүнгээ өгсөн байна.

Энэ нь Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг өөрчлөн шинэчилж, эрх зүйн харилцааг боловсронгуй болгох, цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, цагдаагийн үйл ажиллагааг олон нийтэд ойртуулах, цагдааг олон түмний дотор үйлчилдэг, үйлчилгээний байгууллага болгон төлөвшүүлэх эхлэл тавьж байгаа юм.

Тухайлбал: 1997 онд Монгол Улсад гарч буй гэмт хэрэг, түүний дотор хулгайлах гэмт хэргийн гаралтыг судлан дүгнэлт хийж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд, цагдаагийн байгууллага түлхүү анхаарч ажилласнаар хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд нэлээд ахиц, өөрчлөлт гарсан билээ.

2001 онд хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийг Эрүүгийн цагдаагийн газрын бүтцээс гаргаж, хэв журмын албаны бүтцэд оруулан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтууралтай тэмцэх, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгуудтайгаар шинээр байгуулж, улсын хэмжээнд үйл ажиллагааг нь явуулж байна.

Засгийн газраас батлан гаргасан, “Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Хар тамхи, мансууралтай тэмцэх хөтөлбөр”-үүдийг санаачлагч нь цагдаагийн байгууллага байсны дээр 2005 оныг дуустал хугацаанд хэрэгжих явцад цагдаагийн мэргэжлийн албадын хүч, анхаарлыг төвлөрүүлж ажиллаж байсан байна.

Гэмт хэрэг гэдэг бол нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд хэзээ ч устаж үгүй болохгүй аль ч нийгэмд байсаар ирсэн түүхтэй. Түүний гаралтыг зөнд нь орхих бус харин түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй үр дүнтэй хэлбэрээр явуулах ёстой бөгөөд ялангуяа нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжид, цагдаагийн байгууллагын нийт албадыг төлөөлөн үүрэг гүйцэтгэж байгаагийн хувьд хэсгийн байцаагч нар, хамгийн их үүрэг хариуцлага хүлээдэг.

Өнөөдөр, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай”⁸⁶ Монгол Улсын

⁸⁵ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 202 дахь тал

хуулийн 3.12.1-д “Нутгийн захиргааны байгууллага, харъяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахдаа иргэдийг дараах хэлбэрээр татан оролцуулахыг хуульчлан заасан байна. Энэ нь, хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлаа явуулах, түүнд иргэдийг татан оролцуулахад гол эрх зүйн үндэс болж байна. Үүнд:

1. Иргэдийг нийтийн эргүүлд гаргах
2. Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрийг томилох
3. Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчаар ажиллуулах” зэрэг болно.

Тодорхой нутаг дэвсгэрт ажиллах хэв журмын урамшилтай эргүүл, жижүүр, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийн тоо, урамшуулалын хэмжээг хүн амын нягтрал, хэв журмын зөрчлийн гаралтаас хамааран сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил тутам тогтоож байна.

Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон торгох ял ноогдуулж, төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулах тухай заалтыг орон нутгийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад зөвөөр ойлгуулж, зохих журмын дагуу гаргуулан авч, оновчтой зарцуулж чадсан эсэхээс ихээхэн зүйл шалтгаална.⁸⁷

Үүний зэрэгцээ иргэн нь, оршин суугаа болон ажлын газрынхаа зохиогдож буй эрх зүйн ба хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд оролцоно. Мөн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын энэ чиглэлийн ажилд санаачлагаараа, эсхүл тэдний хүсэлтээр хууль сахиулах ажиллагаанд туслалцаа үзүүлнэ⁸⁸ гэсэн заалт ихээхэн хүч дэмжлэг болдог. Харин эрх зүйн боломжийг манай хэсгийн байцаагч нар хэрхэн яаж ашиглахаас хамаарч, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө тодорхой болдог.

Түүнээс гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг судлаачид хэд хэдэн төрөлд хуваан үздэг байна. Үүнд:

1. Ерөнхий арга хэмжээ
2. Тусгай арга хэмжээ
3. Нэг бүрчилсэн арга хэмжээ

Ерөнхий арга хэмжээ: Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртхуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ гэнэ.

Эдгээр арга хэмжээнүүд нь, иргэдийн аж байдлыг дээшлүүлэх, нийгмийн тодорхой үе шатны хөгжилтэй түүхэн ёсоор нөхцөлдсөн зарим зөрчлийг зөөлрүүлэх, нийгмийн анги, бүлгийн ялгааг арилгах, ардчилалыг гүнзгийрүүлэн хөгжүүлж, олон түмний идэвхийг өрнүүлэх, соёл, боловсролын түвшин, ухамсрыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ. Дээр дурдсан арга хэмжээнүүд гэмт явдал, гэмт хэрэгтэй тэмцэхэд шууд чиглэгдээгүй боловч нийгмийн үзэгдэл болох гэмт явдлыг арилгах, даван туулах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлогын хэмжээнд шийдэгддэг асуудал юм..

⁸⁶ “Төрийн мэдээлэл” 1998 он №1

⁸⁷ Г. Даштүдэв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй”. УБ. 2007. 36 дахь тал

⁸⁸ Ж. Долгорсүрэн. Монгол улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 262 дох тал

Ерөнхий арга хэмжээг авч үзэхдээ гэмт хэргийн гаралтанд хүчтэй нөлөөлж байгаа суурь шалтгаануудыг арилгахад чиглэсэн цар хүрээтэй томоохон судалгаа, шинжилгээнд тулгуурлан, улс орныхоо эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, ажлын байрыг олноор буй болгох, соёл, гэгээрлийн ажлыг өөрчлөн сайжруулах, иргэдийн соёл, ёс суртахуун төлөвших орчинг бүрдүүлэх, архидан согтуурах явдлыг багасгах зэрэг ажлуудыг хийж чадвал гэмт хэргийн гаралт цөөрөх үндэстэй. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгахад чиглэгдсэн, эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээг түлхүү анхаарч үзэх ёстой.⁸⁹

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ: Энэ нь тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл байдлыг арилгахад шууд чиглэгдэнэ. Уг арга хэмжээ нь ерөнхий урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс ялгаатай нь гэмт хэрэгт нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйлсийг таслан зогсооход чиглэгдсэн байдаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ нь, гэмт явдалд нөлөөлөх хүчин зүйлүүдийн шинж байдлаас шалтгаалахгүйгээр зохион байгуулагдана. Тусгай арга хэмжээ нь, гэмт явдалд нөлөөлж буй хүчин зүйл /үзэгдэл, үйл явц/, тэдний байдал, бүтэц, шинж чанараас шалтгаалж, нутаг дэвсгэр, аж ахуйн салбар, объектод нөлөөлөх нөлөөллийн хэр хэмжээг харгалзан түүний онцлогийг тусгаж зохион байгуулагдана.

Энэ арга хэмжээний хүрээнд, тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоож, арилгахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдагаараа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд чухал байр суурь эзэлдэг.

УИХ, Засгийн газраас энэ бүхэнд дүгнэлт хийж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ихээхэн анхаарал тавьж, хэд хэдэн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал: Монгол Улсын Засгийн газраас “Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх” /2002 он/, “Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр” /1999 он/, “Хар тамхи, мансууралтай тэмцэх” /2000 он/, “Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” /2000 он/ зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байжээ.

Мөн УИХ-аас “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр” /2003 он/, Монгол Улсын Засгийн газраас “Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол /1994 он/, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” /2000 он/, “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай” /2003 он/ Монгол Улсын хуулиудыг батлан гаргаж мөрдүүлсэн нь улс орны хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн байна.

Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг түүний эзлэх байр, цар хүрээ, хэмжээгээр нь:

А. *Улс орны хэмжээний*

Б. *Тодорхой нутаг дэвсгэрийн*

В. *Нийгмийн их бага тодорхой бүлгийн /жишээ нь насанд хүрээгүй хүмүүс, шилжин суурьшигчдын дунд явуулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ/*

⁸⁹ Н. Гаравсүрэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба Цагдаагийн байгууллага. УБ. 2002. 4 дэх тал

Г. Нийгэмд хариу зан төлөвтэй болох нь тогтоогдсон тодорхой хэсэг этгээдэд чиглэгдсэн /согтууруулах ундааны зүйлийг хэтрүүлэн хэрэглэгчид буюу архаг архичид гэх мэт/

Д. Тодорхой нэг гэмт этгээдээс үйлдсэн хэргийн шалтгаан нөхцлийг арилгахад чиглэгдсэн нэг бүрчилсэн арга хэмжээ- нүүд хамаарна.⁹⁰

Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны нэг гол хэсэг бол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ юм.

Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэдийгээр гэмт явдлын шалтгаан нөхцөлтэй шууд холбоотой тайлбарлагдах боловч, түүний үндсэн шинж байдлыг нэг бүрчилсэн түвшинд авч үздэгээр нийгмийн нийтлэг ба криминологийн тусгай арга хэмжээнээс ялгагдаж, гэмт хэрэг үйлдсэн тодорхой этгээдийн зан төлөвт идэвхитэй нөлөө үзүүлнэ.

Нэг бүрчилсэн арга хэмжээг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргаж болзошгүй этгээдийн гэмт зан төлөвийн элдэв илрэлээс хамгаалах хэрэгсэл болгон оновчтой ашиглах явдал онцгой ач холбогдолтой.

Энэ арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх гол үндэс нь хүмүүжлийн буюу албадах аргыг зөв хослон хэрэглэх боломж нөхцлийг бүрдүүлэн бий болгоход оршино. Нөгөө талаар, зөвхөн гэм буруутны зан төлөвт оршин буй сөрөг үзэл бодлыг төдийгүй, түүний үүсч бий болох, төлөвшин бэхжихэд нөлөө үзүүлдэг орчны тааламжгүй нөхцлүүдийг арилгахад чиглүүлэх ёстой юм.

1990-ээд оноос хүүхдүүд гэр орноосоо дайжин тэнүүчлэх, сургууль завсардах, гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэх явдал нэлээд газар авч хараа хяналтгүй тэнүүчлэх нь нийслэл хот болон төмөр зам дагуух аймгуудаас дэлгэрч улмаар нийгмийн шинжтэй болон бараг бүх аймгуудыг хамарч 3000-аад хүрч тэдний 80% нь Улаанбаатар хотод байгаагийн 30% нь охид байна.

Энэ үед төр засаг ирээдүйд чиглэсэн зоригтой алхмууд хийхээс өөр аргагүйд тулсан. Зөвхөн олон нийтийн үүсгэл санаачилгад тулгуурлан, цөөн тооны хүүхдийн байгууллагадаа найдаж, гэмт хэрэг өдүүлснийг нийгмээс тусгаарлах замаар энэхүү ярвигтай асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

Насанд хүрээгүй хүмүүсийг иргэдийн хүрээнд хэрэв боломжтой бол гэр бүлийн хүрээнд дахин хүмүүжүүлэх, өөрийн хувь нэмрийг оруулах сайн дурынхан, сайн дурын байгууллага, нутгийн захиргааны байгууллага, иргэдийн үүсгэл санаачлагын бусад албадыг татан оруулж, тэдгээр байгууллагатай хамтран ажиллах ажиллагааг зохион байгуулалттай тогтмол явуулах талаар төр засгаас шинэ эрхийн акт, шийдвэр гаргаж ажиллах явдал чухал болж байна. Хүн амын 45 хувийг 15 хүртэлх насны хүүхэд өсвөр үеийнхэн эзэлж байгаа өнөө үед төр, засгийн тодорхой бодлого, чиглэсэн дорвитой ажил илт үгүйлэгдэж байна.

Төрийн үйл ажиллагааны залгамж чанар энд бас илэрч, авах, гээхийн сургаал ч үйлчлэх учиртай. Өнгөрснийг эргэн харвал 1942 онд Улсын бага хурлын ҮШ тогтоолд "Хүүхдийг хараа хяналтгүй явуулахыг хориглосугай" гэж тэмцэж байсан уламжлалтай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид 1964 онд "Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комиссын дүрэм" нэртэй хууль цаазын тусгай акт батлан гаргаж сум, хороо, аймаг, хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны дэргэд

⁹⁰ Л. Билгээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн ажлын арга зүй. УБ. 2005. 35 дахь тал

нэр бүхий комиссыг байгуулан ажиллуулж байжээ. Уул дүрэм нь 1992 оны Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар төрийн байгууламж өөрчлөгдөх хүртэл 30-аад жил мөрдөгдөж байжээ.

Дүрэмд комиссын үндсэн зорилтыг "Хүүхдийг хараанаас гадуур байлгах явдалтай тэмцэх, тэдний эрхийг хамгаалах, хууль ёс, нийгмийн хэв журам зөрчих явдлаас урьдчилан сэргийлэхэд оршино" гэж тодорхойлоод комисс байгуулах журам, комиссын эрх, үүрэг, авч хэлэлцэх хэрэг зөрчил, буруутай хүмүүст авах арга хэмжээ, хэрэг үүсгэх болон шийдвэрлэх явцын журмыг заан тогтоосон байна.

Энэ дүрмээр сум, хорооны комиссоос хүүхэд нь зөрчил гаргасан эцэг эх, тэднийг төлөөлсөн хүмүүст авах арга хэмжээг заасны дотор "Хүүхдээ хүмүүжүүлэхээс зайлсхийсэн буюу эрхээ хортой буруу ашигласан эцэг, эхийн тухай, тэдний эцэг буюу эх байх эрхийг нь хасуулах асуудлыг комиссоос шүүхэд тавих эрхтэй" гэж заажээ.

Бас хүүхдийг хүмүүжүүлэх тусгай байгууллагад шилжүүлэхдээ шаардлагатай бол зардлыг эцэг эхээс гаргуулах эрхтэй бөгөөд торгууль, төлбөр, зардлын комиссын шийдвэрийг шүүхийн тогтоол гүйцэтгэгчээр дамжуулан үг дуугүй биелүүлэх журамтай байжээ.

Энэ дүрэмд хүүхдийн эрх ашигтай холбоотой зөрчлийг илрүүлэх, авч үзэж шийдвэрлэх олон заалт байгаагийн дотор тэнэмэл хүүхдийн учир зүйг олох арга ажиллагааны баримжаа болохуйц санаа оноо ч цөөнгүй байна. Бидний бодоход хууль тогтоомжийн энэ акт урт настай байж болох байсан. Харамсалтайгаар хэлэхэд гагцхүү төрийн тогтолцоо өөрчлөгдсөн цагийн эрхээр мөрдөх гол эзэн /НХХХЭК/ нь сум, хороо, аймаг, хотын АДХ, тэдгээрийн гүйцэтгэх захиргааны хамтад байхгүй болжээ. Шүүмжлэлтэй хандахад харин хууль тогтоомжийн энэ чухал сайн актыг дагаж мөрдсөн ажиллагаа гурван арван жилд хүссэн үр дүнд хүрээгүй. Энд хоёр хүчин зүйл нөлөөлсөн байна.

Нэгдүгээрт: Хүүхдийн эрх ашгийг хохироосон зөрчил харьцангуй бага гардаг байсны дээр илрэх, илрүүлэх явдал түвэгтэй байсан.

Хоёрдугаарт: Комиссын сонгуультан, захиргаа, бусад холбогдох байгууллагын ажилтан идэвхтний хууль цаазын мэдлэг, ажлын дадлага дутагдалтай холбоотой байсан юм.

Ийнхүү бий болсон шинэ нөхцөлд тэнэмэл хүүхдийн асуудлыг зохистой шийдвэрлэхийн хамт цаашид тэнэмэл хүүхэд нэмэгдэж гарахаас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих. Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх /орон тооны бус/ зөвлөлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дэргэд байгуулж төрөөс хүүхдийн төлөө авч байгаа бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлж яам, засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага, аж, ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж хамтран ажиллахыг цаг үе, амьдрал шаардсан байна.

Монгол улсын Засгийн газрын 1999 оны 229-р тогтоолоор "Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр" батлагдснаар хүүхдийн эрх ашгийг хамгаалах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дэргэд насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх /орон тооны бус/ зөвлөл байгуулагдсанаар хариуцах эзэнтэй хариуцлагын тогтолцоо бий болсон юм.

Хүүхдийг сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх, эмзэг бүлгийн хүүхдийг сургуульд тогтоон барих талаар боловсролын байгууллагаас бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй. 1990 оноос хойш нийгмийн халамжийн үйл ажиллагааг явуулахдаа сургуулиас салангид халамжийн төвийг түшиглэсэн үйл ажиллагаа явуулж байсан нь зарим талаар сургууль завсардалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн гэж үзэж болох талтай.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид “18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ”, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хуульд “Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ” гэж тодорхойлсон. Хүүхэд гэмт хэрэг үйлдэж, гэмт хэргийн халдлагад өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирсоор байна. Сүүлийн 4 жилд хүүхдүүдээс 2874 гэмт хэрэг үйлдэж, гэмт хэргийн улмаас засаг захиргааны нэгж болох багийн хүн амтай тэнцэх тооны хүүхэд нас барж, сумын хүн амтай тэнцэх тооны хүүхдийн эрүүл мэнд хохирчээ.

2007-2010 онд гэмт хэргийн халдлагад 4342 хүүхэд өртөж, тэдгээрийн 434 буюу 10.0 хувь нь нас барж, 2473 буюу 57.0 хувь нь гэмтжээ.

Өнөөдөр хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сүүлийн үед төр засаг, цагдаа, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудаас тодорхой ажлуудыг санаачлан хийж байгаа билээ. Тухайлбал, 2011 оны 3 дугаар сард “Хүүхэд насаа хайрлая” зөвлөгөөнийг улсын хэмжээнд зохион байгуулж, энэ үеэр Монгол Улсын Шадар сайд, дэлхийн зөн олон улсын байгууллага, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, өмгөөллийн байгууллагууд хамтран ажиллахаар санамж бичиг байгуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Уг санамж бичигт гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, гэмт хэргийн халдлагад өртсөн хүүхдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж, шалтгаан нөхцөлийг судлан, урьдчилан сэргийлэх арга хэмжээний санал боловсруулах ажил тусгагдсан юм.

Цагдаагийн байгууллага төрийн болон төрийн бус байгууллагатай байнга хамтран ажиллаж байгаа ба “Хүүхдийн асуудлаар 2012 он хүртэл төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах хөтөлбөр”, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай 3 жилийн хугацаатайгаар хамтран ажиллах гэрээ байгуулан, хүүхдийн гэмт хэргийн талаарх мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, зөвлөмж, сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг хийх, хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэхийг уриалах, сургуулийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах зэрэг ажлууд хийж байна.

Дүгнэлт

Ардын хувьсгал ялсан цагаас эхлэн манай улсад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж ирсэн байна. 1940 оноос 1980-аад оны үед иргэдийн нийгмийн сэтгэлгээний хандлага нь хүн бүр ажил хөдөлмөр эрхэлж, гэмт хэрэг, зөрчил байх ёсгүй гэсэн үзэл баримтлал дээр тулгуурлаж байснаас үүдэлтэй юм.

Нөгөө талаараа иргэдийн цагдаагийн байгууллагад туслах олон нийтийн хөдөлгөөн эрчимтэй өрнөж, “Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригад” нэртэй сайн дурын нэгдлүүд олноор байгуулагдсан байдаг.

Мөн тэдний дэмжлэг тусламжтайгаар гэмт хэрэг, зөрчил олныг илрүүлэн шийдвэрлэж байсны зэрэгцээ захиргааны хяналтыг сайн тавьж байсан нь гэмт

хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг ихээхэн хөнгөвчилж байжээ гэж дүгнэж байна.

Санал

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ирсэн уламжлалт туршлагыг ашиглан дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Иргэдийн оролцоонд тулгуурласан “Цагдаагийн байгууллагад туслах олон нийтийн бригад”-уудыг томоохон аж ахуйн нэгжүүд дээр байгуулах замаар аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх;
2. Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус комиссыг нутаг нутгийн захиргааны байгууллага буюу Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд байгуулах замаар иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
3. “Цагдаагийн байгууллагад туслах олон нийтийн бригад”-ын үйл ажиллагааны чиглэл, эрх, үүрэг, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын загварыг шинэчлэн боловсруулж, туршилтын журмаар хэрэгжүүлэх;

СЭТГЭЛ СУДЛАЛЫН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИЙН

СЭТГЭЛ ЗҮЙ

(Хүүхдийн жишээн дээр)

П.Цагаандарь

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн ахмад

Товч утга

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч тэр дундаа дам хүчирхийлэлд өртгөж буй хүүхдийн сэтгэл зүй, түүний онцлог, хүчирхийлэл үйлдэгдэх учир шалтгаан, хүчирхийллийн улмаас үүсэх үр дагаварын талаар энэхүү нийтлэлдээ авч үзэв.

Түлхүүр үг: Гэр бүл, хүүхэд, хүчирхийлэл, дарамт, хүүхдийн сэтгэл зүй

Аливаа улсын хөгжил цэцэглэлт ирээдүй хүүхдээс хамаардаг. Тухайн хүүхэд ямар орчинд сурж хүмүүжин тэр төлөвшил нийгэмд нөлөөлж тухайн улсын хөгжил шалтгаалдаг. Хүний хүмүүжлийн анхдагч суурь нь гэр бүлийн хүмүүжил, эцэг эхийн зан төлөв, тэдний хоорондын харилцаан дээр үндэслэгдэж тогтдог. И.Кант “Гэр бүл нь нийгмийн хөгжлийн анхдагч бичил орчин бөгөөд хууль ёсоор харилцах буюу хууль ёсны гэрээ юм”⁹¹ гэж тодорхойлсон байдаг. Бие хүн үзэл бодол, хүмүүжлийнхээ 80 хувийг гэр бүлийн орчинд байхдаа олж авдаг гэж үздэг. Бие хүн гэдэг нь янз бүрийн нөхцөлд

⁹¹ Батцэнгэл Г., Баньдхүү Б, “Гэр бүлийн сэтгэл судлал”, УБ., 2016..11 дэхь тал

хүний зан үйлийн илрэх сэтгэл зүйн бүх чанарыг багтаасан иж бүрэн цуглуулга юм.⁹²

Гэр бүл дэх хүмүүжлийн буруу нөлөө, эцэг эхийн хайр халамж дутах, хүүхдийг гэр орноосоо дайжихад хүргэх нь хүүхэд хүмүүжлээр доголдох, зан авир нь эвдрэх үндэс болдог. 1990-ээд оноос хойш манай нийгэмд Гэр бүлийн хүчирхийлэл нь нэлээд яригдах болсон.

Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг бол хэн нэг нь бусад гишүүдээ хэмжээ хязгааргүй эрх мэдэл хяналтаа тогтоож, айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх замаар зориудаар үүсгэж байгаа олон төрлийн түрэмгийлэл, дарамтууд юм.⁹³ Гол төлөв хүүхэд эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийллийн үндсэн хохирогчид болж байдаг.

Гэр бүлд нь хүчирхийлэл газар авсан, хэрүүл зодоонтой айлын гишүүд гэмт хэрэг үйлдэх магадлал өндөртэй. Хүн хүүхэд насандаа сэтгэлдээ тусгаж авсан зүйлээ том болсон хойноо өөрийн зан төлөвт сэргээн буулгаж байдаг. Иймд манай улсад гэр бүлийн хүчирхийллийн улмаас хэр их хүүхэд хохирч, гэмт хэрэгтэн бие хүн болох магадлалтай байгааг өнөөгийн нийгмийн байдлаас харж болно.

Дэлхийн бараг бүх улс оронд эцгийн эрхт ёс ноёрхож байгаатай холбоотой хүчирхийллийн хохирогчид нь ялангуяа эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл байсаар байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар *гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэж* гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ.

Гэр бүлийн хүчирхийлэл бол нийгмийн үзэгдэл бөгөөд нийгмийн бараг бүх давхаргыг хамардаг. Хэдийгээр гэр бүлийн хүчирхийлэл нийгэмд түгээмэл тохиолддог ч ихээхэн нуугдмал байдлаар оршисоор байна. Иймээс түүнийг илрүүлэхэд амаргүй байдаг ба ойр дотны хүмүүсдээ зовлон шаналалд учруулж, сөрөг үр дагавар нь удаан үргэлжилдэг байдлаараа гэр бүлийн хүчирхийлэл бол нийгмийн хурц асуудлын нэг болсоор байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд хүүхдүүд хамгаалах байранд ирж, түр хугацаанд сэтгэл зүйн болон аюулгүйн байдлын дэмжлэг, туслалцаа авдаг боловч хохирсон иргэд бүгд хамрагдах боломжгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл дотор хүүхдийн эсрэг хүчирхийлэл гол байр суурь эзэлдэг.

Хүүхдэд гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харьцах анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөлжих зэрэг бие махбодь, сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэрийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж, хүүхдийн эрхийн конвенцид тодорхойлсон байдаг.


Манай улсад 2004 оноос хойш өнөөг хүртэл хэрэгжиж буй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн найруулан, илүү боловсронгуй болгож өргөн барьсныг 2016 оны 12 сарын 22-нд УИХ-ын чуулганаар баталснаар дээрх хууль 2017 оны 2 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг болзошгүй аюул эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үүднээс “Түр хамгаалах байр” байгуулан ажиллаж байна.

⁹² Батсайхан Б., Дэлгэржав М., “Ерөнхий сэтгэл судлал”, УБ., 2013. 242 дахь тал

⁹³ Эрдэнэчулуун Д., “Гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө”, УБ., 2012. 114 дэхь тал

Ингээд сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийллээр бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хохирсон иргэдийн тоог насны ангиллаар нь авч үзье.⁹⁴

График №1. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



Дээрх судалгаанаас үзэхэд 2014 оноос эхлэн гэр бүлийн хүчирхийлэлийн гэмт хэргийн тоо эрс өссөн байна. Энэ нь нэг талаас энэ гэмт хэргийг үйлдэх хүмүүсийн тоо эрс өссөн сөрөг үр дагавартай байгаа бол нөгөө талаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тэмцэл нэмэгдэж түүний эсрэг чиглэсэн арга хэмжээнүүд сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь нуугдмал гэмт хэрэг ил болсонтой салшгүй холбоотой.

График №2. Улсын хэмжээнд хүчирхийлэлд өртөж хохирсон хүүхдийн судалгаа



Дээрх судалгаанаас үзэхэд 2014 оноос эхлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон хүүхдийн тоо өмнөх онуудынхаас эрс өсөж, буурсан үзүүлэлтгүй байна. Үүнээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй хүүхдүүдийг анхааралдаа авч тэдний сэтгэл зүйн байдал, өөрчлөлтийг судлах шаардлагатай байна.

Судалгаанаас үзэхэд хохирсон хүүхдүүдийг анхааралдаа авах цаг болоод шаардлагатай байна. Хүн хүүхэд насандаа сэтгэгдээ тусгаж авсан зүйлээ том болсон хойноо өөрийн зан төлөвт сэргээн буулгаж байдаг гэдгийг гэмт хэрэгтэн бие хүний талаарх сэтгэл зүйн тодорхой судалгаанууд харуулж байдаг.⁹⁵ Үүнийг баталсан нэг судалгаа бол АНУ-ын сэтгэл судлаач Альберт Бандурагын хамгийн алдартай судалгаа болох “БОБО хүүхэлдэй”-дээр явуулсан судалгаа батлан харуулж байдаг.

1963 онд тэрээр өөрийн хамтран зүтгэгч нарын хамт насанд хүрсэн том хүмүүсийн хүчирхийллийн хэлбэрийн үйлдлүүдийг хүүхдүүд хэрхэн хүлээн авч тэдний сэтгэл зүйд хэрхэн нөлөөлж, зан үйлд ямар өөрчлөлт орохыг судлахад чиглэгдсэн. Стенфорд их сургуулийн харьяа цэцэрлэгээс 3-5 насны 36 эрэгтэй, 36 эмэгтэй хүүхэд судалгаанд хамруулан, хүүхдүүдийг 4 том бүлэг болгон хувааж, эхний бүлэгт бодит амьдрал дээр хүч хэрэглэсэн үйлдэл гаргаж байсан бол, 2 дахь бүлэгт хүч хэрэглэсэн үйлдэл бүхий кино үзүүлсэн ба хамгийн сүүлийн 3 дахь бүлэгт харин хүч хэрэглэсэн хүүхэлдэйн кино үзүүлсэн бол 4 дүгээр бүлгийн хүүхдүүдэд хүчирхийллийн талаар огт үзүүлээгүй ба энгийн тайван орчинд хүүхдүүдийг тоглоомуудаар нь тоглуулж байсан.

Гарсан үр дүн:

Судалгааны 1 дүгээр багийн хүүхдүүдийн дунд судлаач орж тодорхой хугацаанд БОБО гэх хүүхэлдэйг зодож, цохиж үзүүлж байсан ба хүүхдүүд энэхүү үйл явцыг анхааралтай ажиглаж байв. Судалгааны ажилтан хүүхэлдэйг цохихоо больж хүүхдүүдэд шилжүүлэхэд хүүхдүүд том хүнийг үйлдэл бүрийг дууриаж, БОБО гэх хүүхэлдэйг зодож, цохих үйлдэл хийсэн.

Судалгааны 2 дугаар багийн хүүхдүүдэд 10 минутын турш БОБО хүүхэлдэйг зодож, цохиж байгаа киног үзүүлсэн байна.

Судалгааны 3 дугаар багт БОБО хүүхэлдэйг хар муур хэрхэн цохиж, маажиж байгаа талаар 10 минутын хүүхэлдэйн кино болгон үзүүлсэн.

Судалгааны хариу:

Судалгаанд оролцсон бүх хүүхдүүдийг нэг танхимд оруулж тоглуулахад 1,2,3 багийн хүүхдүүд тоглоомоороо тоглохдоо илт хүч хэрэглэсэн, цохиж, зодох гэх зэрэг уур уцаартай байдал ажиглагдаж байсан бол 4 дүгээр багийн хүчирхийллийн үйлдэл үзүүлээгүй хүүхдүүд тайван, ямар нэг хүч хэрэглэсэн байдал үзүүлэхгүй байсан. Иймд хүүхдүүд гадаад орчноос бие хэрхэн авч явах талаар мэдээлэл авч түүнийгээ даган дууриадаг нь илт тодорхой байна. Том хүний гаргаж байгаа үйлдэл болон олон нийтийн сувгаар хүлээн авч үзэж байгаа мэдээллийг өөр дээрээ шууд тусган авч даган дууриадаг нь энэхүү судалгаагаар нотлогдсон учир гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдүүд нь ирээдүйн хүчирхийлэгчид болох магадлалтай.

Санал:

1.Эцэг эх, асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгчийн зүгээс хүүхдэд зөв үлгэр жишээ өөрийн бие, үйлдлээрээ харуулж мөн хүүхдийн үзэж байгаа хүүхэлдэй, олон нийтийн суваг, цахим хэрэглээ, найз нөхдийн хүрээлэлд анхаарал тавих.

2.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн судалгааг гаргаж, тэдэнд улсаас үнэ төлбөргүй сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх. Ингэнээр

⁹⁵ Жанцан Н., “Криминологи”, УБ., 2000.58 дахь тал

ирээдүйн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болохоос урьдчилан сэргийлэх боломжтой.

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ ПРАКТИК

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ИРГЭН АЛБАН ТУШААЛТНЫ ҮҮРЭГ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Б.Зоригт

ХСИС-ийн АШБС-ийн магистрант,
цагдаагийн хошууч

Замын хөдөлгөөний аюулгүй байдал гэж замын хөдөлгөөнд оролцогчдыг зам тээврийн осол, зөрчил, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдлыг ойлгоно.

Зам тээврийн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг хэлнэ.

Эд материалын хохиролтой зам тээврийн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтээх, ачаа болон бусад эд материалын хохирол учруулахыг хэлнэ.

Хүн гэмтсэн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн буруу хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирохыг хэлнэ.

2018 оны эхний 7 сарын байдлаар Бүртгэгдсэн нийт зам тээврийн ослын 88.8 хувийг эд материалын хохиролтой осол, харин 11.2 хувийг хүн гэмтсэн осол эзэлж байна. Хүн гэмтсэн ослын 74.3 хувь, эд материалын хохиролтой ослын 91.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. 2018 оны эхний 7 сарын байдлаар улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 163 хүний амь нас хохирсон байна. Ослын 76 хувь нь орон нутгийн замд бүртгэгдсэн. Орон нутгийн замд гарч буй осол нь дийлэнхдээ жолооч аюулгүй байдлыг хангаагүйгээс үүдэлтэй гардаг.

Улаанбаатар хотод бүртгэгдсэн зам тээврийн ослын 91.0 хувь нь мөргөлдөх, 6.7 хувь нь явган хүн дайрах хэлбэртэй байхад орон нутагт 63.6 хувь нь мөргөлдөх, 18.2 хувь нь онхолдох хэлбэртэй байна.

Хүний амь нас хохирсон ослыг сараар авч үзэхэд, 7 дугаар сард хамгийн их бүртгэгдсэн нь тухайн сард хүмүүс амралт, аялал, зугаалгаар хөдөө, орон нутаг руу их явдагтай холбоотой байх талтай.

Зам тээврийн ослын шалтгааныг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

- Жолоочийн буруутай үйлдэл
- Явган зорчигчийн буруутай үйлдэл
- Замын нөхцөл
- Техникийн гэмтэл

Улсын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын 97.5 хувь нь жолоочийн буруугаас, 2.4 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 0.1 хувь

нь замын нөхцлөөс болсон бөгөөд өмнөх оны мөн үеэс жолоочийн буруутай үйлдлийнх 0.2 хувиар нэмэгдэж, явган зорчигчийн буруутай үйлдлийнх 0.2 хувиар буурч, замын нөхцлөөс болсон осол өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Жолоочийн буруутай үйлдлээс бүртгэгдсэн ослын голлох шалтгааны эзлэх хувийг харуулбал:

- Хажуу хоорондын зай тохируулаагүйгээс - 43.4 %
- Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн -15.3 %
- Эгнээ байр буруу эзэлсэн – 14.8 %
- Ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн – 8.2 %
- Хурд хэтрүүлсэн – 2.3 %
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон -2.2 %

Жолоочийн буруутай үйлдлийн улмаас бүртгэгдсэн ослын шалтгаан Улаанбаатар хот болон орон нутгийн замд ялгаатай байна. Үүнд:

Улаанбаатар хотод Орон нутаг Хажуу хоорондын зай тохируулаагүй-48.6% Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон- 20.2%, Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн-16.5% , Зогсоох арга хэмжээ аваагүй - 16.3%,Эгнээ байр буруу эзэлсэн- 16.5%,Хажуу хоорондын зай тохируулаагүй-9.9%,Ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн 8.3%,Хурд хэтрүүлсэн-9.1%, Зогсоох арга хэмжээ аваагүй - 2.1% Ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн -9.0%, Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон-2.0% Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон-8.5%Бусад-6.0%, Бусад-27.0%

Явган зорчигчийн буруутай үйлдлээс гарах осол дараах шалтгаантай байдаг. Үүнд:

- Явган хүний гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөнгарах,
- Гэрлэн дохио зөрчиж зам хөндлөн гарах,
- Ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх
- Зогсож буй автомашины урдуур буюу автобуснаас буугаад урдуур нь замын зорчих хэсэгт орох,
- Замын зорчих хэсэг дээр буюу зорчих хэсгийн захаар дагаж явах,
- Согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замын зорчих хэсгээр явах, хэвтэх,
- Замын голоор тавьсан тусгаарлах хайс, хашлага дээгүүр давах, доогуур нь шургах,
- Замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжгүй оролцох /зам хөндлөн гарахдаа гар утсаар ярих, захиа бичих, чихэвчний хөгжим сонсох/,
- Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах /Эцэг, эх, асран хамгаалагчийн буруугаас/ зэргээс автомашинд дайрагдах, мөргөгдөх.

-Явган зорчигч гэж замаар явган яваа /зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаагаас бусад/ хүнийг хэлнэ.

-Замын хөдөлгөөнд оролцогч гэж замаар яваа жолооч, явган зорчигч болон тээврийн хэрэгслээр зорчигчийг хэлнэ. Явган зорчигч жолоочийн нэгэн адил замын хөдөлгөөнд оролцогч юм.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 88.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Нийт явган зорчигчийн буруутай үйлдлээс бүртгэгдсэн ослын 32.9 хувийг явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоны улмаас, мөн сургуулийн өмнөх насны хүүхдийг

харгалзах хүнгүй замын хөдөлгөөнд оролцуулсанаас болсон осол 7.3 хувийг эзэлж байна.

Замын нөхцлөөс гарах ослын голлох шалтгаан нь: Замын гадаргуу, нөхцөл, замын гэрэлтүүлэг, замын тэмдэг, тэмдэглэгээ ойлгомжгүй байснаас Замын нөхцлөөс шалтгаалан гарсан ослын 59.1 хувь нь Улаанбаатар хотод, 40.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Замын эвдрэл, гэмтэл нь Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол гарах шалтгаан нөхцлүүдийн нэг болдог байна.

Техникийн гэмтлээс шалтгаалсан зам тээврийн осол: Техникийн гэмтэл сааталд жолоочоос хамааралгүй техникийн гэмтэл, тухайлбал жолооны хүрд гацах, тоормос гэнэт барихгүй болох, гэрэл дохионы саатал, хөдөлгүүрийн гэмтэл гэх зэргийг хамруулна. Автомашины техникийн хэм хэмжээ тогтоохдоо замын хөдөлгөөнд оролцогчийн бие болон сэтгэл зүйн дараахь үзүүлэлтүүдийг заавал тооцох шаардлагатай. Үүнд:

- Найдвартай ажиллагаа;
- Ашигтай ажиллагаа;
- Мэдээллийг хүлээн авах чадвар;
- Мэдээллийг боловсруулах чадвар;
- Тосон хариулах чадвар;
- Хөдөлмөрийн чадвар;
- Замын хөдөлгөөнд бэлтгэсэн байдал;
- Хөдөлгөөнд оролцогчийн ухамсар болон ёс зүй

Техникийн гэмтлээс шалтгаалсан зам тээврийн осол 2018 онд бүртгэгдээгүй байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар жил бүр 1.2 сая хүн зам тээврийн ослоор нас барж, 50 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй болох төлөвтэй байна гэсэн үр дүн гарсан байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлыг зөвхөн замын хөдөлгөөнд оролцогчид болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа гэдэг ойлголтоос Монгол Улс татгалзаж, “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам-Орчин” гэсэн өргөн хүрээнд авч үзэх болсон.

Дэлхий дахинд зам тээврийн осол гэмтлийн улмаас жилд 1,2 сая хүн амь насаа алдаж байна. Энэ байдал хэвээр үргэлжлэвэл, зам тээврийн осол нь зүрхний шигдээс, сэтгэлийн дарамтын дараа хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болж байгаа юм.

Иймд НҮБ Ерөнхий Ассемблейн 2010 оны 64/255 дугаар тогтоолоор 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд” болгон зарлаж зам тээврийн ослын улмаас нас баралтыг үндэсний, бүс нутгийн, дэлхийн түвшний үйл ажиллагаагаар 50 хувиар буруулах зорилт дэвшүүлсэн. Монгол Улс “Замын хөдөлгөөний аюулгүй байдлаас үүдэн гарч буй осол хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удаа дараа зохион байгуулсан бөгөөд эдгээр нь ихэвчлэн Замын цагдаа, жолооч нарт хандаж байсан гэж үзэж болохоор байна.

Энэхүү урьдчилан сэргийлэх ажлыг иргэн, албан тушаалтанруу чиглэж зохин явуулбал илүү үр дүн гарах боломжтой юм. Иргэн, албан тушаалтны үүрэг. Үүнд:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэн, албан тушаалтан дараахь үүргийг хүлээнэ:

а/ стандартын шаардлага хангаагүй буюу замын хөдөлгөөний дүрмийн 2 дугаар хавсралтад заасан техникийн гэмтэлтэй, мөн тогтоосон журмын дагуу техникийн улсын үзлэг, тооллогод ороогүй, улсын дугааргүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх;

б/ тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхгүй (жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд) буюу түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулахгүй байх;

в/ гинж, ажлынхаа хэрэгслээр замын хэсэг, бусад элементийг эвдэж болзошгүй трактор, өөрөө явдаг машин, механизмыг хатуу хучилттай замаар явуулахгүй байх;

г/ засмал замд 50 метрээс дотогш хариулгагүй мал, тэжээвэр амьтдыг оруулахгүй байх;

д/ механикжсан тээврийн хэрэгслийг өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш 1 сарын дотор, тээврийн хэрэгслийн марк, зориулалт, өнгө, хөдөлгүүр буюу арлын дугаар өөрчилсөн бол 7 хоногийн дотор замын цагдаагийн албанд бүртгүүлэх.

Зам ашиглалт, хот тохижилтын асуудал эрхэлсэн байгууллагын ажилтан, албан тушаалтан нь зам, төмөр замын гарам буюу замын бусад байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийг холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагын дагуу бүрэн бүтэн байлгах, хэрэв эдгээр нь эвдэрсэн буюу замын гадаргуу мөстсөн зэргээс хөдөлгөөнд аюул учирч болзошгүй үед түүнийг нэн даруй засах, цэвэрлүүлэх арга хэмжээ авна.

Монгол улсад гарч буй осол нь зам мөн тээврийн хэрэгсэл бус иргэдийн мэдлэг боловсрол, соёл, хайхрамжгүй, болгоомжгүй үйлдэл, стресс аливаа нэгэн газар түргэн шуурхай очих хүсэлтэй нь холбоо хамааралтай байж болох юм. Иймд учир иргэдэд зар сурталчилгаа мэдээллийг тогтмол түгээж түгжрэлийг бууруулах алхамуудыг шат дараатай авч ажиллах шаардлага тулгарч байна.

Ингэснээрээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэг нөхцлийг хангана гэсэн үг юм.

Замын цагдаагийн алба нь 2018 онд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гарч болзошгүй эрсдэлээс эрдэнэт хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хяналт шалгалтыг эрчимжүүлэн, Замын хөдөлгөөний дүрэм, Зөрчлийн тухай хууль болон ослын хор уршгийг таниулах, сурталчлах, хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллалаа.

Уг үйл ажиллагааны үр дүнд 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 28 хувиар, ослын улмаас амь нас нь хохирсон хүн 33.7 хувь, гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн 27.5 хувь, амь нас нь хохирсон хүүхдийн тоо 76,9 хувиар, гэмтсэн хүүхдийн тоо 32 хувиар, явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан осол 58.3 хувиар гэх зэргээр тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

2017 оны байдлаар Монгол улсын хэмжээнд 1,153,000 жолооч бүртгэгдэж, 900,000 гаруй тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож, 975 замын цагдаагийн алба хаагч хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд олон улсын жишгээр нэг алба хаагч өдөрт дунджаар

120-150 тээврийн хэрэгсэл шалгах байдаг бол манай улсад нэг алба хаагч өдөрт 1800 орчим тээврийн хэрэгслийг шалгах шаардлага гарч байна гэсэн үг.

Автомашинжилтын түвшингийн зүй тогтлоор 1000 хүнд ноогдох автомашины тоо 30-аас дээш болоход замын нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварыг хангах асуудалд бэрхшээл үүсэх, 130-аас дээш бол тухайн хотын автомашинд хязгаар тавих, 200-250 хүрвэл нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд давуу эрх өгч зөвхөн түүгээр үйлчлүүлэх асуудал тавигддаг. Авто замын түгжрэлийн асуудал ярьж байгаа дэлхийн томоохон хотуудын хувьд 1000 хүнд ногдох суудлын автомашин нь 120-оос дээш байгаа бөгөөд Нийслэлийн хэмжээнд энэ үзүүлэлт 239 байна.

Түүнчлэн тус алба нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээсээ гадна хөдөлгөөний ачааллыг бууруулахад дэмжлэг үзүүлж төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд заасан албан тушаалтан, зочин төлөөлөгчдийн замын хөдөлгөөнд оролцох үед, замын хөдөлгөөнд оролцогчдод аюултай нөхцөл байдал /зам, замын байгууламж эвдэрсэн, байгалийн гамшиг, гал түймэр, халдварт өвчин гэх мэт/ үүссэн үед, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу /баяр наадам, тэмцээн уралдаан, жагсаал цуглаан гэх мэт/ нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах үед, зам тээврийн осол гарсан үед замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор биет зохицуулалт хэлбэрээр хөдөлгөөн зохицуулалт хийж ажиллаж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд иргэдээс цагдаагийн алба хаагчаар биет зохицуулалт хийх бус техник технологи /гэрлэн дохио, хяналтын камер, хөдөлгөөний ачаалал мэдрэгч гэх мэт/ ашиглан зохицуулалт хийж байх талаар саналууд ихээр ирэх болсон.

Улаанбаатар хотын авто замыг 100 хувь гэж авч үзвэл цагдаагийн алба хаагчид 20 хувийг нь хяналтандаа авч, үлдсэн хувийг нь гэрлэн дохио, тэмдэг тэмдэглэлийн дарааллаар зохицуулж хөдөлгөөнд оролцох ёстой байдаг.

Мөн бусад орнуудын цагдаагийн байгууллага ч энэ жишгээр хөдөлгөөн зохицуулалт, хяналт шалгалтын ажиллагааг явуулж байна. Иймд тус албанаас замын хяналтын төхөөрөмж ашиглан хянаж, зохицуулах боломжтой уулзваруудад ажиллаж байгаа алба хаагчдыг шилжүүлэн гудамж, замд хяналт тавих, бусад зам уулзваруудад нэмэгдлээр ажиллуулахаар төлөвлөж байна.

Тухайлбал: БГД-ийн нутаг Өргөө кино театр, Ахуй үйлчилгээний төв, Гэмтлийн эмнэлэгийн баруун урд болон 25-р эмийн сангийн уулзвар, 100 айл, Замын цагдаагийн баруун урд уулзвар, Урбанек төв зэрэг уулзваруудад замын хяналтын төхөөрөмжөөр хөдөлгөөн зохицуулалт хийж, ажиллаж байсан алба хаагчдыг алслагдсан болон бусад гудамж замуудад сэлгэн ажиллуулна.

Зарим уулзваруудыг техник төхөөрөмжөөр зохицуулах хэдий ч байнгын хяналттай байлгах тул иргэд та бүхэн цагдаа ирж зохицуулна гэсэн сэтгэлгээг өөрчилж, хөдөлгөөнд дэг журамтай, сахилга, соёлтой оролцохыг зөвлөж байна.

Орон сууц болон гэр хороолол доторх замын аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ?

Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэмд “Тээврийн хэрэгслийн хурдыг Хорооллын доторх замд цагт 20 км-ээс хэтрүүлэхгүйгээр явна” гэж заасан байдаг.

Сүүлийн үед орон сууц болон гэр хорооллын доторх замд жолооч нар хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжгүй, хурд хэтрүүлсний улмаас

байрныхаа гадаа тоглож байгаа хүүхдүүд, явган зорчигчдыг мөргөж гэмтээх явдал нэмэгдэж байна.

МУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу “Жолооч тээврийн хэрэгслийн хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас тавь хүртэл хувиар хэтрүүлсэн буюу хороолол доторх замд 30 км/ц хурдтай зорчсон бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний арван хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна”, мөн тавиас дээш хувиар хэтрүүлсэн буюу 40 км/ц түүнээс дээш хурдтай зорчсон нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний хорин таван хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг зургаан сарын хугацаагаар хасах шийтгэл оногдуулах” юм.

Иймд орон сууц болон гэр хороолол доторх замын аюулгүй байдлыг хангахдаа:

- Эцэг эх, асран хамгаалагч нар бага насны хүүхдээ үргэлж хараа хяналтандаа байлгах,
- Автомашин ойртон ирж байгаа тохиолдолд гараас нь хөтлөх буюу тэврэх
- Авто замтай ойролцоо бага насны хүүхдийг толлуулахгүй байх,
- Автомашины ард тоглож байгаа хүүхэд таны арын толинд сайн харагдахгүй учир хөдөлгөөн эхлэхээс өмнө аюулгүй байдлыг хангаж эргэн тойрныг сайтар нягталсны дараа хөдлөх,
- Машинаа хөдөлгөхдөө ямар нэгэн анхаарал сарниулах үйлдэл хийхгүй байх. /Тухайлбал: Гараараа даллах, утсаар ярих, яарч сандрах гэх мэт

Иймд бага насны хүүхдүүд сониуч зантай хурдан хөдөлгөөнтэй байдаг учраас зогсож буй машины урд, ардаас гэнэт гүйж гарч ирэх аюултай тул хөдөлгөөний хурдыг зөв тохируулж, анхаарал болгоомжтой зорчихыг зөвлөж байна.

Азийн Хөгжлийн банкны дэмжлэгтэй хэрэгжүүлж буй “ЗХАБ-ын бодлого, төлөвлөгөө боловсруулах” төсөл юм. Энэхүү төслийн хүрээнд өндөр хүчин чадал бүхий 2 сервер, осол гэмтлийн мэдээллийн нэгдсэн сангийн программ, 85 ширхэг тавлет бүхий зүйлийг ЗЦА-нд хүлээлгэж өгч аймаг, дүүрэг дэх замын цагдаагийн тасгуудад тараасан.

Энэхүү тоног төхөөрөмж, сервер нь зам тээврийн ослын шалтгааныг зөв тогтоох, хариуцлагын тогтолцоог бий болгох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тодорхой чиглэлд зохион байгуулахад чухал үүрэгтэйгээс гадна алба хаагчдын ажлыг хөнгөвчлөх, тээвэрлэлтийн үеийн найдвартай, аюулгүй байдлыг хангагдахад гол үүргийг гүйцэтгэдэг юм.

Эдгээр тоног төхөөрөмжийг мөн орон нутгийн замын хяналтын байцаагч, сургалтын төвд олгож байгаа юм. Тоног төхөөрөмжөөс гадна замын цагдаагийн алба хаагч, байцаагч нарын ур чадварыг чадавхижуулах, хөдөлгөөнд оролцогч тээврийн байгууллагууд, жолооч нар, хүүхэд багачууд, иргэдэд зориулсан шаталсан сургалт, мэдээллийг давхар явуулж байгаагаараа үр дүнгээ өгч байна.

Дүгнэлт

Улаанбаатар хотод зам тээврийн осолд өртөж хохирсон хүмүүсийн 58.6 хувийг явган зорчигчид эзэлж байгаа нь хүмүүсийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, мэдсэн ч дүрмээ биелүүлдэггүй байдал, тэдэнд

оногдуулах хариуцлага хэрэгжихгүй байгаагаас амь насаа алдах, бэртэл, гэмтэл авч хохирсоор байна.

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүүхдүүдийн 83.6 хувийг орон нутагт бүртгэгдсэн осол эзэлж байна. Хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай зүйлсийн нэг бол автомашин доторх аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүүхдийн зориулалтын хамгаалах бүс, хамгаалалтын суудал хэрэглэж хэвших явдал юм.

Улаанбаатар хотод зам тээврийн осолд өртсөн хүүхдүүдийн дийлэнх нь явганаар замын хөдөлгөөнд оролцогч хүүхдүүд байгаа нь хүүхдүүдэд замын хөдөлгөөний мэдлэг, замын хөдөлгөөнд зөв оролцох дадал хэвшээгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Иймд сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдүүдэд Замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, замын хөдөлгөөний боловсролыг олгож, зөв оролцох дадлыг багаас нь эзэмшүүлэх шаардлагатай байна. 2018 оны 7 сарын байдлаар зам тээврийн осолд өртсөн жолооч, тээврийн хэрэгслээр зорчигчдын зөвхөн 13.7 хувь нь хамгаалах бүс хэрэглэсэн байжээ. Зам тээврийн осол гарах үед хамгаалах бүс хэрэглээгүй хүмүүсийн 32 хувь нь нуруу, 50-аас дээш хувь нь толгой, нуруундаа гэмтэл авч хамар, эрүү, эгэмний яс хугарч, дух нүүрний хэсэг нь зүсэгддэг байна.

Манай орны зам хангалттай сайн биш байхад замын нөхцлийн улмаас гарсан ослын тоо маш бага байгаа нь замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцлийг тойрох зорилгоор автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан ослын тохиолдлын бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулдагтай холбоотой байна.

Иймд замын нөхцлөөс шалтгаалсан зам тээврийн ослын хохирлыг зам, байгууламжийг хариуцсан байгууллага, аж ахуйн нэгжид бүрэн хариуцуулдаг болговол замын нөхцөл сайжрах нэг нөхцөл болно гэж үзэж байна.

Санал

Нэг саяас дээш хүн амтай, тухайн үндэстнийхээ хүн ам, эдийн засаг, шинжлэх ухааны дэвшил, соёлын чиг хандлагын төв цэг болсон зүрхэн хэсгийг метрополис хот хэмээн нэрийддэг. Тэгвэл Улаанбаатар метрополис хот. Ийм хотын наад захын шаардлага нь замын түгжрэлгүй байх, эрүүл аюулгүй орчинд амьдрах юм. Улаанбаатарт өдөртөө 100 гаруй хүүхэд мэндэлдэг бол өдөртөө 200 орчим авто машин шинээр дугаар авдаг гэсэн албан ёсны тоо баримт байдаг. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах зорилгоор замын цагдаагийн албанаас үргэлж шинэлэг санааг хэрэгжүүлж ажилладаг. Хотын авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд одоо 100 айлын барилгын захуудыг нүүлгэх ажлыг дэс дараатай явуулж байна. Хэрэв нүүлгэчихвэл агаар, хөрсний бохирдлоос эхлээд замын түгжрэл хүртэл мэдэгдэхүйц байдлаар арилна.

Үүнээс гадна Мобиком, Скайтелийн төв болох гар утас худалдааны Тэди, Жи мобайлийн төв, мөн дэргэдэх Монтел худалдааны төвүүдийг нүүлгэх ажлыг хийвэл тухайн бүсийн түгжрэл буурах нь ойлгомжтой. Яагаад түгжрэл үүсч байна вэ гэхлээр бүтэн өдрийн турш хөл хөдөлгөөн ихтэй байдаг газрууд. Жишээ нь гар утасны ганц дугаар, батарей, цэнэглэгч авахын тулд зам дээр машинаа тавьчихдаг. Уг нь Тэди төвийн хувьд 110 машины зогсоолын багтаамжтай.

Гэхдээ ихэнх хэсэгт нь Тэди төвийн ажилчид, алба хаагчид машинаа тавьдаг. Харин үйлчлүүлэгч, иргэд машин тавих зай хомс байдаг. Тэдигийн өмнөх авто машины зогсоолоор өдөртөө 200-300 орчим авто машин үйлчлүүлдэг талаар зогсоолын ажилтны баримт мэдээ байгаа. Авто зогсоолоос гадна тэр хавийн авто замын нэгдүгээр эгнээ, орон сууцны хороолол дундах зам дээр авто машинаа хаячихаад бүтэн өдөржин алга болдог. Мобиком, Скайтел, Жи мобайлийн хувьд 100 айлаас дутахгүй замын түгжрэл бий болдог тул хотын төвийн бүсээс гаргачихад хүндрэл багсана.

Харин Дүнжингарав захын хувьд хотын төвөөс зайдуухан хангалттай хэмжээний авто зогсоолтой үйл ажиллагаа явуулж байна. Тэнд үйлчлүүлж буй үйлчлүүлэгч нарын хувьд түгжрэл хотын төвийг бодвол багатай байна.

Бага тойрууг тойрсон бас нэг түгжрэл байдаг нь Улсын их дэлгүүр. Улсын их дэлгүүр, Номингоор үйлчлүүлэх гэсэн хүмүүс хаа холоос явган ирэхгүй. Дор бүрнээ автомашинтай ирээд зогсоол хайж явдаг. Их дэлгүүрийн зүүн талаас 24 дүгээр сургууль хүртэл байрууд дундах замд ямар нэгэн байдлаар машин зөрөх боломж бараг л байхгүй. Зогсоолгүйн улмаас байрны гадаа машин тавигдахаас өөр сонголтгүй. Нэгэнт Их дэлгүүрийг нүүлгэх боломжгүй тул өмнөх ил зогсоолын талбайг нь ашиглаад давхар граш барьж болох юм. Үйлчлүүлэх хүмүүс нь зогсоолд төлбөрөө төлөөд хэдэн цагаар ч хамаагүй үйлчлүүлэхээр зохицуулах шаардлагатай. Нийслэлийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа 33 агентлагийг Яармаг руу нүүлгэх шийдвэр гарч байгаа ч үүний оронд Тэди, скайтел, зарим нэг түгжрэл үүсгэдэг том том захуудыг нүүлгэх нь зөв санаа байх боломжтой.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ ХАРИУЦЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Н.Цогтбаатар

ХСИС-ийн АШБС-ийн магистрант,

Товч агуулга

Энэ өгүүлэлд Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны өнөөгийн байдал, замын хөдөлгөөний хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэж буй хариуцлага, түүний эрх зүйн орчинд судлаачийн үүднээс товч дүгнэлт хийсэн талаар дурдсан болно.

Түлхүүр үгс: Замын хөдөлгөөн - traffic, Аюулгүй байдал - safety
Хариуцлага - charge, Эрх зүйн зохицуулалт - legislation

Үндсэн хэсэг

Зам тээврийн осол, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ бол гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг юм.

Улсын Их Хурлаас 2008 оны 1 дүгээр сарын 31-нд батлан гаргасан “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” нь хүмүүнлэг иргэний нийгэм дэх монгол хүний хөгжлийг хангах, улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологи, соёл иргэншлийг

эрчимтэй хөгжүүлэхэд чиглэсэн арван дөрвөн жилийн бодлогыг дэлхий нийт, бүс нутгийн хөгжилтэй нягт уялдуулан цогцоор тодорхойлсон юм.

Түүнчлэн Үндэсний цогц бодлогын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд “төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно, хүний эрхийг баталгаатай хангана, нийгэм дэх аюулгүй орчныг бий болгох эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэсэн стратегийн томоохон зорилтуудыг дэвшүүлэн, түүнийг 2007-2021 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байдаг.

Гэтэл өнөөдөр стратегийн томоохон зорилтуудыг хэрэгжүүлж буй байдал нь нийгмийн өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна гэдгийг манай улсын зам тээврийн осол, зөрчлийн статистик тоо мэдээ, учруулсан хор уршгийн хэмжээнээс үзэж болохоор байна.

Тухайлбал, цагдаагийн байгууллагын хэмжээнд 2017 онд 192618 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасны 35212 буюу 18.3 хувь нь Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсан байна.

Улсын хэмжээнд 36591 зам тээврийн осол бүртгэгдсэний 3929 буюу 10.7 хувь нь орон нутгийн замд, 32662 буюу 89,3 хувь нь Улаанбаатар хотын замд гарсан байна.

Нийслэлд бүртгэгдсэн 32662 зам тээврийн ослын 3031 буюу 9.3 хувь нь хүний амь нас, эрүүл мэнд тодорхой хэмжээгээр хохирсон осол байхад 26931 буюу 90.7 хувь нь эд материалын хохиролтой осол байна.

Улсын хэмжээнд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1698 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад улсын хэмжээнд 4,8 хувиар, нийслэлд 15,9 хувийн бууралттай боловч орон нутагт 6,8 хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 507 хүний амь нас хохирч, 1258 хүн гэмтэж, иргэн аж ахуйн нэгж байгууллагад 9 тэрбум гаруй төгрөгийн хохирол учиржээ.

Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон 507 осол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 5,8 хувиар, орон нутагт 12,2 хувиар тус тус өсч, нийслэлд 11.8 хувиар буурсан үзүүлэлт гарч байна.

Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан 431 хүн, зам тээврийн ослын улмаас гэмтсэн 4712 хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрийг авч үзвэл:


Улсын хэмжээнд:

- Явган зорчигч - 122 нас барж, 2359 гэмтсэн
- Жолооч – 133 нас барж, 500 гэмтсэн
- Тээврийн хэрэгслээр зорчигч – 166 нас барж, 1769 гэмтсэн
- Дугуйтай хүн – 8 нас барж, 84 гэмтсэн

Гэмт хэргийн улмаас гэмтсэн 1258 хүний гэмтлийн зэргээс харахад хөнгөн гэмтэл 197 буюу 15.7 %, хүндэвтэр гэмтэл 732 буюу 58.1 %, хүнд гэмтэл 329 буюу 26.2 % нь байна.⁹⁶ Үүнийг графикаар үзүүлбэл:

⁹⁶ Замын цагдаагийн албаны улсын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын тоон үзүүлэлт танилцуулгаас хэсэгчилэн авав.

2017 оны зам тээврийн осолд өртсөн хэлбэр



Дээрхи судалгаанаас харвал дийлэнхи хувь нь зам тээврийн ослын улмаас биедээ хүндэвтэр гэмтэл авч, хөдөлмөрийн чадвараа алдах, цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа нь зам тээврийн ослын хор уршгийг харуулж байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 36591 зам тээврийн ослын 35679 буюу 97.5 хувь нь жолоочийн буруугаас, 868 буюу 2.4 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, замын нөхцөл байдлаас 44 буюу 0.1 хувь нь гарчээ.

Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 15869 буюу 43.4 хувийг хажуу хоорондын зай тохируулаагүйгээс бүртгэгдсэн осол эзэлж байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 868 бүртгэгдсэний 768 буюу 88.5 хувь нь нийслэлд бүртгэгдсэн осол байна. Явган зорчигчийн буруутай үйлдэл дотроо явган зорчигч замын хөдөлгөөнд согтуугаар оролцож өртсөн тохиолдол 32.7 хувийг эзэлсэн байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 32214 буюу 88.0 хувь нь мөргөлдөх, 2523 буюу 6.9 хувь нь явган зорчигч мөргөх, 850 буюу 2.3 хувь нь онхолдох, 670 буюу 1.8 хувь үл хөдлөх зүйл мөргөх, /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн/ 34 осол зорчигч унагах, 85 унадаг дугуйтай хүн мөргөх, 155 осол мал, амьтан дайрах, 60 осол бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.⁹⁷

Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзвэл хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4.8 хувиар буурсан хэдий ч гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 8.0 хувийн өсөлттэй гарсан. Нас барсан хүний дийлэнх буюу 79.6 хувь нь орон нутгийн замд үйлдэгдсэн ослын улмаас амь насаа алдсан байна.

Орон нутгийн замд гарсан ослын хэлбэрээс авч үзэхэд онхолдох хэлбэрээр олон хүний амь нас хохирох, гэмтэх тохиолдол их байна гэж үзэж болно. Түүнчлэн хүүхэд өртсөн зам тээврийн осол улсын хэмжээнд 6.3 хувиар буурсан боловч нас баралт 18.0 хувиар өссөн нь онц ноцтой, хохирол ихтэй буюу хүндэвтэр гэмт хэргийн гаралт ихэссэнтэй холбон үзэж байна.

Монгол улсад 2017 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаан нөхцлөөс харахад жолоочийн буруутай үйлдлээс 97.5 хувь нь бүртгэгдсэн байна. Жолоочийн буруутай үйлдэл дотроо хажуу хоорондын зай тохируулаагүй, эгнээ байр, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, ухрах үйлдэл буруу гүйцэтгэснээс гарсан осол давамгайлж байна. Хурд хэтрүүлсэн болон

⁹⁷ Замын цагдаагийн албаны улсын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын тоон үзүүлэлт танилцуулгаас хэсэгчилэн авав.

согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс шалтгаалсан зам тээврийн осол буурсан үзүүлэлттэй ч орон нутагт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, хурд хэтрүүлсэнээс гарсан осол нилээдгүй хувийг эзэлж байгаа жолооч болон иргэдийн замын хөдөлгөөнд оролцож буй соёл, сэтгэлгээний хандлага ямархуу доод түвшинд байгааг харж болохоор байна.

Өнөөдөр манай улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн, замын хөдөлгөөний аюулгүй байдалд цагдаагийн байгууллагаас тавих хяналт тавих зохих хэмжээнд явж байгаа, түүнчлэн зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой хэмжээний ажил, арга хэмжээ зохион байгуулсаар байгаа боловч яагаад зам тээврийн осол, зөрчил буурахгүй, гарсаар байгаад яагаад анхаарлаа хандуулахгүй байгаа юм, асуудлын гол нь хаана байгааг хэн ч авч үзэхгүй байгаа юм бэ? гэдэгт өгүүлэлийн гол агуулга, ач холбогдол оршиж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан нийт 56 төрлийн үйлдэлд хариуцлага оногдуулахаар хуульчилсан.

Хариуцлагын төрлийг авч үзвэл:

Иргэнд торгох шийтгэлийг 55 төрлийн зөрчилд, баривчлах шийтгэлийг ганцхан төрлийн зөрчилд, эрхийг хасах шийтгэл /нэмэгдэл/ 4 төрлийн зөрчилд оногдуулахаар зохицуулалт орсон байх бөгөөд торгуулийн хэмжээ нь 10-400 нэгж буюу 10.000-400.000 төгрөг байна.

Харин хуулийн этгээдэд зөвхөн торгох шийтгэл оногдуулах бөгөөд 12 төрлийн зөрчилд хариуцлага хүлээлгэхээр заасан байх бөгөөд 100-1000 нэгж буюу 100.000-1.000.000 сая төгрөгөөр торгох зохицуулалттай байна.

Баривчлах шийтгэл оногдуулах зөрчилд тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, зохих журмын дагуу шалгуулахаас зайлхийлсэн бол албадан сургалтанд хамруулж, 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулах зохицуулалттай байна.

Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/187 тоот тушаалаар “Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам” батлагдсан байдаг.

Уг журамд зааснаар жолоочийн зөрчлийн онооны дээд хэмжээ 10 оноо байдаг бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, хор уршгаас хамаарч 1-5 оноо хасна. Харин тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан жолоочийн оноог дууссанд тооцдог байна.

Зөрчлийн оноог 1, 2, 3, 5 оноогоор хасах бөгөөд нийт 18 зөрчилд оноо хасахаар зохицуулсан байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг зөрчсөнөөс зам тээврийн осол гаргасан болох нь эрх бүхий байгууллага, албан тушаалтны хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд 5 оноо хасна.

Зөрчлийн оноо хасах үндэслэлийг дараахь байдлаар тусгасан байна.
Үүнд:

- Тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон жолоочид – 2 оноо;

- Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл хэрэглэсэн этгээдэд жолоог шилжүүлсэн жолоочид – 2 оноо;
- Улсын бүртгэлийн дугааргүй, тогтоосон хугацаанд дугаараа аваагүй буюу дугаараа нуун далдалсан тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцсон жолоочид – 2 оноо;
- Зам тээврийн осолд холбогдсон жолооч Замын хөдөлгөөний дүрэмд заасан үүргээ биелүүлээгүй жолоочид – 2 оноо;
- Хурд хэтрүүлсэн тохиолдолд – 2 оноо;
- Явган зорчигчдод зам тавьж өгөөгүй бол – 2 оноо;
- Замын хөдөлгөөнд оролцохдоо зорчигчид хамгаалах бүс хэрэглээгүй бол – 1 оноо гэх мэт

Жолоочийн бүртгэлийн оноо сэргээх, урамшуулах дараах зохицуулалт байдаг байна. Тухайлбал:

- Зөрчлийн бүртгэлийн оноо хасагдсанаас хойш 1 жилийн хугацаанд дахин зөрчил гаргаагүй жолоочийн хамгийн сүүлд хасагдсан оноог сэргээж, мөн зөрчил гаргалгүй 2 жил өнгөрсөн тохиолдолд 10 оноог сэргээж урамшуулах
- Жолоочийн зөрчлийн оноо дууссан буюу эрх хасагдсан, хуулийн дагуу оногдуулсан торгуулийг заагдсан хугацаанд сайн дураараа төлөөгүй жолоочид урамшуулал хамаарахгүй байх
- Эрх бүхий албан тушаалтан, захиргааны хэргийн шүүхээс торгуулийг хүчингүй болгосон тохиолдолд бичгээр ирүүлсэн шийдвэрийг үндэслэн тухайн хасагдсан жолоочийн зөрчлийн оноог сэргээх
- Зөрчлийн бүртгэлийн оноог хасуулсан жолооч хүсэлт гаргаж, зохих журмын дагуу сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн тохиолдолд зөрчлийн бүртгэлийн 10 оноог сэргээн олгож болох зохицуулалтай байна.

Дүгнэлт

Дээрх бүх зохицуулалтуудыг нэгтгэн авч үзвэл замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, түүнийг тогтоож өгсөн эрх зүйн зохицуулалт тодорхой хэмжээнд бүрэн хангагдсан гэж үзэж болохоор байна.

Гагцхүү хариуцлагын эрх зүйн орчин бүрдсэн ч жолоочдын замын хөдөлгөөнд оролцогчдын сэтгэлгээний сөрөг хандлага төлөвшсөн байдал үүнд нөлөөлж байна гэж судлаачийн хувьд үзэж байна.

Санал

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах, зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Замын хөдөлгөөнд оролцогчдод тавих хяналтыг сайжруулах үүднээс камерын системд орчин үеийн дэвшилтэд техник хэрэгслийг нэвтрүүлэх;
2. Замын хөдөлгөөнд оролцогчдын дүрэм зөрчсөн үйлдлүүдийг төлбөргүй утсаар, нотлох баримтын хамт хүлээн авч хариуцлага хүлээлгэдэг болохын зэрэгцээ зөрчил илрүүлсэн жолоочид урамшууллын 1 оноо өгдөг болох;

3. Зөрчил илрүүлсэн жолооч бус иргэнд уг зөрчил нь нотлогдсон тохиолдолд уг зөрчил гаргасан жолоочид оногдуулж буй торгуулийн мөнгөн дүнгийн 30 хүртэлх хувийг урамшуулал болгон өгдөг болох;

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

СЭТГЭЛ САНААНЫ ГЭМ ХОР БА ТҮҮНИЙГ АРИЛГАХ АСУУДАЛ

Ж.Ууганчимэг

ЭЗНУС-ийн Эрх зүйн онолын тэнхимийн
ахлах багш, ахлах дэслэгч

Товч агуулга

Аливаа улсын улс төр, нийгэм, эдийн засаг дахь өөрчлөлт, шинэчлэл нь эцсийн дүндээ хууль болон эрх зүйн бусад актаар дамжин илрэлээ олдог билээ. Хууль бол нийгмийг хөдөлгөгч хүч. Харин тэрхүү хөдөлгөгч хүчнийг залан жолоодох эсэх тухайн нийгмийн эд эс болсон хүн. Энэ үүднээс нь авч үзвэл эрх зүйт төрийн мөн чанар нь хүнийхээ эрх, эрх чөлөөг хэрхэн баталгаажуулан хамгаалснаас ихээхэн хамааралтай юм. 1992 онд батлагдсан Монгол Улсын шинэ Үндсэн Хуулинд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг ард түмний өмнө тавигдсан эрхэм зорилго хэмээн тунхагласан.

Энэ утгаараа эрх зүйт төрийн хамгийн гол зарчим бол хүний эрх, эрх чөлөөг өндөр түвшинд хангах явдал юм гэдгийг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн явдал юм.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Пакт зэрэг буюу товчхондоо олон улсын Хүний эрхийн Биллд хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангахын зайлшгүй шаардлагыг заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний хувийн амьдрал, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндийг хүний үндсэн эрх, эрх чөлөөний нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлж хамгаалахаар заасан байна. Эрх зүйт төрийн чухал зорилтуудын нэг бол иргэнийхээ зөрчигдсөн эрхийг аль болох шуурхай, шударга байдлаар сэргээх, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх механизмыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх явдал юм.

Иймээс өнөө цаг үед тулгамдсан асуудлын нэг болоод байгаа хүний сэтгэл санааны материаллаг бус гэм хор буюу нэр төр гутаах, гүтгэх гэмт хэрэг үйлдэх явдал, түүнийг арилгах, нөхөн төлүүлэх эрх зүйн харилцааны талаар цогцоор нь авч үзэх шаардлага гарч байна.

Энэ асуудал нь хүний эрх, эрх чөлөөтэй холбогдож туйлын их анхаарал татаж байгаа хэдий ч одоогоор манайд цөөхөн хэдэн судлаачдыг эс тооцвол өөр төдийлөн нухацтай судалсан, хууль тогтоомжид нарийвчлан тусгасан зүйл бага байгаа учраас түүнийг тухайлан авч судлах шаардлага гарч байгаа юм.

Түлхүүр үгс: Нэр төр, алдар хүнд, хохирол, сэтгэл санааны гэм хор, гэм хорын хариуцлага, хүний эрх, эрх чөлөө

Үндсэн хэсэг

Хүний сэтгэл санааны материаллаг бус гэм хор буюу нэр төр гутаах, гүтгэх гэмт хэрэг үйлдэх явдал, түүнийг арилгах, нөхөн төлүүлэх эрх зүйн харилцааны талаар цогцоор нь авч үзэх шаардлага гарч байна. Энэ асуудал нь хүний эрх, эрх чөлөөтэй холбогдож туйлын их анхаарал татаж байгаа хэдий ч одоогоор манайд цөөхөн хэдэн судлаачдыг эс тооцвол өөр төдийлөн нухацтай судалсан, хууль тогтоомжид нарийвчлан тусгасан зүйл бага байгаа учраас түүнийг тухайлан авч судлах шаардлага гарч байгаа юм.

Энэ талаар доктор С.Нарангэрэл “Гэм хор гэж иргэний эрх зүйд иргэний субъектив эрх буюу баялагийг багасгах, устгахыг хэлнэ гэжээ.⁹⁸ Хууль зүйн ном зохиол, шүүхийн практикт “хохирол” гэсэн нэр томъёог хэрэглэдэг. Гэм хор ба хохирол гэсэн нэр томъёо нь хоорондоо яг нийцдэггүй.

Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус гэж хуваагдана.

Эд хөрөнгийн гэм хорын мөнгөн үнэлгээг хохирол гэж нэрлэнэ.

Эд хөрөнгийн бус буюу ёс суртахууны гэм хор гэж бусад этгээдийн хууль бус үйлдлийн улмаас учирсан зан суртахууны ба бие махбодийн зүдгүүр шаналал гэж тодорхойлсон байна.

Харин доктор Д.Наранчимэг: Гэм хор нь иргэний эрх зүйн хариуцлага үүсэх нэг нөхцөл мөн. ⁹⁹Гэм хор нь субъектын амин хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг зөрчсөн явдлаар илэрдэг гээд гэм хорыг материаллаг ба материаллаг бус гэж ангилсан байна. Материаллаг бус гэм хорыг дотор нь: - хүний амь нас хохироосон, - хүний эрүүл мэндийг сарниулсан, -хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж ангилалт хийжээ.Түүнчлэн оросын иргэний эрх зүйн тайлбарт “Гэм хор гэдэг нь аливаа эд хөрөнгийн эрх эсхүл материаллаг бус баялагт халдсан болон зөрчигдсөн байдлыг ойлгоно.

Эд хөрөнгийн бус хохиролыг – бие махбодийн хохирол, - ёс суртахууны хохирол гэж хуваадаг” гэсэн байдаг. Мөн Японы эрх зүйн тайлбарт Гэм хор буюу сэтгэл санааны хохирол гэж зөрчил гаргасан, гэм буруутай этгээдийг шийтгэх зорилгоор гомдол гаргагчид шууд учирсан хохиролоос илүү хэмжээний мөнгөн төлбөр олгох шийдвэрийг шүүхээс гаргахыг хэлнэ.

Үүний үр дагавар болох гэм хор, хохирол нь эд хөрөнгийн бус ”өвчин зовлон” учруулах нэмэлт нөхцөлтэйгээр л нэхэмжлэгчийн алдагдал, зардлыг нотолсны үндсэн дээр тооцогдоно” гэсэн байдаг.Дээр дурдсан тодорхойлолтуудаас харахад гэм хор, хохирол гэсэн ойлголтууд нь агуулгын хувьд давхцаж байгаа нь харагдаж байна.

Харин хууль тогтоомжид энэ талаар тусгасан байдлыг хувьд авч үзвэл: Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хуулийн 227 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно” гэснээс үзэхэд хохирол гэдэгт хохирогчоос зөрчигдсөн эрхээ сэргээхэд буюу эрх зөрчигдөхөөс өмнөх байдалд эргүүлж оруулахад шаардагдах зардал болон эрх зөрчигдсөний улмаас алдсан орлогыг тодорхойлсон гэж болох байна.

⁹⁸ С.Нарангэрэл.”Эрх зүйн эх тайлбар толь” УБ.,2009 он

⁹⁹ Д.Наранчимэг “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” УБ.,1999 он 89-р тал

Иргэний хуулийн 497- 514 дүгээр зүйлд гэм хор учруулснаас үүсэх үүргийн харилцааг зохицуулсан байдаг. Хуулинд “гэм хор” гэсэн ойлголтыг тодорхойлж өгөөгүй байгаа боловч гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь өөрөө гэрээний бус үүрэгт хамаарах учир гэм хор учирсан явдал нь талуудын хоорондын гэрээний бус харилцаанаас үүсэн гарсан эд хөрөнгийн болоод эд хөрөнгийн бус эрх зөрчигдсөний үр дагавар гэж ойлгож болно. Тэгэхээр гэм хор, хохирол гэсэн ойлголтуудыг яг ижил ойлголт гэж авч үзэх нь тийм ч оновчтой биш байна.

2002 онд батлагдсан Иргэний хуулинд энэ ялгааг нэлээд тод гаргаж өгсөн гэж болох бөгөөд уг хуулийн 227 дугаар зүйлийн 4 дахь хэсэгт зааснаас харахад хохирол бол гэрээний үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан материаллаг зардал, олох байсан орлого юм. Харин уг хуулийн 228-229 дугаар зүйлд гэм хорыг арилгах ерөнхий нөхцөл, журмыг тогтоосон бөгөөд өмнөх хуулийн ойлголтоос ялгагдах онцлог нь гэм хор арилгах үүрэг нь талууд хоорондоо гэрээний болон гэрээний бус харилцаанд байгаагаас үл хамааран үүсэхээр заажээ. Мөн хуулийн 230 дугаар зүйлд эдийн бус гэм хорыг арилгах талаар заасан бөгөөд Эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлж болох тухай заасан байна.

Иргэний хуулийн заалтууд болон дээрх судлаачдын тодорхойлолтоос харахад гэм хор гэсэн ойлголт нь хохирол гэсэн ойлголтоос илүү өргөн утгатай бөгөөд түүнийг өөртөө багтаасан ойлголт гэж болох байна.¹⁰⁰ Өөрөөр хэлбэл гэм хор нь шууд материаллаг хохирол болон эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны гэм хор гэсэн төрөлд хувааж болох юм.

Энэхүү ойлголтоор авч үзвэл хүнд учирсан эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг арилгах, нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтын талаар тоймлох шаардлага урган гарч байна. Тухайлбал: Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хорыг арилгах тохиолдол, арга замыг зааж өгсөн. Уг зүйлийн 1 дэх хэсэгт “Бусдын нэр, төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн гэм хорыг арилгасныг үл харгалзан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэж заасан байна.

Өөрөөр хэлбэл нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан, хувийн нууцтай хамааралтай мэдээг өөрийн нь зөвшөөрөлгүй тараасан, иргэнийг өөрийн зөвшөөрөлгүйгээр элдвээр дүрсэлж нийтэлсэн, улмаар олон нийтэд үзүүлсэн тохиолдолд учирсан эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлж болохоор хуульчилсан мөн гэм хорын даатгалыг шинээр оруулсан нь өмнөх зохицуулалтаас илүү нарийвчилсан шинжтэй болсон.

Нөгөөтэйгүүр энд анхаарал татаж буй зүйл бол Иргэний хуулинд “эдийн бус гэм хор” гэдэгт яг юуг оруулж тооцох вэ гэдгийг шууд тодорхой зааж өгөөгүй байгаа асуудал юм. Гэхдээ уг хуулийн 511.1-д зааснаар бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэх тохиолдлыг эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны гэм хор гэсэн ойлголтын бүрэлдэхүүн хэсэгт хамруулан үзэх бололцоотой гэж үзэж болох байна.

¹⁰⁰ Т.Мөнхжаргал “Монгол Улсын Иргэний эрх зүй” УБ.,2014 он 248-р тал

Түүнчлэн эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаар манай хууль тогтоомжинд тодорхой зааж өгөөгүй байгаа нь хууль зүйн практикт уг зохицуулалтыг янз бүрээр тайлбарлах, ойлгож шийдвэрлэх тодорхойгүй байдлыг үүсгэх хандлага байна.

Үүнээс үндэслэн хэлэхэд сэтгэл санааны гэм хорыг манайд гэм хорын тусгайлсан төрөл болгож авч үзэхгүй байгаа бөгөөд харин эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэхэд харгалзан үзэх шалгуур болгохоор хуульчилсан нь ажиглагдаж байна. Нөгөөтэйгүүр энэ нь эдийн бус хохиролд чухам яг юуг хамааруулан ойлгох талаар тодорхойлоогүй нь эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорын ойлголтын талаар маргаантай асуудлыг үүсгэж болзошгүй үр дагавар гаргаж болох байна. Тухайлбал, хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан эдийн бус гэм хороос гадна хүний амь нас хохироосон, хүний эрүүл мэндийг сарниулсанаас хүнд үүсэх сэтгэл санааны хохирлыг хэрхэн үнэлэх, тооцох асуудал бүрхэг байна.

Харин гадаад орнуудын хууль зүйн практикт энэ талаар нэлээд тодорхой авч үздэг байна. Тухайлбал, европт шүүхийн практик болон хуульчдын дунд эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэхтэй холбоотой бүрдүүлвэр асуудлын нэг болох нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэрхэн тодорхойлж ойлгосноос шалтгаалан түүнийг сэргээх, гэм хорыг нь арилгах, нөхөн төлүүлэх аргыг тогтоох боломж бүрддэг.

Юуны түрүүнд Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдолд сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй этгээдэд хэнийг хамруулах вэ гэсэн асуудал чухал. Үүнд иргэн, хуулийн этгээд, эсхүл зөвхөн ганц иргэнийг хамруулах эсэхээ тодорхойлох ёстой. Иймээс нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гэсэн ойлголтуудын ялгааг нь мэдэх нь чухал.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалдагч: Нэр төр, алдар хүнд гэдэг бол хамт олон, нийгэм төрөөс хүний хувьд өгсөн үнэлгээ юм.

Эрх зүйн мэдлэгийн товч толинд: Нэр төр бол бие хүний талаар нийгмийн зүгээс өгч буй тодорхой үнэлэлт бөгөөд түүний нийгмийн бодит шинж юм. Биехүний нэр төрийг түүний үйл ажиллагаа, үйл хэрэг, үзэл бодлоор тодорхойлно.

Алдар хүнд нь бие хүний өөрийн үнэлгээнд илэрхийлэгдэнэ. *Хууль зүйн тайлбар толинд:* Нэр төр гэж хүний нийгэмд эзлэх байр суурь шинж чанар, төлөв байдлыг ёс суртахууны талаас нь илэрхийлсэн үнэлэмж буюу нийгэм эрх зүйн категор. Нэр төр нь хүний төрсөн өдрөөсөө эхлэн зөвхөн өөрт нь заяамал ба салшгүй чанар нь нэр төртэй байх явдал бөгөөд түүнийг хэн ч өөрчлөх, хүчингүй болгох эрхгүйгээс гадна бусдад шилжүүлж болдоггүй.

Ажил хэргийн нэр хүнд гэж иргэн, хуулийн этгээд тухайн эрхлэж буй байгууллага, аж ахуйгаа үр ашигтай эрхлэн хөтөлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүнээрээ тодорхой зах зээл, хэрэглэгчийн хэрэгцээг тогтвортой хангаж, тэдний таашаалыг хүлээх нь тухайн иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг үнэлсэн нийгмийн үнэлэмж юм гэж тодорхойлсон байна.

Олон улсын хүний эрхийн нэр томъёоны тайлбарт хүний нэр төр, алдар хүнд гэж Бүх хүний эрхийн эрх зүй, гүн ухааны үндэс болдог. Хүнд төрсөн цагаас нь заяасан хүний төрлөхийн үнэ цэнэ.

Аливаа улс хүний нэр төр, алдар хүнд, нэр хүндийг хамгаалж, гутаахыг хязгаарласан олон улсын хүний эрхийн стандартыг тогтоож, хүний нэр төр,

алдар хүндийг хүндэтгэх зарчмыг хууль тогтоомжоороо баталгаажуулах ёстой. Хүний эрх нь нэр төр, алдар хүндийг хамгаалдаг. Хүний эрхийн суурь нь нэр төр, алдар хүнд бөгөөд тэр нь бусдаас олгогдоогүй, үүсгэгдээгүй төрлөх чанартай гэсэн байна.

ОХУ-ын эрх зүйн тайлбарт: Нэр төр- хүн төрөхөөсөө үхэх хүртлээ өөртөө өгсөн үнэлгээ

Алдар хүнд – нийгэм, олон нийт тэр хүнийг хэрхэн хүлээн авч буйн илрэл. Харин хувь хүнд хандах хандлага нь нэр хүндээр илэрдэг. Ажил хэрэг, бизнестэй холбоотой хэрэглэгддэг ажил хэргийн нэр хүндийг хүн өөрөө буюу эрхлэн буй ажил, албан байдлаар олж авдаг гэсэн байдаг.

Иймээс дээрх байдлаас үндэслэн дараах дүгнэлтийг хийж болох байна.Нэр төр гэдэг ойлголтыг хуулийн этгээдийн хувьд хэрэглэх боломжгүй бөгөөд хуулийн этгээд нь зохиомлоор бий болгосон бүтэц болохынхоо хувьд өөрийн ухамсар, сэтгэцтэй байх боломжгүй юм.

Хуулийн этгээдийн хувьд ажил хэргийн нэр хүндийг нь гутаасан үед л түүнийг сэргээх талаар ярьж болох бөгөөд учир нь хуулийн этгээд гэдэг нь өөрөө ажил хэрэг явуулах л зорилготой байгуулагддаг ба түүнд зөвхөн ажил хэрэгч шинж чанар л байж болох юм.Иймээс ажил хэргийн нэр хүндийг хөндсөн гэх зөрчлийн үед 3 төрлийн хариуцлага тооцож болох юм. Үүнд:

- Тараасан мэдээллийг няцаах
- Учирсан хохирлыг нөхөн төлөх /материаллаг хохирол
- Сэтгэл-санааны-гэм-хорыг нөхөн төлөх явдал юм.

Харин иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан хэргийн хувьд дээр дурдсан 3 төрлийн хариуцлагыг аль алиныг нь тооцож болох бөгөөд гэхдээ хуулийн этгээдийн хувьд сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх хариуцлага оноох боломжгүй юм.

Хуулийн этгээд өөрийн гэсэн сэтгэл санаа байхгүй, өөрөөр хэлбэл хуулийн этгээд нь сэтгэлийн хөдөлгөөн, бие махбодийн зовлон шаналал амссан байх боломжгүй. Иймд хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдолд худал мэдээлэлд няцаалт, залруулга хийх, эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх гэсэн 2 төрлийн хариуцлагыг тооцож болох байна.

Манай улсын хууль тогтоомжид сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаар шууд заасан заалт байхгүй гэж болох юм. Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Иргэний эрхийг эдийн бус гэм хорыг арилгуулах аргаар хамгаална”, 497 дугаар зүйлд “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэл/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй “ гэж заасан байна. Эндээс харахад сэтгэл санаанд учруулсан гэм хорын талаар дурдаагүй байна.

Харин Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол материаллаг хохирлыг арилгасныг үл харгалзан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэсэн байгаа нь материаллаг хохирлын хажуугаар материаллаг бус хохирлыг нөхөн төлүүлэх бололцоог бүрдүүлсэн гэж болох байна.

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эдийн бус гэм хорын хэмжээг мэдээ тараасан хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр

дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох”-оор зааснаас үзэхэд сэтгэл санаанд учирсан үр дагавар буюу сэтгэл санааны гэм хор нь эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх нэг үзүүлэлт болж байгаа нь харагдаж байна. Иймд манай хууль тогтоомжид заасны дагуу сэтгэл санааны гэм хорыг эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх аргаар арилгаж болох үндэслэл байна.

Эдийн бус гэм хор гэдэгт эдийн бус баялаг, хувийн эрх нь зөрчигдсөн байдлыг ойлгож болно. Эдийн бус баялагт амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, хувийн амьдралын халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц зэрэг орно.

Эдийн бус хувийн эрх гэдэгт оршин суугаа газраа чөлөөтэй сонгох, зохиогчийн эрх, өөрийн нэрийг хэрэглэх эрх зэрэг орно. Эдгээр баялаг, эрхийг эдийн бус гэж тодорхойлох гол шалгуур бол түүнийг бусад этгээдэд дамжуулж болдоггүй, зөвхөн тухайн этгээдэд хамааралтай байдаг онцлогтой юм. Иргэний хуулийн 497 дугаар зүйлд заасны дагуу өөрөөр хэлбэл эд хөрөнгийн болон эдийн бус эрх нь зөрчигдсөн үед гэм хор нөхөн төлүүлэхээр заасан боловч гэм хорын төрлийг нарийн зааглаж өгөөгүй байна.

Эндээс үзвэл үүнд Иргэний хуульд заасан гэм хорын хоёр төрлийн аль алиныг нь ч төлүүлж болохоор ойлгогдож байна. Гэтэл 511 дүгээр зүйлд зааснаас харахад зөвхөн эдийн бус гэм хор учирсан тохиолдолд сэтгэл санаанд учирсан үр дагаврыг харгалзан үзэх талаар заасан байдаг. Үүнээс гадна иргэний хуулийн 511.3 –т заасны дагуу уг хуулийн 21.4, 21.5, 21.6-д заасан зөрчлүүд буюу хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг тухайн иргэний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл, иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүй нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан зэрэг нь мөн эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлүүлэх үндэслэл болох байна.

Нас барсан хүний нэр төр, алдар хүндийг гутаасан тохиолдолд түүнийг нь хэрхэн хамгаалах, эд хөрөнгийн бус эрхийн хэмжээг хэрхэн тогтоох, нэр төр гутааснаас сэтгэл санаанд учирсан үр дагавар гэдэгт юуг ойлгох зэрэг асуудал хууль зүйн зохицуулалтын гадна үлдсэн байна.

Бусад тохиолдолд гэм хорыг хэрхэн арилгах талаар Иргэний хуулийн 52 дугаар бүлэгт тодорхой заасан боловч дээр дурдсан тохиолдоос бусдад нь сэтгэл санааны гэм хорыг хэрхэн нөхөн төлүүлэх талаар нарийвчлан заагаагүй байна.

Энэ байдлаас шалтгаалан шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ төсөөтэй бус, магадгүй өрөөсгөл гэж болохуйц янз бүрээр шийдвэрлэх хандлага байна гэж болох байна. Харин Эрүүгийн хуулинд гэм буруутай нь тогтоогдвол зохих торгууль оногдуулах, тодорхой хугацаагаар баривчлах, хорих ял оногдуулахаар зохицуулсан байна.

Мөн зарим тохиолдолд нэхэмжлэгчээс эд хөрөнгийн бус гэм хорын хэмжээг мөнгөөр үнэлээгүй байх бөгөөд зөвхөн нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд хандсан тохиолдол ч олон бий.

Иргэний эрх зүйд тухайн хүн гэм буруугүй гэдгээ өөрөө нотлох ёстой. Хэрэв нотлож чадахгүй бол гэм буруутайд тооцогдоно. Харин Эрүүгийн эрх зүйд гэм буруутайд үл тооцох зарчим үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, бүрэн төгс

нотлогдож, шийдвэр гараагүй цагт тухайн хүнийг гэм буруутайд тооцох ёсгүй билээ.

Мэдээж дээр дурдсан байдлаас гадна шүүхэд нөхөн төлбөрийн хэмжээг объектив байдлаар тодорхойлох тусгай шалгуур байх ёстой. Тодорхой хэрэг бүрийн тухайд шүүгч тухайн хүний зөрчигдсөн баялгийн ерөнхий үнэлгээ, хууль зөрчигчийн гэм буруугийн хэмжээ, эрх зүйн зөрчлийн үр дагаврын хэмжээ, хохирогчийн амьдралын нөхцөл /албан ажлын, гэр бүлийн, ахуйн, материалын, эрүүл мэндийн байдал, нас/, худал мэдээлэл тараагдсан хүрээ, бие эрхтний гэмтлийн хэмжээ, нас барсан хүн болон нэхэмжлэгчийн төрлийн холбоо, талуудын материаллаг байдал зэргийг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Нөгөөтэйгүүр бас нэг анхаарах томоохон асуудал бол эдийн бус буюу сэтгэл санааны гэм хор учирсан гэх хүн буюу нэхэмжлэл гаргагч маань өөрийн хохирсон гэх үнэлгээгээ мөнгөн хэлбэрээр тооцон нэхэмжлэх, түүнийг нь шүүх хууль хяналтынхан хэрхэн үнэлэн тооцох аргачлал нэн хангалтгүй байгаа болно.

Үүнээс шалтгаалан нэхэмжлэл гаргагчид өөрсдийн тооцолсноор буюу хатуухан хэлэхэд хүссэнээрээ нэхэмжлэлийн мөнгөн хэлбэрээ илэрхийлдэг гэхэд хилсдэхгүй байна.

1.Дотоодод нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлж буй аргачлал
Манай улсын хувьд эд хөрөнгийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох асуудлын талаар Улсын Дээд Шүүхийн Иргэний танхимаас шинэ Иргэний хууль батлагдахаас өмнө буюу 2000 оны 6 дугаар сарын 25-ны өдөр зөвлөмж гаргасан байдаг.

Гэхдээ шинэ Иргэний хуультай төсөөтэй хэрэглэгдэх бололцоотой юм. Тус зөвлөмжид дараах байдлаар эдийн бус гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх аргачлалыг гаргасан байна.

Шүүх эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзана гэдгийг доорхи утгаар ойлгоно.

/хуучин Иргэний хуулийн 392 дугаар зүйл, шинэ Иргэний хуулийн 511 дүгээр зүйл/ Энэхүү аргачлалыг товчхоноор тоймловол:



Мөн уг зөвлөмжид заасны дагуу шүүх эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэхдээ дээрх хуульд заасан нөхцөл байдлаас гадна төлбөр хариуцагчийн цалин, орлого, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хэмжээ, мэдээ тараасан санаа зорилгыг харгалзан үзэж гэм хорын хэмжээг тогтооно гэсэн байна.

Энэхүү зөвлөмж нь шүүхүүдээс иргэдийн эдийн бус гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх, арилгах, сэргээхтэй холбогдсон харилцааг арга зүйн хувьд объектив байдлаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлж байна гэж болох байна.

2.Гадаад орнуудад нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлж буй аргачлал

Гадаад орнуудын хууль зүйн практикаас харахад нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо дараахь шалгуурыг харгалзан үздэг байна.

- гэм хор учруулагчийн гэм буруугийн хэмжээ
- хохирол учирсан этгээдийн хувийн онцлогтой холбоотой бие махбодийн болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ хэмжээ
- бодит нөхцөл байдал болон хохирогчийн хувийн онцлогийг тусгасан бие махбодийн болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ шинж чанар
- шударга ёсны шаардлага зэрэг юм.

Гэм хор учруулагчийн гэм хорын хэмжээ, хуулинд гэм буруу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно гэж заасан нөхцөлд хэрэглэгдэх бололцоотой. “Сэтгэл санааны гэм хор” нь хууль бус үйлдлийн нийгмийн үнэлгээг тусгадаг.

Иймд нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо ёс суртахууны болон бие махбодийн зовлонгийн төрөл /шинж чанар биш/, харин эдгээр эд хөрөнгийн бус гэм хор учирсан баялагийн ач холбогдол шинж чанарыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үздэг.

Ихэнх судлаачдын үзэж байгаагаар бодит сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээ “байж болохуйц сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөр”-ийн хэмжээнээс дөрвөөс илүү дахин хэтрэхгүй байх нь тодорхой төрлийн эрх зүйн зөрчлийн хувьд нөхөн төлбөрийн дээд түвшинг тогтоох бололцоог бүрдүүлдэг гэж үздэг байна.

Түүнчлэн Австрали, Их Британи зэрэг оронд хэн ч нэр төрөө сэргээх нэхэмжлэл гаргаж болно. Гэхдээ шүүхээс дараах үндсэн 4 элементийг хангасан тохиолдолд тухайн гаргаж буй нэхэмжлэлийг хүлээн авдаг байна.¹⁰¹ Үүнд:

- Бодит байдалд нийцээгүй мэдээлэл түгээсэн бол,
- Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол,
- Тодорхой байгууллага, хувь хүний нэр зааж, танигдахаар бичсэн, дүрсэлсэн /гэхдээ заавал шууд тусгахгүй байж болно/ бол ,
- Бодит баримт, болсон үйл явдал дээр тулгуурлаагүй бол гэсэн үндэслэлтэй байх ёстой.

Гэхдээ энэ нь цэвэр онолын асуудал бус, хууль зүйн практик ач холбогдол талаасаа анхаарах зүйл юм. Тухайлбал, дээр дурдсан орны сэтгүүлчид дээрх 4 элементийн хууль зүйн үр дагаварыг мэддэг учраас аливаа материал нийтлүүлэхдээ уг хүрээ, хязгаараас гажихгүйгээр бичиж, нийтэлдэг нь томоохон ололттой тал юм. Манай хэвлэлийнхэн ч энэ талаар мэдээлэлтэй байх нь нэн чухал юм.

Эцэст нь хэлэхэд шүүхээс нэр төр гутаах хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэгчид эрүүл мэнд, сэтгэл санааны гутрал бий болсон эсэх, ашиг орлогын тооцоо, гэм хорын хохирлын хэмжээ, үг хэллэгийн тайлбар зэрэг тусгай мэдлэг шаардсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх боломжийг нарийвчлан зохицуулах нь зүйтэй юм.

¹⁰¹ Ж.Оюунтунгалаг “Харьцуулсан Иргэний эрх зүй” УБ.,2013 он 79-р тал

**ХУУЛЬ ЗҮЙН КЛИНИК СУРГАЛТ ТҮҮНИЙ
ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ**

С.Оюунчимэг

ЭЗНУС-ийн Эрх зүйн онолын
тэнхимийн ахлах багш, ахмад

Товч агуулга

Дэлхий нийтээр эрх зүйн бакалаврын боловсролын чанар, үр нөлөөг дээшлүүлэх гол хүчин зүйл нь хууль зүйн клиник сургалт мөн болохыг хүлээн зөвшөөрөөд байна. Хууль зүйн клиник сургалт нь Хууль зүйн дээд боловсролын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд онолын мэдлэгийг оюутан илүү өөрийн болгож эзэмшүүлэхэд тусладаг төдийгүй оюутныг нийгмийн социаль амьдралд бэлтгэх, дасан зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл хууль зүйн клиник боловсрол нь сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан үйлчлүүлэгчтэй ажиллах замаар хуульчийн ажлын ур чадварт оюутныг сургах зорилготой сургалтын хэлбэр болохыг хөндөж авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Хууль зүйн боловсрол, хууль зүйн клиник сургалт, эрх зүйч, мэргэжлийн ур чадвар, дадлага, туршлага

Үндсэн хэсэг:

Хуульч хүний зайлшгүй эзэмшвэл зохих ур чадварыг оюутнууд сургууль төгссөний дараа, ажилд орсон хойно, практик дээр ажиллаж туршлага суух явцад олж авна хэмээн манай ихэнхи их, дээд сургуулиуд үзэж ирсэн.

Эрх зүйн бакалаврын боловсролын стандартад зааснаар суралцагсад мэдлэг, чадвар эзэмшүүлж, мэргэжлийн үнэт чанарыг төлөвшүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйл нь танхимын сургалтаас гадна хууль зүйн клиникийн сургалт юм

Хууль зүйн клиник сургалт буюу боловсролын талаар авч үзэхээс өмнө боловсрол гэж юу болох талаар авч үзэх нь зүйтэй.

Боловсрол гэдэг бол тусгайлан сургалтаар олж авсан мэдлэгүүдийн нийлбэр ба өөрөөр хэлбэл нийгэм, төр, хүний эрх ашгийн хүрээнд төрөөс тогтоосон боловсролын түвшинд иргэн бүрийг сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг боловсрол гэж ойлгож болно.

Дэлхий нийтээр эрх зүйн бакалаврын боловсролын чанар, үр нөлөөг дээшлүүлэх гол хүчин зүйл нь хууль зүйн клиник сургалт мөн болохыг хүлээн зөвшөөрөөд байна.

Хуульчдыг бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын тогтолцоо, зорилго, сургалтын төлөвлөгөө, агуулгыг үзэхэд дээрхи чиг хандлагыг тодорхой олж харж болно. Үүний улмаас эрх зүйч мэргэжлээр төгсөгчид нь хүмүүст хууль эрх зүйн зөвлөлтөө өгөх, эрх зүйн акт, баримт бичгийн эхийг бэлтгэх, боловсруулах, шүүх хуралдаанд оролцох, мэтгэлцэх, иргэний хэрэгт иргэд, хуулийн этгээдийг төлөөлөн оролцох зэрэг үйл ажиллагаанд мэргэжлийн алдаа гаргах, дутуу дулимаг хандах, дадлага ур чадвар дутагдах тал олонтаа гардаг.

Гэтэл энэхүү ур чадвар, дадал, түүний тодорхой хэсгийг суралцах хугацааны туршид онолын сургалттай хослуулан клиник сургалтын хүрээнд суралцагч бүрт эзэмшүүлж, төлөвшүүлж болно. Ялангуяа эрүүгийн ба иргэний эрх зүй, захиргааны эрх зүйн чиглэлээр оюутанд олгох онолын мэдлэгийг гүнзгийрүүлэн бататгах, иргэний болон эрүүгийн процесс ажиллагаанд оролцох, хууль зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлэх чадвартай болгоход клиник сургалтын гүйцэтгэх үүрэг маш чухал юм.

Эрх зүйн бакалаврын сургалтын хүрээнд оюутан танхимд олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэглэх, хуульчийн мэргэжлийн ажлын ур чадварт суралцан зохих дадал, чадваруудыг эзэмших хэрэгцээ, шаардлагыг хангах нэг чиглэл нь хууль зүйн клиник сургалт. Ийм учраас клиник сургалт дахь салбар эрх зүйн хичээлийг хөтлөн явуулах гол онцлог нь хуульчдын ажил үүргийг хийж гүйцэтгэх практик дадал, ур чадварыг олж авахад нь оюутанд туслахад оршино. Хуульчийн мэргэжлийн ур чадварт:

1.Аливаа асуудлыг шийдвэрлэх бүхий л боломж хувилбарыг бүхий л боломж, хувилбаруудыг урьдчилан харж чаддаг байх

2.Бусдыг сонсож, ярилцаж мэдээлэл авч чаддаг байх

3.Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, хуулийг хэрэглэх ур чадвар эзэмшсэн байх

4.Сэтгэн бодох, харьцуулан үзэх, хэргийн материалыг шинжлэн судлаж, үнэлэлт дүгнэлт өгөх

5.Бусдыг итгүүлэх ур чадварыг эзэмшсэн байх гэх мэт олон зүйлийг хамааруулан үздэг. Хууль зүйн дээд боловсрол нь боловсролын ерөнхий тогтолцооны хэсэг бөгөөд хуульзүйн стандартад зааснаар онолын мэдлэг,практик дадлыг тодорхой хэмжээгээр тэнцвэржүүлэн сургах сургалт юм.

Хууль зүйн клиник сургалт нь Хууль зүйн дээд боловсролын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд онолын мэдлэгийг оюутан илүү өөрийн болгож эзэмшүүлэхэд тусладаг төдийгүй оюутныг нийгмийн социаль амьдралд бэлтгэх,дасан зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Өөрөөр хэлбэл хуульзүйн клиник боловсрол нь сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан үйлчлүүлэгчтэй ажиллах замаар хуульчийн ажлын ур чадварт оюутныг сургах зорилготой сургалтын хэлбэр юм.

Клиник сургалт нь оюутан клиникийн удирдагч-багшийн удирдлага дор хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр тайлбар, лавлагаа өгөх; хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх бэлтгэх; хэрэг маргаантай холбоотой асуудлаар үйлчлүүлэгчээс олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төлөөлөх; хэрэг, маргааныг эвлэрүүлэн зуучлах; хууль тогтоомжоор хориглоогүй хууль зүйн бусад туслалцаа үзүүлэх зэргээр бодит үйлчлүүлэгчтэй ажиллах хэлбэрээр явагдана.

Хууль зүйн клиник сургалт нь сургалтын тусгайлсан орчин, сургалтын хэрэглэгдэхүүний сан, “Уулзалтын өрөө”, “Шүүх хуралдааны танхим” болон сургалтын агуулга, зорилгод нийцсэн орчин, бусад нөхцөлийг бүрдүүлсэн байхыг шаарддаг.

Хууль зүйн клиникийн зохион байгуулалтын хэлбэр

1. Их сургууль/тэнхим/-ийн бүтцэд байгуулсан ХЗКТ
2. Хэд хэдэн их сургуулийн оролцоотой байгуулсан их сургууль дундын ХЗКТ
3. Ашгийн бус хуулийн этгээдийн дэргэд байгуулсан ХЗКТ

4. Төрийн байгууллагын дэргэд байгуулсан ХЗКТ

5. Бусад

Хууль зүйн клиник төвийн үйл ажиллагааны чиглэл

- Нийтийн эрхзүйн чиглэлийн хууль зүйн клиник
- Тусгайлсан чиглэлийн хуульзүйн клиник
- Хязгаарлагдмал чиглэлийн хуульзүйн клиник

Хууль зүйн клиник боловсролын зорилт нь танхимд олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэглэхэд оюутанд гарч буй хийдлийг шийдвэрлэх явдал юм.

Хуулийг мэднэ гэдэг нь түүний үг үсгийг бус, харин түүний учир холбогдлыг нь мэднэ гэсэн үг юм. Тиймээс хууль, түүний дотор иргэний хууль тогтоомжийг хэрэглэж сурах, хуулийн зүйл заалтыг зөв ойлгож дүн шинжилгээ хийх, хэрэг маргааныг шийдвэрлэхэд тэдгээрийг бүрэн дүүрэн ашиглах чадварыг эзэмшүүлэх нь Иргэний эрх зүйн чиглэлийн хичээлийн нэгэн гол зорилго болон тавигддаг.

Энэхүү зорилгыг биелүүлэхэд тухайн чиглэлээр клиник сургалтыг зохион байгуулах нь чухал ач холбогдолтой гэж хувийн эрх зүйн салбарын хичээлүүдийг заадаг багшийн хувьд үзэж байна.

Хууль зүйн клиник ялангуяа иргэний эрх зүйн чиглэлээр клиник сургалтыг дараах хэлбэрээр зохион байгуулж явуулж болох юм. Үүнд:

- 1.Иргэний хууль тогтоомжийг хэрэглэх;
- 2.Нотлох баримтыг бүрдүүлэх;
- 3.Хууль зүйн зөвлөгөө өгөх;
- 4.Иргэний шүүн таслах ажиллагаанд оролцуулах;
- 5.Эрх зүйн бичиг баримтын эхийг бэлтгэх гэх мэт.

Иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх шатанд суралцагсад зохигчдийг төлөөлөх, холбогдох нотлох баримтуудыг бүрдүүлэх, цуглуулах, мөн үйлчлүүлж байгаа иргэдтэй харилцах тэдгээрт хууль зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, өмгөөлөх зэрэг янз бүрийн ажиллагаанд оролцох иргэний төрөл бүрийн хэрэгт биечлэн оролцох зэрэг нь тухайн чиглэлээр явуулж байгаа клиник сургалтын нэг давуу тал юм. Ийнхүү оролцсоноор оюутаны хувьд зохих дадлага туршлага, ур чадвар суух, олж авсан эрх зүйн мэдлэгээ бататгах, шинэ мэдлэг олж авах ач холбогдолтой.

Хууль зүйн клиник сургалтын төвд хандсан үйлчлүүлэгчдийг хүлээн авах, хэргийн бүртгэл хөтлөх, үйлчлүүлэгчээс тавьж буй асуудал, хүсэлтийг судлах шийдвэрлэх арга замыг хайх, хууль зүйн зөвлөлгөө өгөх, эрх бүхий байгууллагад хандах гэх мэт өмгөөлөгчийн үйл ажиллагааг оюутнууд хэрэгжүүлэх нь тэдэнд хуульчийн дадал, хэвшил, зохих чадвар бүрдүүлэхэд онцгой үр нөлөөтэй.

Хууль зүйн клиник сургалтын иргэний эрх зүйн хичээлийг тодорхой зорилго чиглэлтэй бие даасан хэд хэдэн хэсэгт хуваан үзэж болно. тухайлбал:

- a)Лекц
- b)Семинар дасгал
- c)Загварчлал
- d)Дүрд тоглох
- e)Үр дүнг нь тодорхойлох гэх мэт

Клиник сургалтанд хичээлийг лекцийн хэлбэрээр зайлшгүй зохион байгуулах шаардлагатай. Лекцийн зорилго нь оюутан хуульчийн ур чадвар, дадал дүй эзэмшихэд шаардлагатай бүхий л онолын болон практик мэдээллийг өгөхөд оршино.

Танхимын сургалтын өөр нэг хэлбэр нь дасгал, семинарын хичээл байдаг. Энэхүү хичээлийг тухайн клиникийн мэдээллийн бааз суурь, оюутны хөтөлж байгаа иргэний хэрэг маргаанд тулгуурлаж явуулах нь илүү үр дүнтэй, сонирхолтой болдог. Түүнчлэн удирдагч багш нь сэдэв тус бүрээр бодлого, дасгал, бодит тохиолдол, кейс дээр оюутнуудыг багт хувааж ажиллуулах, өөр хооронд нь мэтгэлцүүлэх, асуудал хэлэлцүүлэх аргыг хэрэглэх боломжтой.

Иргэний хэргийг хянан хэлэлцээд шүүхээс гаргасан шийдвэр, тогтоол, захирамж, магадлал, түүнчлэн иргэд, хуулийн этгээдээс гаргасан иргэний нэхэмжлэл, эрх зүйн баримт бичгийг тарааж судлуулах, иргэний шүүх хуралдааны видео бичлэгийг үзүүлэх зэрэг нь Клиник сургалтын загварчлалын аргад хамаарна.

Иргэний хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн дүрд тоглуулах арга замаар иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааг явуулах үйлчлүүлэгчид хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлөх ур чадварыг оюутанд зохих хэмжээгээр эзэмшүүлэх боломжтой.

Эцэст нь дүгнэж авч үзвэл хууль зүйн клиник сургалт бол бодит үйлдлээр дамжуулан хуульчийн мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэх, суралцагчийг аливаа асуудалд шурган оруулах, хийнгээ суралцах, ярилцангаа сурах зарчим дээр тулгуурласан сургалтын хамгийн оновчтой хэлбэр юм.

Монгол Улсад эрх зүйн дээд боловсрол олгох үйл явцад “Хууль зүйн клиник сургалт” хэмээх сургалтын шинэ хэлбэр үүсэж бий болсноос хойш нэлээд хугацаа өнгөрсөн байх ба судлаачдын бүтээлээс үзэхэд Монгол улс дахь хууль зүйн клиникийн сургалтын түүх 1990 оноос эхлэлтэй бөгөөд 1999-2001 оны үед Монголын анхны хууль зүйн клиник сургалтын төвүүд байгуулагдаж, эрх зүйн бакалаврын тогтолцоонд клиник боловсролын эхлэл тавигджээ. Энэ үеэс багш бэлтгэж эхэлсэн төдийгүй хууль зүйн их, дээд сургуулийн дэргэд клиник төвүүд байгуулагдаж, сургалт явуулж эхэлсэн байдаг. 2007 онд Монгол Улсын “Эрх зүйн бакалаврын боловсролын стандарт”-д хууль зүйн сургуулиуд дэргэдээ хууль зүйн клиник төвтэй байх тухай заасан. Улмаар уг стандартад “Хууль зүйн клиник сургалт”-ын тухай нэмэлт өөрчлөлт 2011 онд орсноор манай улсын хууль зүйн их, дээд сургууль бүр дэргэдээ клиник төв байгуулж ажиллахыг заасан болно.

Хууль зүйн сургуулиудын тогтолцоонд клиник сургалт нэвтэрснээр хязгаарлагдмал хүмүүст хувь хүмүүст үйлчилдэг байсан хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа өөрчлөгдөн нийгмийн эмзэг бүг, ядуучууд болон дундаж орлоготой иргэд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй авах боломжийг бий болгосон.

Хууль зүйн клиник сургалтаар оюутанд “юу зааж сургах вэ?” гэдэг нэн чухал юм. Оюутан академик сургалтын зэрэгцээ хуульчийн мэргэжлийн дадлага дүй, туршлагад суралцах нь зайлшгүй бөгөөд энэ нь эрх зүйг хэрэглэж сурна гэсэн үг. Хууль зүйн клиник сургалтыг явуулж байгаа хуулийн их, дээд сургуулиудын өнөөгийн байдлыг судлаж үзэхэд дараахь агуулгаар явуулж байна.

1. Хууль зүйн клиникийн удиртгал
2. Хууль зүйн клиникийн бичиг хэрэг
3. Нийгэм дэх хуульчийн үүрэг, ёс зүйн зарчим, шаардлага
4. Хууль зүйн клиникийн сургалтын интерактив арга зүй
5. Үйлчлүүлэгчтэй ярилцлага хийх арга зүй
6. Хэргийн материалд дүн шинжилгээ хийх арга зүй
7. Хууль зүйн зөвлөгөө өгөх арга зүй
8. Хууль зүйн техник
9. Шүүхийн мэдүүлэг
10. Мэтгэлцээн
11. Маргаан шийдвэрлэх альтернатив аргууд

Манай улсын хууль зүйн клиник сургалт өөрийн гэсэн өвөрмөц онцлогтойгоор зохион байгуулагдаж байна. Үүнд:

Нэгдүгээрт: Хууль зүйн клиник сургалт нь Монгол Улс дахь хууль зүйн туслалцааны тогтолцоонд зохих байр суурь эзэлсэн.

Хоёрдугаарт: Хууль зүйн клиник сургалт нь эрх зүйн бакалаврын боловсролын албан ёсны бүрэлдэхүүн хэсэг болж, өөрийн гэсэн стандарттай болсон.

Гуравдугаарт: Хууль зүйн сургуулийн багш нар клиник сургалтын интерактив аргуудад суралцан, багш, оюутанд зориулсан хууль зүйн клиникийн ном, сурах бичгийг боловсруулж нийтийн хүртээл болгож, сургалт-заах аргын аргачлал тодорхой хэмжээнд бий болсон.

Манай сургуулийн хувьд 2017-2018 оны хичээлийн жилд “Иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх хууль зүйн туслалцааны төв буюу клиник сургалтын төв”-ийг байгуулан түүнийгээ сургалтанд ашиглах болсон нь сайшаалтай бөгөөд цаашид уг төвийг сургалтанд ашиглах явдлыг эрчимжүүлэх, оюутнуудын танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын зарим хэсгийг түүнд тулгуурлан зохион байгуулах нь үр дүнтэй гэж судлаачийн зүгээс үзэж байна.

ГАДААД ХЭЛ ДЭЭР БИЧИГДСЭН ӨГҮҮЛЭЛ НИЙТЛЭЛ

К ВОПРОСУ ПРОФЕССИОНАЛЬНОГО РАЗВИТИЯ МОНГОЛЬСКОЙ ПОЛИЦИИ

МОНГОЛЫН ЦАГДААГИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

Ц.Наранчимэг

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, ЦЭЗТ-ийн
ахлах багш, доктор (Ph.D) цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга

Бидний өнцгөөс боловсролын бодлого, үүрэг нь эцсийн дүндээ бие хүний төлөвшил, хөгжлийг дэмжих, цаашилбал байгууллагын имиж бүрдүүлэх үйл ажиллагаа юм.

Монгол Улсад боловсролын байгууллагуудад боловсрол олгодог уламжлалт арга өөрчлөгдөж насан туршийн боловсролын (суралцагч байгууллага, хөгжиж буй хувь хүн) чиг хандлага хэрэгжиж эхлээд байна. Үүийг цагдаагийн байгууллага, түүний алба хаагчид тойрон гарах аргагүй. Иймээс байгууллагын стратеги, хувь хүний хөгжил-манлайллыг боловсронгуй болгоход хэрэгжүүлэх “5Ш” загварыг (- шинэ философи сэтгэлгээ, - шинжлэх ухаанч хандлага, - шинэлэг үйл ажиллагаа, - шинэ алхам, - шинэ боловсрол-имиж) боловсруулснаа энэхүү нийтлэлдээ авч үзлээ.

Ключевы слова: Формирование личности, непрерывное образование, развитие человека

Полицейские органы и каждый его сотрудник должен хорошо помнить, что граждане платят налоги и организовали полицейские органы, чтобы они защищали их спокойную и мирную жизнь. Далеко позади осталось то время, когда в области борьбы с преступностью полицейские органы не имели конкурентов и занимали главенствующую роль.

Монголия перешла в общество демократии и рынка бесповоротно, и, хотя, полицейские органы обязаны нести ответственность за общественный порядок перед законом, наряду с данной ответственностью в некоторых случаях действуют только для защиты интереса олигархов-политиков, становится их средством защиты.

“По мере развития режима профессиональной работы любой организации Правительства в его структуре происходят глубокие изменения, эффективное сотрудничество значительно ослабевает, впоследствии снижается общая производительность труда и конечный результат становится неясным. В итоге бюрократическую организацию ждет участь ликвидации или рассеивания” так упоминает в своем творчестве “Совершенное Правительство” исследователь R.M.Linden [2, с. 33]. Вышеупомянутое положение наблюдается в нынешнем образе Монгольской полицейской организации.

Разумеется, полицейская организация не может быть вытеснена из общества. Другими словами, хотя полицейский занимает в данной области беспрецедентное монопольное место, неизвестно, сколько это будет продолжаться. За последние годы образованы следственная служба, Управление по борьбе с коррупцией при Прокуратуре, Криминалистико-аналитический Центр, который реализовывает направление и обязанности анализов полицейских органов, стал самостоятельным и независимым агентством, Полицейская Академия стала Университетом правоохранения при Министерстве Юстиции, дальше, решается вопрос отделения службы реализации направления и обязанности в спорте и искусстве, в итоге, в полицейских органах идет процесс разложения.

Полицейские органы перестали соответствовать преобразованиям общественной структуры и изменениям, не стало сотрудников с высоким

образованием и профессиональным навыком, которые являлись основой его существования, люди перестали доверять производительности труда и способности сотрудников и стали резко критиковать [1, с. 3]. Сегодняшние правоохранительные органы, их руководства ведут политику, направленную на преобразование и изменение, чувствуя влияние общества, давление граждан-жителей.

Изменение и преобразование – это такой процесс, где требуется сложный и длинный срок, где необходима грандиозная выдержка со стороны руководства, также требующий усердной работы, и, зависящий от профессиональной способности специалистов [3, с. 16]. К сожалению, в нынешнее время не хватает обоснованно обработанного стратегического планирования политики полицейского образования и плана развития полиции.

По нашим взглядам, политика и задача образования, в конечном итоге, есть деятельность по **оказанию поддержки развитию и формированию личности человека**. Поэтому, содержание образовательной услуги должна быть направлена на поддержку развития и жизнеспособности человека. Формирования личности человека наряду с образованием неразрывно связано с формированием большой системы общества и полицейский периода гуманного и демократического общества должен соответствовать требованиям высокого образования и знания, с чувством гуманности, сострадания, морали, с чувством среды, со способностью самостоятельной жизни, ликвидности, с высокой производительностью труда, обладающий политической культурой, со способностью самостоятельно обучаться, развиваться, с чувством патриотизма и демократизма.

Изменилась наша традиционная тенденция понятия об образовании как об образовании, дающих только в рамках образовательных учреждений, и нами изучено о том, что человек, начиная с самого рождения и до самой своей смерти адаптируется с окружающей средой, обучается и развивается непрерывно.

Это в простой речи и в произведении об изучении образования “Непрерывное образование” понимается и изучается под формулировкой “пожизненное образование” [4. с. 11]. В связи с формированием понятия пожизненного образования среди общества и людей, появился актуальный вопрос о непрерывной системе образования полиции, и среди них - развитие личного состава монгольского полицейского.

Основной элемент непрерывной системы образования является наряду с официальным образованием также и неофициальным образованием. Так как пожизненное образование невозможно обеспечить только официальным образованием, помимо официального образования появилась необходимость развития и неофициального развития.

Если в системе непрерывного развития политику официального образования, содержание, стандарт устанавливается со стороны государства на основе законов, имеет относительно постоянный признак и определяет направление образовательного развития, то в неофициальном образовании содержание, способ и форма имеют свободный характер, имеет множество вариантов, различий, гибкий, относительно открытый, с чувством восприятия

среды, ликвидности, и поэтому продвижение вперед развития образования имеет большое значение.

Из исследований видно, что к реализации непрерывной системы полицейского образования и ее механизмов полицейские органы еще не готовы.

Таковыми причинами являются, с одной стороны, то, что слова, произнесенные из уст начальников являются приказами, с другой стороны, существуют строгие законы, ограничивающие право выборов сотрудников соответствующих личным особенностям.

Поэтому, считаем, что субъекты реализующие руководство полицейского образования должны быть открыты для сотрудников, привлекать по их интересам, потребностям и требованиям обучению, обучать участию коллектива и общества, и нести обязанность помощи за их саморазвитие. В дальнейшем,

1. В данной организации необходима общая политика развития человека, соответствующая новым измененным условиям нынешнего времени. Поэтому необходимо внедрить способы и методы дальнейшего планирования человеческого развития, потребности, спроса, поставки, оценки, формулировки новой политики контроля, принимаемые всем обществом и соответствующие новым условиям.

2. По нашим исследованием видно, что весь полицейский личный состав на высшей, средней и низшей стадиях желают произвести резкие изменения в обучении по квалификации и официальном обучении. Граждане и общество желают того же. Слишком много накопленных проблем и актуальных вопросов в полицейских органах должны решаться не по стадиям, а требуют не теряя времени изменить всей системой.

3. Для нахождения более новых идей, для привлечения как можно больше людей к деятельности перестройки, среди личного состава полицейских органов обмениваться мнениями и предложениями, регулярно организовать обсуждения, диалоги, научно-исследовательские дебаты, конкурсы и соревнования.

Считаем, что полицейскому управлению необходимо оторваться от традиционных методов приказов, реализовать менеджмент поддержки сотрудников, соответствующих их личным особенностям.

4. Обучать и инструктировать сотрудников, находящихся под непосредственным руководством, практиковать, помимо этого организовать механизмы, которые смогли бы реализовать такие обязанности, использовать их с эффективностью. Благодаря этому, развить полицейского служащего как данные от природы талант и профессиональную способность именно для монгольского человека, этим дать им возможность в общественной жизни активное место, в дальнейшем, оказать влияние на усовершенствование общественных отношений.

Поэтому, считаем, что для системы непрерывного образования полицейских органов, направленных для перестройки общественных полицейских услуг, произведения современных тенденции развития менеджментов в соответствии особенностям личности, планирования развития

полицейских, для усовершенствования планов необходимо реализовать следующие задачи:

1. Разработать и развить программу поддержки пожизненного образования (Повысить культуру и имидж организации);
2. Сделать полицейские органы обучающейся организацией;
3. Организация, коллектив, команда, каждый сотрудник – обучающийся, обязан делиться знанием, обязан быть инициатором – в деятельности следовать “5 Н” образцов:

Новая философия и менталитет (внедрение лучших опытов центральных и региональных полицейских органов, также борьбу с преступностью полицейских органов других стран, опыт развития полицейских)

Научная тенденция (всадить метод комбинации теории, практики, традиции, перестройки)

Новейшая деятельность (изучение тенденций развития общества, потребности, требований, изменить форму и качество деятельности)

Новая ступень (В рамках деятельности перестроечного правительства реализовать перестройку деятельности полиции)

Новое образование-имидж (организовав вышеупомянутую деятельность систематически, наряду с реализацией дальнейших задач оказания полицейского образования на новой ступени поднимается уровень авторитета полицейских органов, и реализуется новый имидж перестроечного полицейского органа-личного состава)

Принять мероприятия по организации правил поощрения инновационной деятельности, творческой работы сотрудников;

Организовать систему поднятия карьеры, опорствующей на производительности, также систему оценки званий, организовать механизм справедливой оценки производительности, для этого внести дополнительные изменения в соответствующие правовые акты;

Важное значение для создания полицейских услуг, опирающихся на чувство к изменениям внутренних и внешних сред, подлинные желания граждан и их потребности, занимает повышение стремления, активности и участие сотрудников полицейских органов.

Литература:

1. “Мнение граждан о полиции и о деятельности полицейских сотрудников. Центр исследования Максима. УБ.2008.
2. Цэцэгмаа.Ц. “Менеджмент человеческого ресурса”. УБ. 2009.
3. Пурэвдорж Ч. Менеджмент переподавания. УБ.2011.
4. Пурэвдорж Ч. О методике теории развития и инновации в области образования. УБ.1999.